

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1 Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нийслэл, дүүрэг хариуцан
хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт;

Хан-Уул дүүргээс хариуцан хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2050” бодлогын баримт бичигтэй уялдуулан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

❖ Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 1 дүгээр улиралд тайлагнах нийт 30 тогтоол шийдвэрийн холбогдох 54 заалт (Биелэлт-57.7%); 2024 оны эхний хагас жилд 29 тогтоолын 40 заалт /Биелэлт-61.2%/; 3 дугаар улиралд 29 тогтоолын холбогдох 43 заалтыг тус тус нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн, хугацаанд нь нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар тайлагнах нийт 43 тогтоол шийдвэрийн холбогдох 60 заалтын биелэлтийг нэгтгэн, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэж, тайлагнасан. Биелэлт-92%

ТОГТООЛ, ШИЙДВЭР	ТОО	ЗААЛТ
2024 оны жилийн эцсийн байдлаар		
Монгол Улсын хууль	4	9
Улсын Их Хурлын тогтоол	5	5
Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол	1	1
Ерөнхийлөгчийн зарлиг	3	7
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	1	1
Засгийн газрын тогтоол	21	25
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	5	8
Засгийн газрын албан даалгавар	1	2
Ерөнхий сайдын албан даалгавар	1	1
Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол	2	2
Нийслэлийн Засаг даргын захирамж	6	34
Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл	2	6
Нийслэлийн Засаг даргын албан даалгавар	3	21
НИЙТ	55	122

Тогтоол шийдвэрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил арга хэмжээнүүдээс дурдвал:

Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврыг дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх 17 арга хэмжээтэй төлөвлөгөөг эхний 5 сарын байдлаар 90%-тай хэрэгжүүлж, биелэлтийг 5 дугаар сарын 10-ны 01/902 тоот албан бичгээр нийслэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт цахимаар илгээж, хугацаанд нь тайлагнасан.



Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу дүүргийн Засаг даргын дэргэдэх 27 байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Засаг даргын Тамгын газраас давхардсан дүнгээр нийт 304 арга хэмжээний саналыг тусгуулсан.

Д/д	Хэлтэс, алба, байгууллагын нэр	Засаг даргын Тамгын газраас тусгасан арга хэмжээний саналын тоо
1	Цагдаагийн газар	12
2	Замын цагдаагийн хэлтэс	0
3	Онцгой байдлын хэлтэс	8
4	Татварын хэлтэс	12
5	Улсын бүртгэлийн хэлтэс	4
6	Нийгмийн даатгалын хэлтэс	0
7	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс	16
8	Боловсролын хэлтэс	13
9	Статистикийн хэлтэс	6
10	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс	13
11	Эрүүл мэндийн төв	14
12	Дүүргийн Нэгдсэн эмнэлэг	8
13	Газар зохион байгуулалтын алба	12
14	Худалдан авах ажиллагааны алба	3
15	Дотоод аудитын алба	7
16	Албан бус, насан туршийн боловсролын төв	7
17	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв	13
18	Ахмадын хороо	5
19	Биеийн тамир, спортын хороо	19
20	Соёлын ордон	13
21	“Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ	13

Д/д	Хэлтэс, алба, байгууллагын нэр	Засаг даргын Тамгын газраас тусгасан арга хэмжээний саналын тоо
22	“Хан-Уул Агро” ОНӨААТҮГ	17
23	“Нийтлэг үйлчилгээний алба” ОНӨААТҮГ	17
24	“Усан спорт сургалтын төв” ОНӨУТҮГ	12
25	“Хан-Уул Яармаг” ОНӨААТҮГ	13
26	“Хан-Уул зам засвар, арчлалт” ОНӨААТҮГ	6
27	“Эко ахмадын сувилал” ОНӨААТҮГ	9
28	“Хан эко тээвэр” ААТҮГ	16
29	“Эко хотын тээвэр” ОНӨААТҮГ	16
НИЙТ		304

❖ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III (2020-2024)”-ийн хэрэгжилтийн хүрээнд төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаанд 2024 оны 04 дүгээр сарын 02-ноос 18-ны өдрүүдэд Засаг даргын Тамгын газрын 74, хорооны 75, нийт 149 албан хаагчдыг хамруулж, Засаг даргын дэргэдэх 20 байгууллагад судалгаанд хамруулах тухай 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 03/610 дугаар албан бичгийг хүргүүлсэн.

❖ Монгол Улсын Засгийн газрын “Баг, хорооны Засаг дарга нарыг чадавхжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2023 оны 303 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Удирдлагын академитай хамтран 2024 оны 01 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд 2 өдрийн чадавхжуулах сургалт зохион байгуулж, сургалтад Хан-Уул дүүргийн 21 хорооны Засаг дарга хамрагдсан. Сургалтад оролцогчид хууль, эрх зүй, засаглал, иргэдийн оролцоо, манлайлал, төсөл боловсруулах аргачлал зэрэг сэдвүүдээр мэдлэг, ур чадварыг эзэмшсэн.



❖ Хан-Уул дүүрэгт харьяалагдах аж ахуйн нэгж, байгууллагуудыг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль зэргийг баримтлан Тайлан баланс, Орлого үр дүнгийн тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланг Сангийн яамны шинэчилсэн “E-Balance” нэгтгэлийн программд бүрэн шивүүлж илгээсэн тайланг заасан хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч баталгаажуулан, нэгтгэлийг заавар журмын дагуу тайлагнаж байна.

Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан журмуудын хүрээнд дүүргийн 99 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж 27,981,1 сая төгрөгийн данс бүртгэлд тусгаж, хяналт тавьж ажилласан.

Худалдаа, үйлчилгээний чиглэлээр:

“Зөвшөөрлийн тухай хууль”, “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, сурталчлах зорилгоор 4 удаагийн сургалт уулзалтад хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй давхардсан тоогоор 725 аж ахуйн нэгжийг хамруулж, аж ахуйн нэгжүүдэд



тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэн, дээд шатны байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлж, мэргэжил арга зүйгээр хангасан. Мөн хууль тогтоомжийг сурталчлах, аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох шат дамжлагыг ойлгомжтой болгох зорилгоор 800 ширхэг гарын авлага бэлтгэн, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн.


❖ Дүүргийн Засаг даргын дэргэдэх худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 10 удаагийн хурлыг зохион байгуулж, тамхи худалдах зөвшөөрөл хүссэн 107 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хэлэлцүүлж, 85 иргэн, аж ахуй нэгжид тамхи худалдах зөвшөөрөл олгосон. Зөвшөөрөл олгохоос татгалзсан 22 иргэн, аж ахуйн нэгжид хариу тайлбарыг хүргүүлж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1467 дугаар захирамжаар 18 нас хүрээгүй хүүхдэд электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглосонтой холбогдуудан худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 324 гаруй газарт захирамжийг хүргүүлж, 250 газарт Цагдаагийн газар, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэстэй хамтран хяналт шалгалт зохион байгуулсан

❖ Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Эрх шилжүүлэх тухай” А/219 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2024 оны А/460 дугаар захирамжаар согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр хүссэн 336 аж ахуйн нэгжийн хүсэлтийг магадлан шалгаж, ажлын хэсгийн 17 удаагийн хурлаар хэлэлцүүлж, стандарт шаардлага хангасан 452 аж ахуйн нэгжид дүүргийн Засаг даргын 17 удаагийн захирамжаар спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгосон. Дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаагаар үйлчлэх болон худалдах тусгай зөвшөөрөл шинээр хүссэн аж ахуйн нэгжийн 280 хүсэлтийг магадлан шалгаж, ажлын хэсгийн 5 удаагийн хурлаар хэлэлцүүлж, стандарт шаардлага хангасан нийт 149 аж ахуйн нэгжид спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх болон худалдах тусгай зөвшөөрөл олгосон. Стандарт шаардлага хангаагүй аж ахуйн нэгжүүдэд тухай бүр холбогдох мэдээллийг хүргэсэн.



❖ Электрон тамхины хор хөнөөлийн талаар 2 төрлийн постер бэлтгэн, Хан-Уул дүүргийн “Хан-Уул Эко дүүрэг” цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтэд мэдээллэж, 15600 гаруй хүнд хүрсэн байна. Электрон тамхины хор уршгийг ЕБС-ийн сурагчдад байнга таниулах ажлыг зохион байгуулах талаар албан бичгийг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй сургуулийн удирдлагуудад хүргүүлж, тайлан мэдээг нэгтгэн ажиллаж байна.



❖ “Өсвөр үеийн эрүүл мэндийг хамгаалах, электрон тамхины хэрэглээг бууруулах” сэдэвт сургалтыг Ерөнхий боловсролын сургуулийн 161 сурагчдад дүүргийн Цагдаагийн газар, Эрүүл мэндийн төв, Боловсролын хэлтэс, Биеийн тамир спорт хороотой хамтран зохион байгуулсан. Мөн 3 төрөлт спорт өдөрлөг арга хэмжээг Ерөнхий боловсролын 10 сургуулийн 100 сурагчдын дунд зохион байгуулж, электрон тамхины хор уршгийг сурталчлан ажилласан.



Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

- Мал эмнэлгийн үйлчилгээ, хяналтын чадавхыг сайжруулах зорилгоор мал эмнэлгийн 3 нэгжтэй ажил үйлчилгээг гүйцэтгүүлэх гэрээг шинэчлэн байгуулж гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.
- 2024 оны эхний хагас жилийн байдлаар Мал эмнэлгийн 3 удаагийн арга хэмжээг мал эмнэлгийн тасагтай хамтран зохион байгуулж, Засаг даргын нөөцөөс 18 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд олгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
- Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан буюу <https://livestock.mofa.gov.mn/> цахим системд 2023 оны мал, тэжээвэр амьтны тооллогоор тоологдсон 781 өрхийн 46,919 мал болон хорогдсон 2,681 малыг мэдээллийн санд шивэх ажлыг ажлыг зохион байгуулсан.
- Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад давхардсан тоогоор 270,944 мал, амьтан хамрагдаж, 92.1 хувь, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 2 удаагийн дархлаажуулалтад 9,607 бог малыг хамруулж, хэрэгжилтэд тавьж ажилласан.
- Дүүргийн Засаг даргын 2024 оны А/125, А/225 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, ариутгал халдваргүйтгэл хийх ажлыг дүүргийн мал эмнэлгийн тасаг, Тохижилт үйлчилгээний төвтэй хамтран зохион байгуулж, 3,389 ширхэг мал, амьтны сэг зэмийг устгаж, 23,000м2 талбай бүхий хашаа хороо, худаг, уст цэг, малын бэлчээр, хогийн цэгт ариутгал халдваргүйжүүлэлт хийж, ажилласан.



Тохижилт, ногоон байгууламжийн чиглэлээр:

"Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд "Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяныг хавар, намар 2 удаа зохион байгуулж, нийт 206419 ширхэг мод тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Тухайлбал:

Хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр гэр хорооллын бүсэд 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16 дугаар хорооны 1650 хашаанд гоёлын болон жимсний 7 төрлийн 16,575, 104 СӨХ, 11 сургууль, цэцэрлэг, 10 хорооны гадна нийт 125 байршилд гоёл чимэглэлийн 7767, аж ахуйн нэгж, байгууллагууд орчиндоо 16,872, нийт 41214 ширхэг мод, бут сөөг, тарьсан.

Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд арчилгаа, нөхөн тарилт хариуцсан 10 байгууллага 19289 ширхэг мод, бут сөөг тарьсан.

Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, тоосжилтыг бууруулах ажлын хүрээнд 1, 3, 15 дугаар хороонд 9848 м.кв талбайг зүлэгжүүлсэн.



Тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн 14 дүгээр хорооны Айцын аманд нийслэл, дүүргийн 38 хэлтэс албадын 645 албан хаагч 2022-2024 онд байгуулсан 12.3 га талбайд усалгаа, арчилгаа хийж, нэмэлтээр болон нөхөн тарилтаар 3196, Ногоон хэрэм төслийн талбайд Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын харьяа агентлагууд, төрийн захиргааны төв байгууллагууд 9175, Богдхан уулын дархан цаазат газрын Түргэний ам, Зайсангийн ам, Нүхтийн ам, Энхтайвны ам, Ихтэнгэрийн аманд 136 га талбайд уул уурхайн 5 компани, улсын хөрөнгө оруулалтаар 1 компани ойжуулалтын ажил хийж, 133,545 ширхэг, нийт 145916 ширхэг мод, бут, сөөг тарьсан байна.

Зураг . Хан-Уул дүүргийн 14-р хороо Айцын аманд байрлах ойн төгөл




Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/97 дугаар захирамжаар Айцын ам, Төгсөгчдийн төглийн 13.5 га талбайн арчилгааг Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т хариуцуулан гэрээ байгуулж, хяналт тавьсан. “Ногоон хот – Иргэний оролцоо” мод тарих аяны нээлтийн арга хэмжээг 2024 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Айцын аманд зохион байгуулж, нийслэлийн нутгийн захиргааны болон дүүргийн Засаг даргын дэргэдэх 56 хэлтэс албадын 646 албан хаагч оролцож, 2022, 2023 онд мод тарьсан 12.3 га талбайд бордоотой цэнэг усалгаа хийж, 966 мод, бут сөөг тарьсан.

Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ 2024 оны 05 дугаар сарын 11- 27-ны өдрүүдэд Айцын амны 12.3 га, 13 дугаар хорооны Төгсөгчдийн төглийн 1.2 га талбайд тарьсан мод, бут сөөгийг 57 удаагийн рейсээр 399 тн усаар усалсан.



Зураг . Хан-Уул дүүргийн 14 хороо Айцын аманд байрлах ойн төгөл

Хот, нийтийн аж ахуйн чиг үүрэг дүүрэгт шилжсэнээр дүүргийн Засаг даргын 2024 оны А/157, А/269 дүгээр захирамжийн дагуу 295,148 м.кв талбайн арчилгааг мэргэжлийн 10 байгууллагад, нэмэлтээр Эрчим хүчний яамны урд талын зам дагуу 3500 м.кв талбай бүхий ногоон байгууламжийг Цэцэгт ногоон хөндий ХХК-д хариуцуулж, агро технологийн 22 ажилбарын дагуу арчилгааны ажилбарыг гүйцэтгүүлж, хяналт тавьж ажиллаж байна. Ногоон байгууламжийн арчилгааны ажлын гүйцэтгэлийн захиалагчийн хяналтыг 2024 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн Бид байгаль элч ТББ-д хариуцуулан ажиллаж байна.



Зураг. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламжийн арчилгаа хариуцсан талбай

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 02 дугаар албан даалгаврын хүрээнд:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/125 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт орчны бохирдлыг бууруулах хаврын их цэвэрлэгээний аяныг 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл зохион байгуулсан.

Дүүргийн нутаг дэвсгэрт хуримтлагдсан хур хог, малын өтөг бууц, сэг зэмийг ариутгаж, халдваргүйжүүлэн ачиж тээвэрлэх ажлыг дүүргийн мал эмнэлгийн 3 байгууллага, дүүргийн мал эмнэлгийн тасаг, “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлсэн.

Тус ажлын хүрээнд 8, 10, 12, 13, 14, 16, 21 дүгээр хороодын нутаг дэвсгэрт хорогдсон нийт 3389 ширхэг мал, амьтны сэг зэмийг устгаж, 12,000 м.кв талбай, 11,000 м.кв талбай бүхий хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлтийг дүүргийн мал эмнэлгийн тасгийн хяналт дор “Ганган буга” ХХК, “Туда” ХХК, “Гүнд тэрэм” ХХК-ууд хийж гүйцэтгэсэн.



Зураг . Малын сэг зэмийг ариутгаж, халдваргүйжүүлэх ажлын явц

Мөн 23 байршилд үүссэн 5258.14 тонн үүсмэл болон хур хог хаягдал, ариутгаж халдваргүйжүүлсэн малыг сэг зэм, өтөг бууцыг “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ нь хог тээврийн 13 хово автомашин, 2 автоковшоор нийт 18 хүний бүрэлдэхүүнтэйгээр цэвэрлэж, цуглуулан 264 рейсээр Морингийн төвлөрсөн хогийн цэгт хүргэж ажилласан.



Зураг . Хур болон үүсмэл хог хаягдал, малын өтөг бууц, сэг зэмийг цуглуулж, тээвэрлэх явц

Дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 21 дүгээр хурлын шийдвэрийн дагуу “Хан-Уул Агро” ОНӨААТҮГ 15 дугаар хорооны Ривер вилла хотхоны урд хэсэгт Дунд голд унасан гүүрийг татан гаргаж, голд хуримтлагдсан 8 тонн хог хаягдлыг цэвэрлэн орчны бохирдлыг бууруулж ажилласан.



Зураг . Дунд голд унасан гүүрийг гаргаж, хог хаягдлыг цэвэрлэсэн байдал

Хөдөө, аж ахуйн чиглэлээр:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 4 удаагийн нэгдсэн арга хамжээ зохион байгуулж, 19.1 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан. Үүнд:

- Малыг асуудал хариуцсан 4 ажилтанг ажиллуулан ажлын цаг ашиглалт, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

- Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд орж ирсэн 98 иргэний 1827 тооны адууг эздэд нь хүлээлгэн өгч, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу 1 иргэнд 3 сая, Зөрчлийн тухай хуулиар 2 иргэнд 250, 18 иргэнд тус бүр 1 сая, нийт 17.5 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээг тус тус авсан.

- Шинэчлэгдэн батлагдсан тогтоолыг мал бүхий хороодын 450 иргэнд танилцуулах уулзалт, сургалтыг зохион байгуулсан.

- Малчин, мал бүхий иргэд малаа байнгын хариулгатай зөвшөөрсөн бүсэд бэлчээхийг анхааруулсан зурагт хуудас, видео шторкийг дүүрэг хорооны цахим хуудсуудад байршуулсан иргэдэд сурталчлан ажилласан.

“Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах, түүнтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэх журам”-ын 2.3-т заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлын хэсэг, удирдамжийг дүүргийн Засаг даргын 2024 оны А/453 дугаар захирамжаар баталж, сонгон шалгаруулалтыг 2 удаа зарласан.

Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд малаа нэвтрүүлсэн тохиолдолд иргэдээс ирүүлсэн зураг, бичлэг, нийтийн эзэмшлийн зам талбайн хяналтын камерын бичлэгийг үндэслэн Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч байгаа тул малчин, мал бүхий иргэд малаа байнгын хариулгатай зөвшөөрсөн бүсэд бэлчээхийг анхааруулсан зурагт хуудсыг дүүрэг хорооны цахим хуудсуудад байршуулсан иргэдэд анхааруулан ажилласан.



1.2 “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх 3 бүлэг, 9 зорилт, 11 арга хэмжээ эхний улиралд 47%, хагас жилийн байдлаар 66,25%, гуравдугаар улиралд 2 зорилго, 7 зорилт 8 арга хэмжээ 70%, хяналт шинжилгээ, үнэлгээний 5 шалгуур үзүүлэлт эхний улиралд 44%, хагас жилээр 55%, гуравдугаар улиралд 60%, 2020-2023 оны 4 жилийн хэрэгжилтийг нэгтгэхэд дунджаар 98%.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОВЧОО

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй /100/	Тодорхой үр дүнд хүрсэн /70-100/	Эрчимжүүлэх шаардлагатай /30-70/	Үр дүнгүй /0-30/	Биелэлт /хувь/	Шалгуур үзүүлэлтэд тусгасан арга хэмжээ	Үнэлгээ /хувь/
Тав. Ногоон хөгжлийн бодлого	1	1	1	1	-	-	-	100%	1	100%
Зургаа. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	1	6	7	1	3	3	-	65,7%	4	50%
Нийт арга хэмжээний дундаж	2	7	8	2	3	3	-	70%	5	60%

Таван жилийн үндсэн чиглэлийн 1 бүлэг, 2 зорилт 4 арга хэмжээ хагас жилээр 50%, гуравдугаар улиралд 77,5%, хяналт шинжилгээ, үнэлгээний 1 шалгуур үзүүлэлт 100%, 2021-2024 оны 4 жилийн хэрэгжилтийг нэгтгэхэд дунджаар 95%,

МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ХАН-УУЛ ДҮҮРЭГ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОВЧОО

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй /100/	Тодорхой үр дүнд хүрсэн /70-100/	Эрчимжүүлэх шаардлагатай /30-70/	Үр дүнгүй /0-30/	Биелэлт /хувь/	Шалгуур үзүүлэлтэд тусгасан арга хэмжээ	Үнэлгээ /хувь/
Ес.Улаанбаатар ба дагуул хот	1	2	4	1	3	-	-	77,5%	1	100%

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 1 бүлэг, 1 зорилт, 2 арга хэмжээ эхний улиралд 50%, хагас жилээр 75%, гуравдугаар улиралд 85%, хяналт шинжилгээ, үнэлгээний 1 шалгуур үзүүлэлт эхний хагас жилд 65%, эрчимжүүлэх шаардлагатай байсан бол гуравдугаар улиралд 85%, тодорхой үр дүнд хүрсэн бөгөөд сар бүр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнд хугацаанд нь илгээж тайлагнасан. Жилийн эцсийн тайлан нэгтгэгдэж байна.

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ХАН-УУЛ ДҮҮРЭГ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй /100/	Тодорхой үр дүнд хүрсэн /70-100/	Эрчимжүүлэх шаардлагатай /30-70/	Үр дүнгүй /0-30/	Биелэлт /хувь/	Шалгуур үзүүлэлтэд тусгасан арга хэмжээ	Үнэлгээ /хувь/
Тав. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	1	1	2	1	1	-	-	85%	2	85%

1.3 “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан 5 бүлэг, 9 зорилт 47 арга хэмжээ эхний улиралд 63%, хагас жилд 74%, гуравдугаар улиралд 84%, жилийн эцсийн байдлаар 92%, хяналт шинжилгээ, үнэлгээний 3 бүлгийн 35 шалгуур үзүүлэлт эхний улиралд 60%, хагас жилээр 34 шалгуур үзүүлэлт 64%, гуравдугаар улиралд 78%, дөрөвдүгээр улиралд 85% тодорхой үр дүнд хүрсэн.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Бүлэг	Нэг. “Ковид-19” хүндрэлийг даван туулах бодлого	Хоёр. Хүний хөгжлийн бодлого	Гурав. Эдийн засгийн бодлого	Дөрөв. Засаглалын бодлого	Тав. Ногоон хөгжлийн бодлого	Нийт дүн
Зорилго	1	4	1	1	2	9
Зорилт	2	12	2	1	4	21
Арга хэмжээ	4	29	4	1	9	47

Үр дүнтэй /100/	2	18	3		9	32
Тодорхой үр дүнд хүрсэн /70-100/		10	1	1		12
Эрчимжүүлэх шаардлагатай /30-70/		1				1
Үр дүнгүй /0-30/						
Үнэлэх боломжгүй	2					2
Үнэлгээ /хувь/	100%	93%	98%	70%	100%	92%

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОВЧОО

Бүлэг үнэлгээ /хувь/	Хоёр. Хүний хөгжлийн бодлого	Дөрөв. Эдийн засгийн бодлого	Тав. Ногоон хөгжлийн бодлого	Нийт дүн
Зорилго	4	1	2	7
Зорилт	10	1	4	16
Арга хэмжээ	27	1	6	34
Үр дүнтэй /100/	18		4	22
Тодорхой үр дүнд хүрсэн /70-100/	5	1	2	8
Эрчимжүүлэх шаардлагатай /30-70/	3			3
Үр дүнгүй /0-30/				
Үнэлэх боломжгүй	-			1
Үнэлгээ /хувь/	88%	70%	97%	85%

Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлээс Хан-Уул хамтран хэрэгжүүлэх 3 арга хэмжээ эхний улиралд 47%, хагас жилээр 63%, гуравдугаар улиралд 73%, хяналт-шинжилгээ, үнэлгээний 3 шалгуур үзүүлэлт эхний улиралд 47%, хагас жилээр 63%, гуравдугаар улиралд 73%, дөрөвдүгээр улиралд 90%, 2021-2024 оны 4 жилийн хэрэгжилтийг нэгтгэхэд дунджаар 90%,

НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2024 ОНЫ БИЕЛЭЛТ

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй /100/	Тодорхой үр дүнд хүрсэн /70-100/	Эрчимжүүлэх шаардлагатай /30-70/	Үр дүнгүй /0-30/	Биелэлт /хувь/	Шалгуур үзүүлэлтэд тусгасан арга хэмжээ	Үнэлгээ /хувь/
Ес.Улаанбаатар ба дагуул хот	3	3	3	2	-	1	-	83%	3	90%

Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнөөс Хан-Уул хамтран хэрэгжүүлэх 15 арга хэмжээ эхний хагас жилийн байдлаар 51%, гуравдугаар улиралд 77%, жилийн эцсийн байдлаар 95,7% тодорхой үр дүнд хүрсэн. Хяналт шинжилгээ, үнэлгээний 3 шалгуур үзүүлэлт эхний хагас жилээр 43%, жилийн эцсээр 67%, бөгөөд нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнд хугацаанд нь илгээж тайлагнасан.

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ХАН-УУЛ ДҮҮРЭГ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Бүлэг Үнэлгээ /хувь/	Гурав. Эдийн засгийн бодлого	Тав. Ногоон хөгжлийн бодлого	Зургаа. Нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлого	Нийт дүн	Шалгуур үзүүлэлтэд тусгасан арга хэмжээ
Зорилго	1	3	1	5	3
Зорилт	1	4	2	7	3
Арга хэмжээ	1	12	2	15	3
Үр дүнтэй /100/	1	7	1	9	1
Тодорхой үр дүнд хүрсэн /70-100/		5	1	6	
Эрчимжүүлэх шаардлагатай /30-70/					2
Үнэлэх боломжгүй					
Үнэлгээ /хувь/	100	92,3	95	95,7%	67%

Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 23 зорилго, 108 зорилт, 151 арга хэмжээ эхний хагас жилд 57,8%, гуравдугаар улиралд 73.5%, жилийн эцсийн байдлаар 87,4%, хяналт шинжилгээ, үнэлгээний 164 шалгуур үзүүлэлт хагас жилийн байдлаар 63%, гуравдугаар улиралд 74%, жилийн эцсийн байдлаар 90%, тодорхой үр дүнд хүрсэн.

Бүлэг	Зорилго	Арга хэмжээ	Үр дүнтэй /100/	Тодорхой үр дүнд хүрсэн /70-100/	Эрчимжүүлэх шаардлагатай /30-70/	Үр дүнгүй /0-30/	Үнэлэх боломжгүй	Үнэлгээ /хувь/
Эко дүүрэг-Ногоон хөгжил	4	25	12	6	5	2	0	77.1%
Эрүүл дүүрэг-Хүний хөгжил	4	36	24	4	3	1	4	90.4%
Төрийн үйлчилгээг-Иргэн бүрт	4	18	13	3	0	1	1	91.2%
Нийгмийн хөгжил-Өрх бүрт	5	38	20	10	4	1	3	85.0%
Дэд бүтцийн хөгжил-Хороо бүрт	6	34	23	7	2	0	2	93.4%
Дүн	23	151	92	30	14	5	10	87.4%

Тайлангуудыг тухай бүр удирдлагад танилцуулж, үр дүнгүй болон хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг эрчимжүүлэх тухай хяналт шинжилгээ үнэлгээний ажлын 2024/02, 2024/03 дугаар зөвлөмжүүдийг холбогдох хэлтсүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021-2024 оны 4 жилийн хэрэгжилтийг нэгтгэхэд 151 арга хэмжээ болон 164 шалгуур үзүүлэлт тус тус 91%-тай хэрэгжиж тодорхой үр дүнд хүрсэн байна.

Бүлэг	Эко дүүрэг- Ногоон хөгжил	Эрүүл дүүрэг- Хүний хөгжил	Төрийн үйлчилгээг- Иргэн бүрт	Нийгмийн хөгжил-Өрх бүрт	Дэд бүтцийн хөгжил-Хороо бүрт	Дүн
Зорилго	4	4	4	5	6	23
Арга хэмжээ	25	36	18	38	34	151
Үр дүнтэй (100)	16	27	13	22	26	104
Тодорхой үр дүнд хүрсэн (70-100)	7	5	3	11	5	31

Эрчимжүүлэх шаардлагатай (30-70)	1	2		4	2	9
Үр дүнгүй (10-30)		1	1	1		3
(0) Хэрэгжээгүй	1	1				2
Үнэлэх боломжгүй			1		1	2
Үнэлгээ /хувь/	90.2	88.1	91.8	88.2	94.2	91.0

Хан-Уул дүүргийн хэмжээнд гэр хорооллын 12 хороо (4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16, 23 дугаар хороо)-ны нутаг дэвсгэрт сайжруулсан шахмал түлшний 45 борлуулалтын цэгээр 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл 15341 өрхийг 132800 тн, 2024 оны 09 дүгээр сарын 15-наас 11 дүгээр сарын 23-ны өдөр хүртэл 4060 тн сайжруулсан түлшээр хангасан.

Дүүргийн хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16, 23 дугаар хороодод 45 сайжруулсан түлшний борлуулалтын цэг ажиллаж байна. Хан-Уул дүүргийн хэмжээнд гэр хорооллын 12 хороо (4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16, 23 дугаар хороо)-ны нутаг дэвсгэрт сайжруулсан шахмал түлшний 45 борлуулалтын цэгээр 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл 15341 өрхийг 132800 тн, 2024 оны 09 дүгээр сарын 15-наас 11 дүгээр сарын 23-ны өдөр хүртэл 4060 тн сайжруулсан түлшээр хангасан.



Дүүргийн хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16, 23 дугаар хороодод 45 сайжруулсан түлшний борлуулалтын цэг ажиллаж, Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 9, 10, 12, 13, 21 дүгээр хорооны 6 агуулахад 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 10120 тн сайжруулсан түлш нөөцөлсөн.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1313, Хан-Уул дүүргийн 2024 оны 01 дүгээр



захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд утааны эх үүсвэрийн улсын тоо бүртгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 06-наас 02 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд явуулсан. Тус тооллогоор 3-15 кВт хүчин чадалтай зуухтай 14039 зуух, 15-100 кВт хүчин чадалтай зуухтай 1209 өрх, аж ахуйн нэгж, байгууллага, 100-4200 кВт хүчин чадалтай уурын халаалтын зуухны байгууламжийн 22 аж ахуйн нэгжийн 41 зуухыг тоолж, цахим мэдээллийн санд оруулсан.

Дээрх мэдээллийг 2022 оны тооллогын дүнтэй харьцуулбал, 3-15 кВт хүчин чадалтай зуухны яндангийн тоо 2189-өөр буурсан, 100-4200 кВт хүчин чадалтай уурын болон усан халаалттай зуухны байгууламжийн тоо 12-оор буурсан буюу 4 аж ахуйн нэгжийн 12 зуух татан буугдсан байна.



Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1030 дугаар захирамжийн хүрээнд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгөөр 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14-р хорооны зорилтот бүлгийн 103 өрхийг угаар мэдрэгчээр хангасан.

Нийслэлийн Экологийн цагдаагийн алба, дүүргийн онцгой байдлын хэлтэс, Таван



толгой түлш ХХК-ийн хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хамтран “Шалгавал эрсдэлгүй” арга хэмжээг дүүргийн хэмжээнд сар бүр зохион байгуулж, угаартах эрсдэл бүхий 8, 9, 12, 13, 14 дүгээр хорооны 234 айлд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.



"Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, зөв галлагааны чиглэлээр зөвлөмж мэдээлэл хүргүүлэх ажлыг 11, "Галлагаандаа анхааръя" аяныг 2 удаа зохион байгуулж, 15 хорооны 15248 өрхийг хамруулсан бөгөөд 6 төрлийн 72000 ширхэг гарын авлагыг иргэдэд хүргэсэн.

Европын холбооны Switch Asia хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй гэр хорооллын хувийн сууцыг дулаалж, дулаан алдагдлыг багасгах “Дулаан шийдэл” төслийн хүрээнд Жэрэс ОУТББ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газартай хамтарч ""Хялбар шийдэл""

аяныг өрнүүлж, дүүргийн 8, 9, 10, 13, 16 дугаар хорооны 50 байшинтай өрхийн дээвэр дулаалах, өрх толгойлсон 50 эмэгтэйчүүдийн байшингийн хаалга, цонхыг дулаалсан.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтарч өвөлжилтийн бэлтгэлийн хүрээнд агаарын бохирдлыг бууруулах, байгальд



ээлтэй дэвшилтэт техник, технологийг сурталчлан таниулах “Ногоон технологи” үзэсгэлэн арга хэмжээг 2024 оны 09 дүгээр сарын 17,18-ны өдөр зохион байгуулж, нийслэлээс өгсөн чиглэлийн дагуу гэр хорооллын 15 хорооны 273 иргэд 15 аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулсан.

Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр:

Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй, зохистой хэрэглээний талаар хэрэглэгчдийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зөв дадлыг хэвшүүлэх зорилгоор 4 удаагийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж 426 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. Үүнд.

1. "Хүнс эрүүл бол хүн эрүүл" сургалт;
2. Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл худалдааны техникийн зохицуулалтыг хангуулах нь сургалт;
3. Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтад хяналт тавих нь сургалт;
4. “Өсвөр үеийн эрүүл мэндийг хамгаалах, электрон тамхины хэрэглээг бууруулах” сэдэвт өдөрлөг, арга хэмжээ, сургалт;



“Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт ил задгай зөвшөөрөлгүй худалдаа, үйлчилгээ явуулж буй иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулах тухай” Засаг даргын Тамгын газрын даргын болон дүүргийн менежерийн 2 удирдамжийг батлуулан ил задгай, зөвшөөрөлгүй худалдаа, үйлчилгээ явуулж буй иргэдийн үйл ажиллагаанд НХХААГ, НЭМГ, НМЭГ, ЦХ-тай хамтран хяналт шалгалтыг зохион байгуулж, холбогдох үүрэг чиглэл өгч, мал эмнэлгийн ариун цэврийн магадлан шинжилгээний дээж авах ажлыг зохион байгуулсан. Цагдаагийн газраас давхардсан тоогоор 45 иргэнд 900 нэгжийн торгуулийн арга хэмжээ авч, зөвшөөрөлгүй худалдаа үйлчилгээг тухай бүр зогсоон ажилласан.



Нөөцийн махны худалдааг хүнсний дэлгүүр, сүлжээ 41 дэлгүүрээр жижиглэнгээр 37.2 тонн, өргөтгөсөн худалдаагаар 172.1 тонн нийт 209.3 тонн махыг худалдаалах ажлыг зохион байгуулж, махны чанар аюулгүй байдалд хяналт тавьж, иргэдийн гомдол санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ажиллаж байна.



Төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа болон жижиглэн худалдааг давхардсан тоогоор 5 байршилд зохион байгуулж, нийт 30 газар тариалан эрхлэгчийн 97.2тн төмс, хүнсний ногоог худалдан борлуулж, 143.3сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжлэг үзүүлэн, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан ажилласан.



Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам дагуу эрүүл ахуйн шаардлага хангаагүй орчинд зөвшөөрөлгүй хүнсний ногооны ил задгай худалдаа эрхлэгчдэд НХХААГ, Цагдаагийн газар, Замын цагдаагийн хэлтэстэй хамтран хяналт шалгалтын ажлыг 2 удаа зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан.



Батлан хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд:

Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас “Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг олон талт арга хэлбэрээр зохион байгуулж, цэргийн сургалт бэлтгэлийг чанаржуулах замаар бэлэн байдлыг дээшлүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс, Батлан хамгаалах хууль, тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын Батлан Хамгаалах зарим чиг үүргийг нийслэлд төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээ зэрэг бодлогын баримт бичгийг үндэслэн Цэргийн штабын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 16 арга хэмжээ төлөвлөж, 97 хувьтай хэрэгжсэн.

Цэргийн бүртгэл:

Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны “Цэргийн бүртгэл явуулах тухай” А/331 дүгээр журмыг удирдлага болгон Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/687 дугаар захирамжаар нийслэлийн хэмжээнд цэргийн бүртгэлийн ажлыг зохион байгуулсан.

Цэргийн бүртгэлийг дүүргийн хүн амын тоо бүртгэлтэй нягт дүүргийн цэргийн бүртгэлийн дүнг 2023 оны жилийн эцсийн хүн амын статистик суурин мэдээтэй харьцуулсан судалгаагаар гаргаж, Е-Монголиа системээр дамжуулан 7705 иргэний хүсэлтийг баталгаажуулсан.

Дүүргийн хэмжээнд цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлыг хэсэг 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 19-ний өдрүүдэд томилогдон ажиллаж иргэний оролцоогүй цаасан суурьтай болон цахимаар 48179 хүнийг бүртгэж, дүүргийн 2023 оны жилийн эцсийн статистик суурин хүн амын тоотой харьцуулахад 93,9 хувийн хамралттай байна.

Цэргийн бүртгэлийг 2024 оны журмын дагуу зохион байгуулж, мэдээлэл, сурталчилгааг мэдээллийн олон сувгийг ашиглан, дүүргийн хэмжээнд нэг стандарт, загварын дагуу зохион байгуулсан.

2024 ОНД ЦЭРГИЙН БҮРТГЭЛД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ТОО 0,1 ХУВИАР ӨССӨН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ БАЙНА.

Д/д	2022	2023	2024
Хувь	91.2	93.8	93.9



Батлан хамгаалахын сайдын, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт:

Монгол Улсын Засгийн газрын Батлан Хамгаалах зарим чиг үүргийг нийслэлд төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээнд 5 бүлэг 37 нэр төрлийн ажил, үйлчилгээ тусгагдсанаас хагас жилийн байдлаар гэрээний биелэлт 99.8 хувьтай хэрэгжсэн.

Цэрэг татлага, халалтын талаар:

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/399, А/1116, А/1227 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын А/181, А/611, А/652 дугаар захирамжийн дагуу Ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн байрыг түшиглэн 2024 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс 05 дугаар сарын 06-ны өдрүүд, 10 дугаар сарын 18-ны өдрөөс 25-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжийн дагуу 2024 оны нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион байгуулж, дүүргийн 25 хорооны Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нартай цэрэг татлагын бэлтгэл ажил, зохион байгуулалтын талаар сургалт, семинар зохион байгуулан цэрэг татлагаар орох хорооны хуваарь, зарлан дуудах мэдэгдэл тараасан хүний тооцоо, зарлан дуудах мэдэгдэл тараах талаар хорооны хэсгийн ахлагч нарт өгөх заавар танилцуулан Зэвсэгт Хүчний Жанжин Штаб болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас ирүүлсэн тоон даалгаврыг биелүүлэх талаар чиглэл өгсөн.

Зохион байгуулалтын талаар:

Дүүргийн 25 хорооны Засаг дарга, зохион байгуулагч нартай цэргийн зарлан дуудах мэдэгдлийн эцсийн тооцоог хийн, цэрэг татлагын боломжийг шинэчлэн гарган цэрэг татлагын байрны эрүүл мэндийн үзлэгт хамрагдах иргэдийн мэдээг холбогдох байгууллагуудад танилцуулан ажилласан.

Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгээр орох иргэдийн нарийн шинжилгээ, цээжний рентген зураг зэргийг нэг дор төвлөрүүлэн цэрэг татлагын байрын материаллаг баазыг түшиглэн авч, амбулаторийн эмч сувилагч нарыг ажиллах нөхцөл бололцоогоор хангаж, түргэн шуурхай зохион байгуулсан.

Цэрэг татлагын явцын талаар:

Нийслэлийн Засаг даргын захирамж болон Хан-Уул дүүргийн Засаг даргын захирамжаар 2024 оны нэгдүгээр болон хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар дүүргийн Ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн байранд зохион байгуулж, цэрэг татлага явуулахаас 3 хоногийн өмнө Нийслэлийн Цагдаагийн газраас ирүүлсэн хэргийн учир мөрдөгдөж байгаа иргэдийн нэрийн жагсаалтыг дүүргийн Цагдаагийн хэлтсийн цахим сантай тулгалт хийж, хариуцсан албан тушаалтнаар гарын үсэг зуруулан мөн нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Эрүүл мэндийн газрын диспансерын хяналтад байгаа иргэдийн нэрийн жагсаалтыг дүүргийн Эрүүл мэндийн төвөөр дамжуулан хүлээн авч, Цагдаагийн болон эрүүл мэндийн байгууллага хяналт тогтоон ажилласан.

Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4 дэх заалтыг үндэслэн 2024 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар 18-25 насны цэргийн үүрэгтнүүдээс ар гэрийн гачигдлын шалтгаанаар 57, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар 63 өргөдлийг иргэдээс хүлээн авч цэрэг татлагын товчооны эрүүл мэндийн үзлэгээр оруулж, Цэргийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийг үндэслэн ээлжит цэрэг татлагаас түр чөлөөлж шийдвэрлэсэн.



Хугацаа дуусгаж халагдсан дайчдыг хүлээн авч, байнгын болон түр ажлын байранд зуучилсан талаар:

Хугацаат цэргийн албанд 2023 оны нэгдүгээр ээлжээр татагдаж Хилийн ба Дотоодын цэргийн ангиудаас хугацаа дуусган халагдаж ирсэн дайчдыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр дүүргийн Соёлын төвд хүлээн авч дүүргийн Хөдөлмөр халамжийн хэлтэстэй хамтран Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний анхан шатны шүүх, Төрийн тусгай хамгаалалтын газар, Цагдаагийн газар, ААНБ-ын хүний нөөцийн мэргэжилтнүүд 45 ажлын байранд санал болгож, байнгын болон түр ажлын байранд 10 дайчдыг зуучилсан.



Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг 2024 оны байдлаар дүүргийн Засаг даргын 2024 оны А/56 дугаар захирамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг 6 байгууллагын 18-50 насны 226 цэргийн үүрэгтний нэрийн жагсаалт /4 дүгээр маягтаар/ авч, 80 хувийг хамруулснаас 22 хувь нь зөрчилтэй байсан. Байгууллага, аж ахуйн нэгжид цэргийн үүрэгтний үзлэг шалгалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу явуулснаар иргэний цэргийн зөрчил буурч байна.



1974-1997 онд төрсөн 26 иргэнд цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр тогтоосноос **14** иргэн төлбөр төлж, **6,506,591** төгрөгийг нийслэлийн Төрийн санд төвлөрүүлсэн.

Үр дүн: Байгууллага, аж ахуйн нэгжид цэргийн үүрэгтний үзлэг шалгалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу явуулснаар иргэний цэргийн үүргийн зөрчил буурч, Батлан хамгаалах багц хуулиудыг байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, албан хаагчдад сурталчилснаар иргэнтэй холбоотой харилцааг зохицуулсан зүйл заалтууд, түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгүүдийн талаарх мэдлэг дээшилсэн.

Цэргийн дүйцүүлэх албыг биеэр болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан талаар:

Цэргийн албаны тухай хуулийн 29.3-д заасны дагуу хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 1994-1998 онд төрсөн 140 иргэнээр 183,933,308 (зуун наян гурван сая есөн зуун гучин гурван мянга гурван зуун найман) төгрөгийг Нийслэлийн төрийн сангийн 100200000984 тоот дансанд төвлөрүүлэн хууль тогтоомжийн дагуу 27 иргэнийг мөнгөн төлбөрөөс чөлөөлөн тэмдэглэл хөтлөн ажилласан.

№	Он	2023	2024
1	Мөнгөн төлбөр тогтоосон	192 иргэн	140 иргэн
2	Мөнгөн төлбөр төлсөн	Нийслэлийн Төрийн сангийн 100200000984 тоот дансанд 192 иргэний 230,384,855 төгрөг төвлөрүүлсэн.	Нийслэлийн Төрийн сангийн 100200000984 тоот дансанд 140 иргэний 183,933,308 төгрөг төвлөрүүлсэн.
3	Мөнгөн төлбөрөөс чөлөөлөгдсөн	27 иргэн	27 иргэн

Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа байдал:

Цэргийн албаны тухай хуулийн 29.3-д заасны дагуу хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 1994-1998 онд төрсөн 200 иргэнээр **266,467,319** (хоёр зуун жаран зургаан сая дөрвөн зуун жаран долоон мянга гурван зуун арван ес) төгрөгийг Нийслэлийн төрийн сангийн 100200000984 тоот дансанд төвлөрүүлэн хууль тогтоомжийн дагуу 41 иргэнийг мөнгөн төлбөрөөс чөлөөлөн тэмдэглэл хөтлөн ажилласан.

№	Он	2023	2024
1	Мөнгөн төлбөр тогтоосон	192 иргэн	140 иргэн
2	Мөнгөн төлбөр төлсөн	Нийслэлийн Төрийн сангийн 100200000984 тоот дансанд 192 иргэний 230,384,855 төгрөг төвлөрүүлсэн.	Нийслэлийн Төрийн сангийн 100200000984 тоот дансанд 200 иргэний 266,467,319 төгрөг төвлөрүүлсэн.
3	Мөнгөн төлбөрөөс чөлөөлөгдсөн	27 иргэн	41 иргэн

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 74 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/535, дүүргийн Засаг даргын 2024 оны А/286 дугаар захирамжаар 2024 онд цэргийн дүйцүүлэх албанд элсэхээр хүсэлт гаргасан 10 иргэнийг цэргийн дүйцүүлэх албанд элсүүлж, цэргийн бэлтгэл сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 03-16-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн байрлалд, нийслэлийн Засаг даргын 2024 оны Цэргийн дүйцүүлэх албаны тусгай үүргийн бэлтгэл шатны сургалт зохион байгуулах тухай А/1085 дугаар, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/637 дугаар захирамжийн дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчидтай 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 11 дүгээр сарын 06-ны өдрүүдэд Нийслэлийн иргэдийн Гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх сургалт арга зүйн төв, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн материаллаг баазыг түшиглэн тус тус зохион байгуулж үүрэг гүйцэтгэх дадлага, цэргийн хэргийн мэдлэг олгосон.



Дүүргийн Засаг даргын 2024 оны А/285 дугаар захирамжаар цэргийн дүйцүүлэх албыг 2022-2024 онд биеэр хааж, хугацаа дууссан 5 алба хаагчдыг халж, цэргийн үүрэгтний үнэмлэхэд тэмдэглэл хийж, хүлээлгэн өгсөн.



Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа байдлыг харьцуулсан:

№	Он	2022	2023	2024
1	Алба хаасан	6	5	5
2	Шинээр элссэн	6	6	10
3	Одоогоор 14 иргэн дүйцүүлэх албыг биеэр хааж байна.			


1.4 Улс, нийслэл, дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалт, зээл тусламж болон өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын төлөвлөлтийн оновчтой байдал, гүйцэтгэл, чанар, үр дүн;

Дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжих 99,310.7 сая төгрөгийн 112 төсөл арга хэмжээ батлагдсан бөгөөд 47 төсөл арга хэмжээ хянагдаж, 34,245.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Үүнээс 99 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж гүйцэтгэгчид 27,981.1 сая төгрөг, 30 төсөл арга хэмжээний 23,022.4 сая төгрөгийн явцын санхүүжилт, газар чөлөөлөлтийн зардал 920.7 сая төгрөг, газрын гэрчилгээ, холбогдох баримт бичиг, дүгнэлт, хөрөнгө оруулалтын ажилтай холбоотой бусад зардал 20.1 сая төгрөг нийт 51,944.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5,836.9 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээ батлагдснаас 2,464.9 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээний гэрээг хуулийн хугацаанд шинээр байгуулж батлуулсан. Бүрэн хэрэгжсэн 3 төсөл арга хэмжээ 738.9 сая төгрөг, 4 төсөл арга хэмжээний 1,698.0 сая төгрөгийн явцын санхүүжилтийг олгосон байна.

Дүүргийн ИТХ-ын 2023 оны 12 сарын 19-ний өдрийн 26 дугаар тогтоолоор батлагдаж, 2024 оны 02 дугаар сарын 29-ний 03 дугаар тогтоол, 4 дүгээр сарын 30-ны 06 дугаар тогтоол, 10 дугаар сарын 04-ний 26 дугаар тогтоолоор тус тус тодотгол хийгдэж орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинээр 116, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр 4 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан.

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын явцын график



Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн онцлох ажлуудаас:

1-Р ХОРОО, 8,18-Р БАЙР ГАДНА ТАЛБAYН ТОХИЖИЛТ,



21-Р ХОРОО, 4 УЛИРЛЫН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАСВАР, ТОХИЖИЛТ



19-Р ХОРОО, 70А БАЙРНЫ БАРУУН ТАЛЫН ТОГЛООМЫН ТАЛБАЙ



15-Р ХОРООНЫ ӨЗМТ-Н БАЙР



Боловсролын салбарын хөрөнгө оруулалт

Санхүүжилтийн эх үүсвэр, Улс,нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт

Зарцуулсан хөрөнгийн хэмжээ: УТХО-30,517.8, НТХО-60,013.8, ДТХО-33,230.8, АХБ-7,386.2 (сая.төг), Хэрэгжилт/үр дүн: 50%

Хан-Уул дүүрэгт 2023-2024 онд гадаадын тусламж, улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр нийт 7840 хүүхдийн суудалтай 12 сургууль, 2570 ортой 16 цэцэрлэг, 1260 суудал, 700 ор бүхий 7 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор баригдахаар төлөвлөгдсөн.

Энэ онд хэрэгжих 12 сургуулийн барилгаас 3, 19 дүгээр хороодод Азийн хөгжлийн банк, улсын төсвийн хөрөнгө оруулалттай тус бүр 320 хүүхдийн суудалтай сургуулийн өргөтгөлийн 2 барилга ашиглалтад орсон бөгөөд үлдсэн 10 сургуулийн барилгын ажлын явц дунджаар 30%, 16 цэцэрлэгийн барилгын ажлын явц 50%, 7 бага сургууль, цэцэрлэгийн ажлын явц 31%-тай хэрэгжиж байна.

1 дүгээр хороо, 240 ортой цэцэрлэгийн барилга 50%



12 дугаар хороо, 10 дугаар сургууль буулган 640 суудалтай сургуулийн шинэ барилга барих ажил 95%-ийн гүйцэтгэлтэй.

4 дүгээр хороо, 145-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга 50%



15 дугаар хороо, 115 дугаар сургуулийн 320 суудалтай өргөтгөл барилга-100%



Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт:

Санхүүжилтийн эх үүсвэр, Улс, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт

Зарцуулсан хөрөнгийн хэмжээ: УТХО-2,722.6, ДТХО-3,818.8, нийт 6,541.4 (сая.төг)

Хэрэгжилт/үр дүн: 50%

Авто замын салбарын хөрөнгө оруулалт:


Санхүүжилтийн эх үүсвэр, Нийслэл, дүүргийн төсөв

Зарцуулсан хөрөнгийн хэмжээ: НТХО-86,020.0, ДТХО-14,329.1 (сая.төг)

Хэрэгжилт/үр дүн: Нийслэлийн зорилтот түвшин: 100%, дүүргийн зорилт: 12,7 км

Хүрсэн үр дүн: 60%

Хан-Уул дүүрэгт 2024 онд нийслэлийн төсвийн 86,02 тэр бум, дүүргийн төсвийн 14,32 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 17 төсөл арга хэмжээний хүрээнд 12,7 км хатуу хучилттай авто зам барихаар төлөвлөсөн.

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ЗОГСООЛ**НИСЭХИЙН ТОЙРГИЙГ ОЛОН ТҮВШИНТ УУЛЗВАР БОЛГОХ АЖЛЫН НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ АЖИЛ****Гудамж, зам, талбайн тохижилтийн чиглэлээр:**

Улсын төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн он дамжин хэрэгжсэн хөрөнгө оруулалтаар 5, 24 дүгээр хороонд 2, шинээр нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1, 13, 14 дүгээр хороонд 3, дүүргийн төсвийн хөрөнгөөр 22 дугаар хороонд 1 байршилд, 21 дүгээр хорооны Дөрвөн улирлын цэцэрлэгт хүрээлэнг засварлаж, шинэчлэх 1, нийт 6 байршилд иргэд амарч салхилах, спортоор хичээллэх боломжтой бичил цэцэрлэгийн тохижилтын ажил хэрэгжиж байна. Үүнд:

1. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 24 дүгээр хорооны Вива сити хорооллын ард Туул гол дагуу тоглоомын талбай, спорт талбай бүхий цэцэрлэгийн тохижилт, улсын төсвийн хөрөнгөөр 5 дугаар хороонд 41 дүгээр сургуулийн баруун талд хэрэгжиж буй цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил бүрэн хэрэгжиж, ашиглалтад орсон.

2. Тохижилт, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтарч 1 дүгээр хорооны Эрэл хотхон, 13 дугаар хорооны 4 дүгээр хэсэг, 14 дүгээр хорооны 156-р сургууль, 300-р цэцэрлэгийн гадна талбайд 3 бичил цэцэрлэгийн тохижилтын ажил хэрэгжиж, ашиглалтад орсон.

3. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар Төгс жигүүр ХХК 21 дүгээр хороонд Дөрвөн улирлын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд 1 хөлбөмбөгийн талбай, хос 3х3 сагсан бөмбөгийн талбай, экстрем талбай шинээр байгуулж, 2 ширхэг 5х5 сагсан бөмбөгийн талбайг засварлаж, шинэчилсэн.

4. Дүүргийн төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул голын эрэг дагуу эрсдэлтэй бүсээс 28 айл өрхийг нүүлгэн шилжүүлсэн 5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулах төлөвлөсөн. Тус ажлын гүйцэтгэчээр "Гарден сити" ХХК шалгарч, загвар зураг төсөл боловсруулаад байна.



Нийслэлийн төсвийн төсвийн хөрөнгөөр 8 дугаар хорооны 118 дугаар сургууль, 12 дугаар хорооны Сонгино 25 дугаар гудамж, 24 дүгээр хорооны Хан богд хотхоны 201-р байрны гадна зэрэг 3 байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулах ажил хэрэгжиж дууссан.





ДТХО, ДОНХС-ийн 900.0 сая төгрөгийн хөрөнгөөр 4, 12, 14, 15, 20, 24, 25 дугаар хороонд 3х3 сагсан бөмбөгийн 7 талбай байгуулах 3 төсөл арга хэмжээ хэрэгжиж дууссан. 2024 оны 11 дүгээр сарын 22-ний өдрийн байдлаар 4 дүгээр хороонд 34 дүгээр сургууль, 25 дугаар хороонд Буянт Ухаа 1 хороололд байгуулах сандал, сүүдрэвч бүхий 2 3х3 сагсан бөмбөгийн талбай, 12, 14 дүгээр хороонд хэрэгжих 2 талбай, 15, 20, 24 дүгээр хороонд хэрэгжих 3х3 сагсан бөмбөгийн талбайн ажил хэрэгжиж дууссан.

Явган хүний зам талбайн засвар шинэчлэлтийн ажлын хүрээнд:

Хан-Уул дүүргийн хэмжээнд 2023-2024 онд 1, 2, 3, 5, 9, 11, 15, 17, 19, 20, 22, 23, 24 дүгээр хорооны 20 байршлын 21,128.1 м.кв (8,5 км) талбайд явган хүний зам засварлаж, шинэчлэх 6 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд жилийн эцсийн байдлаар;

Хэрэгжиж дууссан 3 төслийн хүрээнд 7,500 м.кв (3,0 км):

1. Явган зам, талбайн засвар, шинэчлэлтийн ажил /23, 24-р хороо/ (0.4 км дугуйн замтай)
2. Нийтийн эзэмшлийн зам талбайн засвар, тохижилтын ажил (9, 16-р хороо)
3. Явган зам талбайн тохижилт /1,3, 15-р хороо/



Засвар, шинэчлэлт:

Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн арчлалт, хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд 2024 онд дүүргийн төсвийн 3,393.7 сая төгрөгийн хөрөнгөөр тохижилт, шинэчлэлтийн чиглэлээр 9 төсөл арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс 4 төсөл арга хэмжээ 2023-2024 онд он дамжин хэрэгжих, 5 төсөл арга хэмжээ 2024 онд шинээр хэрэгжиж байна. Үүнд:

Дүүргийн төсвөөр 2024 онд шинээр хэрэгжих (935.0 сая төгрөг):

1. Ардын хувьсгалын 25 жилийн ойн өндөрлөгийн тохижилтын ажил (23 дугаар хороо)
2. 209 дүгээр цэцэрлэгийн гадна тохижилтын ажил (8 дугаар хороо)
3. 65-р байрны тохижилт гадна талбайн тохижилтын ажил (15 дугаар хороо)
4. 7, 89 дугаар сургуулийн спорт талбайн засвар шинэчлэлт (16 дугаар хороо)
5. Дэлгэрэх хотхон, Энхийг сахиулах 50 айлын тоглоомын талбайн засвар шинэчлэлтийн ажил (3 дугаар хороо)

Дүүргийн төсвөөр 2023-2024 он дамжин хэрэгжиж буй (2,458.7 сая төгрөг):

1. Наран хотхон, 8, 18-р байрны гадна талбайн тохижилт, засвар шинэчлэлтийн ажил (1 дүгээр хороо)
2. Ажилчны алдар талбайн тохижилт (2 дугаар хороо)
3. Гадна талбайн тохижилтын ажил (10-р хороо 60/2 дугаар байр, 13-р хороо 144-р цэцэрлэг, 14-р хороо 59-р сургууль)
4. Сагсан бөмбөгийн 3х3 талбай байгуулах (Нисэх яармагийн бүс)

Засвар:

Хүүхдийн тоглоомын талбайн стандарт, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд 1, 2, 3, 4, 8, 10, 13, 14, 17, 19 дүгээр хорооны 21 байршилд тоглоомын талбайг засварлах судалгаа, ажлын тоо хэмжээг гаргаж, дүүргийн Засаг даргын 2024 оны А/203 дугаар захирамжаар Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т хариуцуулж, хяналт тавьж ажиллаж байна. 2024 онд байдлаар 12 тоглоомын талбайг засварласан.

**Авто зам, замын байгууламжийн чиглэлээр:**

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3, 19, 23-р хороодод 4.37 км урт авто замын ажил дуусаж ашиглалтад орсон. Үүнд:

- 1) Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох 0.64 км авто зам,
- 2) Наадамчдын замаас Нүхтийн ам чиглэлийн 1.53 км авто замын шинэчлэлт,
- 3) Чингисийн өргөн чөлөөнөөс баруун үйлдвэрийн гудамж хүртэлх нийт 2.2 км авто зам.

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8, 9, 16-р хороодод 4 төсөл, арга хэмжээний хүрээнд 2.2 км урт авто замын ажил дуусаж ашиглалтад орсон. Үүнд:

- 1) Хан-Уул дүүрэг 9-р хороо Төв замаас гэр хорооллын дундуур шинээр 0.46 км авто зам,
 - 2) Чингисийн хүрээний авто замаас Эко ахмадын сувилал хүртэлх 1.7 км авто зам (8-р хороо),
 - 3) 290 дүгээр цэцэрлэгийн урд талд 6,500 м.кв талбайд авто зогсоол байгуулах ажил (21-р хороо),
 - 4) Яармаг дэнжийн хэсэгт 2,370 м.кв талбайд автобусны буудал байгуулах (8-р хороо)
- Авто замын засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд нийслэл төсвийн хөрөнгөөр 7 байршилд 14.45 км урт авто замыг засварлаж шинэчилсэн.

Авто замын засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгөөр 8 байршилд 3.23 км урт авто замыг засварлаж шинэчилсэн. Үүнд:

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8 төсөл, арга хэмжээний хүрээнд 5 км авто замын ажил хийгдэж байна.



Ус зайлуулах хоолой, суваг байгуулах ажлын хүрээнд:

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 6 байршилд нийт 2630 метр урт борооны ус зайлуулах суваг, үерийн далан байгуулсан. Үүнд:

1. 15-р хороо, Төв цэнгэлдэх хүрээлэн орчимд борооны ус зайлуулах 1200 метр урт шугам сүлжээг угсарч, ашиглалтад оруулсан.
2. 8-р хороо, Архивчдын гудамжинд авто замын борооны ус зайлуулах 423 метр урт ган болон хуванцар хоолой бүхий шугам сүлжээг угсарч ашиглалтад оруулсан.
3. 21-р хороо, Жаргалантын амны үлдэгдэл 800 метр далангийн ажил хийгдэж дууссан.

4. 1-р хороо, Эрлийн байрны урд талын туслах авто замын борооны ус зайлуулах худгуудыг шинэчилсэн.

5. 3-р хороо, Дунд гол дагуу Шунхлай ШТС-ыг буулгаж 3.2 метр өндөр, 207 метр урт үерийн хамгаалалтын даланг шинээр барьсан.

6. 1-р хороо, Наран хотхон, Петровисын шатахуун түгээн станц орчмын авто замын борооны ус зайлуулах шугам, Энхтайваны гүүрэн доорх гаргалгаа шугамыг өргөтгөх ажил тус тус хийгдсэн.

Дүүргийн Засаг даргын 2024 оны А/322 дугаар захирамжийн дагуу “Хан-Уул зам засвар, арчлалт” ОНӨААТҮГ 21.2 сая төгрөгийн хөрөнгөөр “Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, үерийн ус зайлуулах лотки суурилуулах, үерийн хамгаалалтын далан засварлах ажил”-ын хүрээнд 1004 м.куб үерийн ус чиглүүлэгч далан барих, 66 метр замын гадаргуугийн ус зайлуулах сувгийн тэвш байрлуулах ажил хэрэгжиж дууссан.



Гэрэлтүүлгийн чиглэлээр:

Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 6.28 тэрбум төгрөгийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн гудамж талбай, авто зам дагуу нийт 1870 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах 7 төсөл, арга хэмжээ 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар дараах явцтай хэрэгжиж байна. Үүнд:

Хэрэгжиж дууссан 3 төсөл, арга хэмжээ:

1. ДТХО, 13 дугаар хорооны нийтийн эзэмшлийн зам талбайд 78 ширхэг гэрэлтүүлэг суурилуулсан.
2. ДТХО, 23 дугаар хороо, Наадамчдын авто замаас Нүхт чиглэлийн авто замд 16 ширхэг гэрэлтүүлэг суурилуулсан.
3. ДОНХС, 3, 4, 5, 6, 7, 8, 10, 11, 12, 13, 14, 16, 19, 23, 24 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн зам талбайд 640 ширхэг гэрэлтүүлэг суурилуулсан.

Хэрэгжиж буй 3 төсөл, арга хэмжээ:

1. ДОНХС, 2, 5, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21, 23, 24 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн зам талбайд 360 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах ажлын явц 90%, Гүйцэтгэгч “РЗА” ХХК.
2. ДТХО, 14, 21 дүгээр хороодын авто замын зорчих хэсгийн аюулгүй байдлын хүрээнд шинээр 226 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах ажлын явц 90%. Гүйцэтгэгч “Өндрийн удам” ХХК.
3. ДТХО, 10, 12, 13 дугаар хороодын авто замын зорчих хэсгийн аюулгүй байдлын хүрээнд шинээр 440 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах ажлын явц 60%. Гүйцэтгэгч “Ингүүмэл эрчим” ХХК.

Худалдан авах ажиллагааны шатанд 1 төсөл, арга хэмжээ:

ДТХО, 14 дүгээр хорооны авто замын зорчих хэсгийн аюулгүй байдлын хүрээнд шинээр 110 ширхэг гэрэлтүүлэг хийх ажлын тендер дахин зарлах шатанд хэрэгжиж байна.




Мөн шинээр ашиглалтад орсон болон шинэчлэн засварласан авто замын ажлын хүрээнд 3, 4, 8, 9, 10, 12, 16, 20, 22, 23 дугаар хороодод 378 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулсан.

Хан-Уул дүүргийн хэмжээнд 2024 онд гэрэлтүүлгийн урсгал засвар, арчлалтыг 3 бүсэд хувааж, нийт 10804 шонгийн 12154 ширхэг гэрэлтүүлгийн ашиглалтыг мэргэжлийн 3 байгууллагад гэрээгээр хариуцуулж, хяналт тавьж ажиллаж байна.

Гэрэлтүүлгийн урсгал, засвар арчлалтыг тогтмол графикийн дагуу гүйцэтгэж, засвар үйлчилгээний мэдээллийг Улаанбаатар хотын шуурхай удирдлага зохицуулалтын төвд хүргэж ажиллаж байна. Гэрэлтүүлгийн асалт 98.5 хувьтай байна.

Гэрэлтүүлгийн урсгал засварын гүйцэтгэлийг сар бүр хянаж, 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 997.1 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон байна."

Зураг 27. Хан-Уул дүүрэг, гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээний ажлын явц



Камержуулалтын чиглэлээр:

"Нийтлэг үйлчилгээний алба" ОНӨААТҮГ энэ оны эхэнд 1232 ширхэг хяналтын камерын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцаж байсан бөгөөд 4 дүгээр улирлын байдлаар 236 камерын ашиглалтын хугацаа дуусаж, солих шаардлагатай болж, 114 хяналтын камерт ээлжит засвар үйлчилгээ хийгдсэнээр нийт 996 хяналтын камер бүрэн ажиллаж байна. Энэ онд шинээр нийт 715 камер суурилуулахаар төлөвлөсөн. Үүнд;

Камер суурилуулж дуусаж туршилт, тохируулга хийгдэж буй 4 төсөл, арга хэмжээ:

1. 2020-2024 онд хэрэгжиж буй "Нийтийн эзэмшлийн талбайн камержуулалт 1, 2, 3, 6, 7, 8, 17, 1 дүгээр хороо" 53 ширхэг камер,
2. 2021-2024 онд хэрэгжиж буй "Камержуулалт 1-5, 9-11, 13-21-р хороо" 117 ширхэг камер,
3. "Хайрга, дайрга олборлолт, тээвэрлэлтийг хянаж, зохицуулах цэгүүдийн камержуулалт" төсөл арга хэмжээний хүрээнд 12, 13, 14, 16, 21-р хороодод тусгай зориулалтын 10 ширхэг камер,

4. "Камерын хяналтын төв рүү шилэн кабел татах, засвар хийх" төсөл, арга хэмжээний хүрээнд серверийн өрөөний тоноглол суурилуулалтын ажил.

Зураг төсвийн шатанд 2 төсөл, арга хэмжээ:

1. 2022-2024 онд хэрэгжиж буй "Нийтийн эзэмшлийн талбайн камержуулалт 4-10, 12, 13, 14, 16, 21-р хороо" төсөл арга хэмжээний хүрээнд 80 ширхэг камер суурилуулагдах бөгөөд зураг төсөл боловсруулах шатанд

2. 2023-2024 онд хэрэгжиж буй камержуулалтын хяналтын нэгдсэн төв, камержуулалтын ажлын хүрээнд 9, 10, 16, 21-р хороодод 314 ширхэг камер суурилуулагдах бөгөөд зураг төсөл боловсруулагдах шатанд.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Телекамерийн нэгдсэн төвийн техник, тоног төхөөрөмж, систем, программ хангамжийн ажлын гүйцэтгэгчээр "Бодь электроникс" ХХК шалгарсан бөгөөд дотор засал, тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж дууссан. Гадна цахилгааны 2 дахь эх үүсвэрт холбох ажил хийгдэж байна. Ажлын явц 90 хувь.

Зураг. Шинээр камер суурилуулах ажил



1.5 “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан арга хэмжээ:

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан 5 бүлэг, 9 зорилт 47 арга хэмжээ эхний хагас жилд 63%, хяналт шинжилгээ, үнэлгээний 3 бүлгийн 35 шалгуур үзүүлэлт 60%,

Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлээс Хан-Уул хамтран хэрэгжүүлэх 3 арга хэмжээний хагас жилд 47%, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн 3 арга хэмжээ 47%,

Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнөөс Хан-Уул хамтран хэрэгжүүлэх 15 арга хэмжээ хагас жилийн байдлаар 51%, эрчимжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнд хугацаанд нь илгээж тайлагнасан.

Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт: Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 23 зорилго, 108 зорилт, 151 арга хэмжээ эхний хагас жилд 59 хувийн хэрэгжилттэй байна.

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудаас товч дурдвал:

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/63 дугаар захирамжаар “Зөв хүүхэд-Зөв ирээдүй”, “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөр, “Залуучуудын хөгжил”, “Багш”, “Ахмадаа дээдэлье”, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөр, Хорооны хөгжил дэд хөтөлбөр, “Архигүй орчин дэд хөтөлбөр”, “Иргэдээ сонсьё” дэд хөтөлбөрүүд батлагдан хэрэгжиж байна.

Д/д	Дэд хөтөлбөрийн нэр	Нийт төсөв	Тоо	Зарцуулсан төсөв	Үлдэгдэл төсөв
-----	---------------------	------------	-----	------------------	----------------

1	"Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөр	330,000,000	16	329,840,830	159,170
2	"Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөр	180,000,000	9	107,543,700	72,456,300
3	"Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөр	280,000,000	5	274,298,100	5,701,900
4	"Багш" дэд хөтөлбөр	150,000,000	5	94,739,600	50,438,400
5	"Ахмадаа дээдэлъе" дэд хөтөлбөр	250,000,000	4	240,427,700	9,572,300
6	"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөр	100,000,000	3	60,126,260	39,873,740
7	"Хороодын хөгжил" дэд хөтөлбөр	20,000,000	1	20,000,000	20,000,000
8	"Архигүй орчин" дэд хөтөлбөр	20,000,000	-	16,450,000	3,550,000
9	"Иргэдээ сонсъё"	75,000,000	-	-	-
	Нийт	1,405,000,000	43	1,126,976,190	194,651,810

Дээрх хөтөлбөрүүдийн хүрээнд:

"Зөв хүүхэд зөв ирээдүй" дэд хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэхэд 330,0 сая төгрөг баталсан. 1 дүгээр зорилтын хүрээнд 12 төсөл, 2 дугаар зорилтын хүрээнд 4 төсөл, арга хэмжээ, нийт 16 төсөл, арга хэмжээг 329,8 сая төгрөгөөр хэрэгжүүлж, 12,265 иргэнийг хамруулсан.

"Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт 180.0 сая төгрөгийн төсөв батлагдсан. Эхний хагас жилийн байдлаар 9 байгууллагаас 10 төсөл ирүүлснээс 8 төсөл дэмжигдэн хэрэгжиж, нийт 105,32 сая төгрөгийн санхүүжилт зарцуулагдсан байна. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд 2 төсөл хэрэгжүүлж 2-7 насны 918 хүүхдийг амны эрүүл мэндийн үзлэгт хамруулан фторт түрхлэгийг түрхэж, эрүүлжүүлсэн, 3 дугаар зорилтын хүрээнд 3 төсөл хэрэгжүүлж 60 хүүхдийн эмчийг сургалтад хамруулж сайн туршлага солилцох, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах үйл ажиллагаанд, 2 өрхийн эрүүл мэндийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан, 5 дугаар зорилтын хүрээнд 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж 26 эмч, эмнэлгийн ажилчдын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор өндөр хөгжилтэй орнуудын эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч туршлага судлах үйл ажиллагаанд хамруулсан.

"Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэхэд 280.0 сая төгрөг баталсан. Үүнээс 2 дугаар зорилтын хүрээнд 1, 4 дүгээр зорилтын хүрээнд 4, нийт 5 төсөл, арга хэмжээг 274.3 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн.

"Багш" дэд хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэхэд 150.0 сая төгрөг баталсан. 1 дүгээр зорилтын хүрээнд 3, 3 дугаар зорилтын хүрээнд 1, нийт 4 төсөл, арга хэмжээг 90,7 сая төгрөгөөр хэрэгжүүлж, 1000 гаруй багш, ажилчдыг хамруулсан.

"Ахмадаа дээдэлъе" дэд хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд 2 төсөл арга хэмжээ, 2 дугаар зорилтын хүрээнд 1 төсөл, 3 дугаар зорилтын хүрээнд 3 төсөл, нийт 6 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, 8,000 гаруй ахмад настныг хамруулсан.

"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөрийн 4 зорилт, 10 арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

- Хан-Уул дүүргийн 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "Бадрангуй Мөнх" төвд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх сэтгэл зүйн кабинет байгуулсан. Тус кабинетаар нийт 70 хүн үйлчилгээ авсан.
- Зэвсэгт хүчний 120 дугаар цэргийн ангид "Жендэрийн мэдээлэл, сургалт"-ын танхим байгуулан 20,6 сая төгрөгний тоног төхөөрөмж нийлүүлсэн. Төслийн хүрээнд 2024 оны 2 дугаар улиралд "Эмэгтэйчүүдийн оролцоо байгууллагын хөгжилд нөлөөлөх нь", "Төрийн албанд эрэгтэй, эмэгтэйчүүдийн үүрэг оролцоо түүний эрх тэгш байдлыг хангах арга зам" зэрэг сэдвийн хүрээнд 6 цагийн сургалтыг ангийн нийт албан хаагчдын дунд явуулсан. Төлөвлөгөөт хурал зөвлөгөөн, суртал хүмүүжлийн ажлууд цаг хугацаандаа тасалдалгүй явагдах орчин нөхцөл бүрдэж, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, хувийн хэвслүүдийн сургалт мэдээллүүд тогтмол явагдаж хэвшсэн байна.

- Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Камержуулалтын төслийг хэрэгжүүлэн 19,9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Камержуулалт тавигдснаар хугцаат цэргийн албан хаагчдын дунд аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дээрэлхэлт, гэмт хэрэг зөрчил гараагүй байна.

“Хороодын хөгжил” дэд хөтөлбөрийн хүрээнд 5 зорилт 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн эхний хагас жилийн байдлаар 85 хувьтай хэрэгжсэн.

“Архигүй орчин” дэд хөтөлбөрийн хүрээнд 1 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхэд 16,450,000 төгрөг зарцуулсан.

“Иргэдээ сонсьё” дэд хөтөлбөр дээр төсөл хэрэгжээгүй байна.

Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр:

❖ Дүүргийн Засаг даргын 2024 оны А/320 дугаар захирамжаар Засаг даргын Тамгын газрын бүтэц, албан тушаалын жагсаалтыг шинэчилж батлуулсан. Захирамжийн 1 дүгээр хавсралтаар Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/444 дүгээр захирамжид заасны дагуу Засаг даргын Тамгын газрын бүтэц нь 10 хэлтэс, 5 тасгийн нийт 64 албан тушаал, захирамжийн 2 дугаар хавсралтаар төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах төрийн үйлчилгээний 32 албан тушаалын жагсаалтыг тус тус байршуулсан.

Байгууллагын албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, байгууллагын ил тод байдлыг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх чиглэлээр 2024 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө болон Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын “Шудрага байдлын үнэлгээ”-г сайжруулах 2024 оны төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар тус тус батлуулсан.

Дээрх 2 төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахаар авлига, ашиг сонирхол, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын удирдамж, төсвийг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан.Үүнд;

- Засаг даргын Тамгын газар болон хорооны төрийн албан хаагчдын өдөр тутмын ажлын хэрэгцээнд зориулж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн холбогдох заалт бүхий дэвтэр хэвлүүлэхээр эх бэлтгэлийг хийж, хэвлэлтэд өгсөн.
- Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг төрийн албан хаагчдад таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх агуулга бүхий видео шторк бэлтгүүлж, цахим хуудаст нийтэлсэн.
- Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн албан хаагчдын оролцоотойгоор Хан-Уул дүүрэгт худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн, нэгж байгууллага болон иргэдэд худалдаа, үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой мэдээллийг үйл ажиллагаа эрхлэгчдэд хүргэх агуулга бүхий видео шторк хийх ажлыг хангуулж студид захиалга өгсөн.
- Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг төрийн албан хаагчдад таниулах, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Morning QUIZ арга хэмжээг зохион байгуулж ЗДТГ-ын 70 албан хаагчийг хамруулсан. QUIZ асуултанд дээрх хуулиуд болон хөгжөөнт, танин мэдэхүйн асуултуудаас бүрдсэн бөгөөд эхний 3 байр тус бүр 1 албан хаагч шалгаруулж, мөнгөн шагнал олгосон.
- Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж, сургалтад 70 албан хаагчийг хамруулсан.

❖ "Засаг даргын Тамгын газар болон хороодын төрийн албан хаагчийн сургалт хөгжил, ёс зүй, сахилга хариуцлагын чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн

төлөвлөгөө"-г батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 20 арга хэмжээний хэрэгжилт 95 хувь хангагдсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд Удирдлагын академийн төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны багц сургалтад 4, дунд хугацааны давтан сургалтад 3, шинэ томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх 40 цагийн сургалтад 3, чадавхжуулах богино хугацааны сургалтад удирдах 4, гүйцэтгэх 3, Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад 20, баг хорооны Засаг дарга нарыг чадавхжуулах сургалтад 22, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга зүйн сургалтад 10, Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад 2, Хүний нөөцийн удирдлага сургалтад 2, Жендерт суурилсан төсөвлөлт сургалтад 3, Жендерийн мэргэжилтэн, шинжээчдийг чадавхжуулах сургалтад 1, нийт 81 албан хаагч мэргэшил дээшлүүлж, бусад байгууллагаас зохион байгуулсан богино хугацааны 27 удаагийн сургалтад давхардсан тоогоор 860 албан хаагч хамрагдсан.

Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022 оны 7 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Нийслэлийн архивын газраас 2024 оны



05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан Үндэсний бичгийн сургалтад албан хэрэг хөтлөлт, мэдээлэл технологийн 4 албан хаагч, Удирдлагын академиас эрхлэн гаргасан Төрийн албан хаагчийг чадавхжуулах "Монгол бичгийн цахим сургалт"-ын 1-3 дугаар түвшинд ЗДТГ, хороодын албан хаагчид бие даан хамрагдаж үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх, цахим баримт бичиг боловсруулах арга зүй эзэмшсэн.

Эрх зүйн сургалт, арга хэмжээ: "Иргэдэд согтууруулах ундаа, мансууруулах төрлийн бодис хэрэглэх хорт зуршлаас урьдчилан сэргийлэх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн сургалт, өдөрлөг зохион байгуулах" зорилтын хүрээнд "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө"-г дүүргийн Засаг даргаар батлуулан дүүргийн Прокурорын газар, Цагдаагийн газар, Боловсролын хэлтэс, дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран 2 сургалт, 1 өдөрлөг, 2 арга хэмжээ зохион байгуулж 1801 сурагч, иргэд аж ахуй нэгж байгууллагыг хамруулсан.

Дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор орон гэргүй, тэнэмэл байдлаар амьдардаг, олон нийтийн газар, гудамж талбайд архи дан согтуурч, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг алдагдуулан, танхайрах, архинд донтох өвчтэй иргэдийг гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх чиглэлээр "Тэнэмэл" "Тэнэмэл-2" тусгай арга хэмжээг сар, улирлаар зохион байгуулсан. Дээрх арга хэмжээний хүрээнд 2024 онд орон гэргүй тэнэмэл иргэдийг цуглуулж, нийгэмшүүлэх зорилгоор "Өлзийт асар" төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, 41 иргэнийг дүүргийн 14 дүгээр хороонд байрлах "Өлзийт асар" төвд хүлээлгэн өгч ажилласан. "Хууль зүйн тусалцааны төв"-ийн Хан-Уул дүүрэг дэх салбартай хамтран дүүргийн Ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн 9-11 дүгээр ангийн 97 сурагчдад "Хууль эрх зүйн мэдлэг олгох", хорт зуршлаас урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулсан.

Тохижилт, нийтийн аж ахуйн чиглэлээр:

Нийтийн эзэмшлийн гудамж талбай, орон сууц хорооллын дунд явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулж буй, хэлбэржүүлэлт, цэвэрлэгээний огтлол хийх шаардлагатай модны судалгааг гаргаж, дүүргийн Засаг даргын 2024 оны А/635 дугаар захирамжаар 18.9 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэж, Үр үрслэх ХХК-иар гүйцэтгүүлсэн.


Тус ажлын хүрээнд 153 ширхэг улиас, 215 ширхэг хайлаас, 3 ширхэг монос нийт 373 ширхэг модны гувар сэжим цэвэрлэх, мөчрийн цөөлөлт хийж, 12500 м.кв талбайд хэлбэржүүлэлтийн дараах цэвэрлэгээ, шарилж устгал хийж, 52 тн хог хаягдыг ачиж тээвэрлэсэн.

Зураг. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн мод сөөгний хэлбэржүүлэлтийн ажлын явц



Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас олгосон 2700 мод, бут сөөгийг нийтийн эзэмшлийн гудамж, талбай хариуцсан 10 байгууллагад хуваарилж, дүүргийн 1 дүгээр хороонд Шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэн, Хан-Уул өндөрлөг болон Иргэдэд үйлчлэх төвийн гадна 400 монос, 400 голт бор, 400 гүйлс, Наадамчдын зам дагуу ургамлан хашлаганы нөхөн тарилтад 1000 хайлаас, Архивчдын гудамж дагуу нөхөн тарилтад 132 улиас, Айцын аманд 90 улиас, 13 дугаар хороонд Төгсөгчдийн төгөл талбайд 278 улиасыг тус тус тарьсан.

Зураг. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас хуваарилагдсан мод, бут сөөгийг тарих ажлын явц, Шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэн, Хан-Уул өндөрлөг, Иргэдэд үйлчлэх төв байр орчим



Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр:

Хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан ялгаж буй сууц өмчлөгчдийн холбоод, аж ахуйн нэгж байгууллагуудыг ангилсан хуванцраа тушаах, гэрээ байгуулах чиглэлээр “Ти Эм Эл” ХХК дахин боловсруулах үйлдвэртэй хамтарч ажиллаж дүүргийн хэмжээнд 234 байгууллага, СӨХ гэрээ байгуулж, хуванцар хаягдлаа нийлүүлж, дахин боловсруулж байна.

Эко хотын тээвэр ААТҮГ нь 7 хоног бүрийн Пүрэв гарагт тогтмол 1 удаа 1, 2, 20, 23 дугаар хороодын нийт 8 цэгээс 7 удаагийн рейсээр 18,8 тонн хуванцар, лааз, цаасан хайрцаг, гялгар уутыг тээвэрлэсэн.

Хот байгуулалт, хотын стандартын хяналтын газартай байгуулсан хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт сууц өмчлөгчдийн холбоодын удирдлага, ажилтнуудад хог хаягдлын ангилан ялгалтын чиглэлээрх хотын стандартын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулж, 110 сууц өмчлөгчдийн холбоодын 160 хүн хамрагдсан.



Дүүргийн төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр он дамжин хэрэгжсэн XCMG маркийн задгай тэвштэй, 8 тн даацтай, цас хусагчтай 7 ширхэг хогны автомашиныг 2024 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хог тээврийн байгууллагуудад хүлээлгэж өгсөн.

Зураг. Хог тээврийн задгай тэвштэй, 8 тн даацтай, цас хусагчтай 7 ширхэг хогны автомашиныг хог тээврийн байгууллагуудад хүлээлгэн өгөх үйл ажиллагаа



Дүүргийн төсвийн 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр хог шахах төхөөрөмж бүхий Хьюндай HD-78 маркийн 6 м.кубын 1, Хьюндай HD-170 маркийн 14.2 м.кубын 3 буюу нийт 4 ширхэг автомашинаар хог тээврийн байгууллагуудад парк шинэчлэлт хийсэн.



Дүүргийн төсвийн 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр хог тээврийн задгай тэвштэй болон шахах төхөөрөмжтэй 21 машин, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээнд ашиглах цэвэрлэх, услах, шүүрдэх, ариутгах хосолмол үйлдэлтэй том оврын 2 машин, 50 ширхэг үлээгч төхөөрөмж, 27 ширхэг цахилгаан мотортой шүүрдэгч, 15 ширхэг бага оврын давс цацагч, 7 ширхэг замын нуух шүүрдэгч бага оврын машин, 12 ширхэг 4 үйлдэлт ковш, 1 ширхэг экскаваторыг худалдан авч, ашиглалтад оруулсан. Мөн зам талбайн ажилчдыг тээвэрлэх 4 автобус болон 3 автокран, 3 ширхэг усалгаа, ариутгалын зориулалттай машин худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна.



2024 оны байдлаар дүүргийн нутаг дэвсгэрээс төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн хог хаягдлын тоон үзүүлэлт

Байгууллага	Рейс	Тээвэрлэсэн хог, тн	Хариуцсан хороо
-------------	------	------------------------	-----------------

“Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ	17,655	75,451	9, 10, 12, 13, 14, 16, 21, 25
“Хан-Уул Агро” ОНӨААТҮГ			11, 15, 17, 18, 22
“Хан-Эко тээвэр” ААТҮГ			4, 5, 6, 7, 8, 24
“Эко хотын тээвэр” ААТҮГ			1, 2, 3, 19, 20, 23
Нийт	17,655	75,451	25 хороо

Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хог тээвэрлэлт, зам цэвэрлэгээг сайжруулах, хяналт тавих ажлын хүрээнд дүүргийн менежерээр удирдуулан долоо хоног бүр “Хот, нийтийн аж ахуйн шуурхай зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээг авч, үүрэг даалгаврыг холбогдох байгууллагуудад хүргүүлэн, хяналт тавин ажиллаж байна.




Бүх нийтийн их цэвэрлэгээ:

Дүүргийн Засаг даргын 2024 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан "Хоггүй Хан-Уул 2024" аяны хүрээнд дүүргийн хэмжээнд 11 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албад болон дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт 5894 аж ахуй нэгж байгууллага, 336 сууц өмчлөгчдийн холбоодын 6,916 хүн оролцож, 5,721,809 м.кв талбайгаас 1053,3 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.

Батлагдсан хуваарийн дагуу 2024 оны 12 дугаар сард нэгдсэн бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулахаар бэлтгэл хангаж байна.



ЭКО ДҮҮРЭГТ ХАВРЫН БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ МАРГААШ



Ta, Zulaa Erdenezuul, Цэц Цэц 6а өөр 53 хүн

2 сэтгэгдэл 78 удаа хуваалцсан



Хан-Уул Эко Дүүрэг





Зам талбайн цэвэрлэгээ:

Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Чиг үүрэг шилжүүлэх тухай” 2023 оны А/1461 дүгээр захирамжаар хот, нийтийн аж ахуйн чиг үүрэг дүүрэгт шилжиж ирсэнээр нийт 4,225,209 м.кв талбайн цэвэрлэгээ үйлчилгээг 13 байгууллагад хариуцуулан, ажлын явц, гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Дүүргийн Засаг даргын 2024 оны А/162 дугаар захирамжийн дагуу “Хотын хөгжлийг дэмжих шинэ тосгон” ТББ-тай гэрээ байгуулан дүүргийн нийтийн эзэмшлийн нийт зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээнд хөндлөнгийн хяналтыг гүйцэтгүүлж байна.


Зам талбайн байгууллагуудад 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 11,588.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд 11, 12 дугаар сарын гүйцэтгэлийн 12 дугаар сарын 05, 11-ний өдрийн дотор хэрэгжүүлэхээр ажиллаж байна.



Ариутгал, халдваргүйжүүлэлт:

Дүүргийн хэмжээнд нийт 25 хороодын 78 байршлын 357,000 м.кв талбай, 11086 нүхэн жорлон, 5914 бохирын цооног ариутгаж, халдваргүйжүүлсэн. Үүнд:

1. Дүүргийн Засаг даргын А/155 дугаар захирамжийн дагуу хороодоос ирүүлсэн байршлын дагуу нийтийн эзэмшлийн бохирдол ихтэй болон шар усны үер урсан 40,000 м.кв талбайг мэргэжлийн байгууллагаар ариутгуулан хяналт тавьж ажилласан.
2. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/125 дугаар захирамжийн дагуу 8, 10, 12, 13, 14, 21 дүгээр хороодын нутаг дэвсгэрт үхсэн мал амьтны сэг зэм, өтөг бууцыг цэвэрлэж, нийт 23,000 м.кв талбайг ариутгаж, 5258.14 тонн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн.
3. Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас дүүргийн хэмжээнд бохирдол ихтэй 200,000 м.кв талбайд мананцарт ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.
4. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/297 дугаар захирамжийн дагуу гэр хорооллын 11086 нүхэн жорлон, 5914 бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлсэн.
5. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/600 дугаар захирамжийн дагуу нийслэл, дүүргийн 2024 оны ээлжит сонгуулийн 29 дүгээрт тойргийн 73 санал авах байрыг 2 удаагийн давтамжтай ариутгаж, халдваргүйжүүлсэн.




Худалдаа үйлчилгээ, хөдөө аж ахуйн чиглэлээр:

Дүүргийн мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангуулах, цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлыг шуурхай авч хэрэгжүүлэх өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд 14 заалт бүхий “Бэлтгэл ажил хангуулах ажлын төлөвлөгөө”-г батлуулсан.

Дүүргийн нутаг дэвсгэрт өвөлжилт хүндрэх нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан Хан-Уул дүүргийн Онцгой комиссын хурлын шийдвэрийн дагуу дүүргийн Засаг даргын 2024 оны А/08 дугаар захирамжаар 12,13,14 дүгээр хорооны зудын нөхцөл байдлын үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан.

13-р хороо 43-р карьерын ойролцоох нутаг, Хар үнэгний аж ахуй, Бөхөг болон, 14-р хороо Гавжийн шандаар цагаанаар зудтай, 13-р хорооны зарим хэсгээр цагаанаар зудархуу байгаа дүгнэлт гарсан.



Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу зудын байдалд үнэлгээ хийхэд Хан-Уул дүүргийн 13-р хороо 43-р карьерын ойролцоох нутаг, Хар үнэгний аж ахуй, Бөхөг болон, 14-р хороо Гавжийн шандаар цагаанаар зудтай, 13-р хорооны зарим хэсгээр цагаанаар зудархуу байна.



Дүүргийн Засаг даргын 2024 оны А/18 дугаар захирамжийн хүрээнд 23.7тн өвс, 18.7тн тэжээлийг дүүргийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүс буюу 12, 13, 14 дүгээр хорооны

цөөн малтай, бага орлоготой 381 өрхөд өвсний дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг хороодтой хамтран зохион байгуулсан.



Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/188 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн мал бүхий 12,13,14 дүгээр хорооны малчин, фермерт 48.2тн “Ургац хивэг”-ийг дүүргийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүс буюу 12,13,14 дүгээр хорооны хаваржилт хүндэрсэн, өвс, тэжээлийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 531 өрхөд олгох ажлыг хороодтой хамтран зохион байгуулсан.



“Мал аж ахуйн нэгдсэн систем”-ийн бүртгэл:

- Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан буюу <https://livestock.mofa.gov.mn/> цахим системд 2023 оны мал, тэжээвэр амьтны тооллогоор тоологдсон 781 өрхийн 46919 мал, 2024 оны мал төллөлтөөр төллөсөн 631 төл буюу 10 унага, 434 тугал, 121 хурга, 66 ишиг, 2050 том мал хорогдсоноос 247 адуу, 250 үхэр, 713 хонь, 845 ямааг тус тус бүртгэн мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулсан.

Тавлаг байдал цэсний “Малчдын түвшинд бэлтгэсэн өвс тэжээл”, “Хашаа хороо”, “Усан хангамж”, “Хадлангийн талбай”-н дэлгэрэнгүй судалгааг мал бүхий 12,13,14 дүгээр хороодоос авч, цахим мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулсан. Үүнд:

- Малчдын түвшинд бэлтгэсэн 366 өрхийн 4883.8тн өвс, 22 өрхийн 271.9тн сүрэл, 113 өрхийн 1531.1тн ногоон тэжээл, 145 өрхийн 946.5тн үйлдвэрийн тэжээл, 96 өрхийн 196.9тн гар тэжээл, 26 өрхийн 275.8тн дарш, 54 өрхийн 41.8тн давс, хужрыг өрх бүрээр тус тус оруулсан.

Нийслэлийн Засаг даргын 8 захирамжийн холбогдох 17 заалтын хэрэгжилтийг 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар нэгтгэн, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хүргүүлсэн. Биелэлт-60.5%.

2024 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн Засаг даргын 25 захирамж, зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн холбогдох 51 заалт (Биелэлт-70.3%);

3 дугаар улиралд 11 захирамжийн 21 заалтын биелэлтийг тус тус нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн тайлагнасан. Мөн нийслэлийн Засаг даргын 3 албан даалгаврын холбогдох 33 заалтын биелэлтийг нэгтгэн, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хүргүүлсэн. (Биелэлт-88.1%)

Нийслэлийн Засаг даргын 2024 оны жилийн эцсийн байдлаар тайлагнах 6 захирамжийн 34 заалт, 2 зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн 6 заалт, 3 албан даалгаврын 21 заалтын биелэлтийг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж, тайлагнасан. (Биелэлт-94%)

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1488, 2024 оны А/230, А/235, А/238, А/269, А/271, А/272, А/355, А/394 дүгээр захирамжуудаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 24,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх дүүргийн Засаг даргад шилжин ирсэн. Явцаар нь авч үзвэл гэрээ байгуулсан 6 төсөл, арга хэмжээ, тендер зарлах шатанд – 2 төсөл арга хэмжээ, ажлын даалгавар хүлээгдэж байгаа 2 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

№	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР	БАТЛАГДСАН ТӨСӨВ	2023 ОНД САНХҮҮЖИХ	АЖЛЫН ЯВЦ
НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ				
1	Сургуулийн барилга, 960 суудал (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо)	18,000.0	5,000.0	Гүйцэтгэгч: Хуягт харш ХХК шалгарсан. Зураг төсөв боловсруулагдаж байна.
2	Хан-Уул дүүргийн 4,5,6,7,10,16,23,24 дүгээр хороо яармаг орчмын нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон хотхонуудад хэрэглэгдэж буй цэвэр усны шугамын шинэчлэлт (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 4,5,6,7,10,16,23,24 дүгээр)	6,000.0	6,000.0	Гүйцэтгэгчээр Ус сувгийн удирдах газар ОНӨҮГ гэрээ байгуулсан.
	ДҮН	24,000.0	11,000.0	
НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН				
1	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж, засвар шинэчлэлт (ХУД)	400.0	400.0	Гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн.
2	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж (ХУД)	400.0	400.0	Багц-1 , Монтех дистрибьюшн Багц-4 , Мөнх дулаан илч ХХК гэрээ байгуулах шатанд. Гомдол гарсан.
3	Боловсролын байгууллагуудын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн (ХУД)	400.0	400.0	Багц-1- Чиглэл ХХК гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн. Багц-2, 3 дахин зарлах шатанд.
4	Нийслэлийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн Урлаг зааланд шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл (ХУД, 4 дүгээр хороо)	25.0	25.0	2024.05.28 Өүби жийн центр ХХК гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн.

5	Нийслэлийн ерөнхий боловсролын 130 дугаар сургуульд шаардлагатай тоног төхөөрөмж (Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо)	24.0	24.0	3 удаа зарласан аж ахуй нэгж материал ирүүлээгүй. Техникийн тодорхойлолт буцаасан.
6	Орон сууцны хорооллын доторх зам засвар, явган хүний замын шинэчлэлт, тохижилт (ХУД)	300.0	300.0	2024.04-23-2024.05.15 нээлт хийсэн гүйцэтгэгч шалгараагүй. Дахин зарлах шатанд.
7	Орон сууцны хороолол доторх зам засвар, тохижилтын ажил (ХУД, 1 дүгээр хороо)	90.0	90.0	2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр эрх шилжиж ирсэн. Ганзориг төлөөлөгч рүү 2024.03.13-ны 03/422 дугаар албан бичгээр ажлын тоо хэмжээний талаар мэдээлэл ирүүлэх албан бичиг хүргүүлсэн. Ажлын даалгавар хүлээгдэж байна.
8	Тохижилт, бүтээн байгуулалтын ажил (ХУД, 17 дугаар хороо)	50.0	50.0	НХОГ-с зураг төсөв боловсруулах ажлын даалгавар хүлээгдэж байна.
9	ДҮН	1,689.0	1,689.0	
10	НИЙТ ДҮН	25,689.0	25,689.0	

Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Хөрөнгө гаргах тухай” А/368 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “Тусламжаар ирсэн улаан буудайг буулгах, савлах, малчдад хүргэх ажлыг зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай” А/180 дугаар захирамжийг батлуулж, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан.

Дүүрэгт хуваарилагдсан 65тн улаан буудайг 2024 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Толгойт өртөөний Ундарга салбар зам дээр хүлээн авч, ачаа буулгалтын багтай гэрээ байгуулж, 20 ажилтан 11:00-03:00 цагийн хооронд савлах, буулгах, ачих, хороодод хүргэх ажлыг зохион байгуулж, 12,13,14 дүгээр хорооны нийт 548 малчин, мал бүхий иргэдэд тусламжаар ирсэн улаан буудай тараах ажлыг хороодтой хамтран зохион байгуулсан. Үүнд:

- 12 дугаар хороо 434 шуудай буюу 14.5тн улаан буудайг 64 өрх
- 13 дугаар хороо 501 шуудай буюу 25тн улаан буудайг 232 өрх
- 14 дүгээр хороо 553 шуудай буюу 25.5тн улаан буудайг 252 өрх



1.6 Нийслэл, дүүргийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт;

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 2024 онд 24 удаа зохион байгуулагдан, нийт 187 үүрэг даалгавар өгөгдөж, 86.6%-тай хэрэгжсэн. Шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг холбогдох хэлтэс, албадаас авч нэгтгэн батлуулж, хугацаанд нь тайлагнасан. Мөн нийслэлийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сараас 2024 оны 5 дугаар сар хүртэлх нийт 15 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс өгсөн 107 үүрэг даалгаврын биелэлтийг шинэчлэн, нэгтгэж, 2024 оны 5 дугаар сарын 10-ны өдөр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Мөн Нийслэлийн Засаг

даргаас цаг үеийн шинжтэй ирсэн 11 үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн, тухай бүр хугацаанд нь тайлагнасан.

Хан-Уул дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2024 онд 22 удаа зохион байгуулан, нийт 87 үүрэг даалгавар 83%-тай хэрэгжсэн. Шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар болон хэлтэс, албадад тулгамдаж буй асуудлын саналыг нэгтгэн 7 хоног бүр Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулах мэдээллийг бэлтгэсэн. Мөн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын 14 хоногийн үйл ажиллагааны тайланг нэгтгэн боловсруулж, удирдах ажилтнуудын шуурхайд танилцуулах мэдээллийг тус тус бэлтгэсэн.

1.7 Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн;

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан “төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах” арга хэмжээний хүрээнд Төрийн цахим үйлчилгээний газартай хамтран дүүргийн 25-н хороонд төрийн үйлчилгээний “Хурдан” цэгийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган, 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс иргэдэд үйлчилгээ үзүүлж эхэлсэн.



“Хурдан” цэгээс иргэд нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, иргэний үнэмлэхийн болон оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа, авто тээврийн хэрэгслийн торгуулийн мэдээлэл, жолоочийн лавлагаа, мэдээлэл, эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах, шинжилгээний хариу авах, зээлийн мэдээллийн лавлагаа, үл хөдлөх эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаа болон иргэний үнэмлэх дахин авах, ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт зэрэг төрийн 43 байгууллагын 478 төрлийн үйлчилгээнүүдийг нэг дороос авах боломжтой бөгөөд дүүргийн 25-н хорооноос 2024 онд нийт 1276 иргэн “Хурдан- цэгийн үйлчилгээ авсан.

Хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр: Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/987 дугаар захирамжаар нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжтэй хийх гэрээ, батламжийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цахимжуулсан.

Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргүүлэх чиглэлээр Ulaanbaatar.mn цахим сайтын “Онлайн бизнес төв” бүртгэлийн системээр иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч, тухай бүрд шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.



Худалдаа үйлчилгээ эрхлэх “Онлайн бизнес төв” цахим бүртгэлийн системд 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 325 иргэн, аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснийг хүлээн авч, 81,5%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. Үүнд:

- ✓ Зөвшөөрсөн-273
- ✓ Судалж буй- 30
- ✓ Татгалзсан-57

Мөн худалдаа үйлчилгээ эрхлэх “Онлайн бизнес төв” цахим бүртгэлийн системийг иргэн, аж ахуйн нэгжүүдэд танилцуулан, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



1.8 Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн;

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/67 дугаар захирамжаар өөрийн эзэмшлийн болон орчны 50 метр хүртэлх талбайн тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, хөрс, орчны бохирдлыг бууруулж, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн бүх аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд уриалан ажиллаж байна. Дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн 190 аж ахуйн нэгжид гадна тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмолжуулах, гэрэлтүүлэг, хаягийн байгууламжийг сайжруулах талаар үүрэг чиглэл өгч, хаягийн байгууламжийг шинэчлэх шаардлагатай 5 аж ахуйн нэгжийн хаягийн байгууламжийг стандартад нийцүүлэн солиулж, 3 аж ахуйн нэгж, гадна талбайг тохижуулсан.

“Ногоон хот – Иргэний оролцоо” мод тарих аяныг 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс зохион байгуулан ажиллаж байна. Тус аяны хүрээнд 1050 өрх, 104 сууц өмчлөгчдийн холбоо, 23 цэцэрлэг, 16 ерөнхий боловсролын сургууль, аж ахуйн нэгж байгууллагууд нэгдэж, 48583 ширхэг мод, бут сөөг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн.



Цэцгийн мандал 44 байршилд байгуулахаар төлөвлөснөөс 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар 1, 2, 8, 13, 15, 19, 20, 23, 24 дүгээр хорооны 16 байршилд 138,350 ширхэг цэцэг тарьж, усалгаа, арчилгааг мэргэжлийн байгууллагууд тогтмол хуваарийн дагуу гүйцэтгэж байна.

Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/78 дугаар захирамжийн дагуу дүүргийн төсвийн 191.4 сая төгрөгийн хөрөнгөөр “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 300,000 гаруй ширхэг нэг наст, гоёл чимэглэлийн цэцгийн үрсэлгээг хийсэн. Тохижилт цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх ажлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ногоон байгууламжийн 10 байгууллага нийтийн эзэмшлийн 44 байршлын 5000 гаруй м.кв талбайд цэцэг тарьж, цэцгийн мандал байгуулахаар төлөвлөж, хөрс боловсруулалтын ажлыг бүрэн хийсэн. Цэцэг тарих ажил 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс эхэлсэн бөгөөд 30 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.


Зураг . Нийтийн эзэмшлийн гудамж талбайд цэцгийн мандал байгуулах ажлын явц



Дүүргийн Засаг даргын 2024 оны А/628 дугаар захирамжийн дагуу дүүргийн төсвийн 72.6 сая төгрөгөөр 1, 3, 15 дугаар хорооны 3 байршлын 2852 м.кв талбайд зүлэг барих, 363.9 метр хамгаалалтын хашлага барих ажил хөрс боловсруулалтын шатанд хэрэгжиж байна.

Ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн тарилтын ажлын хүрээнд дүүргийн хэмжээнд 28770 м.кв талбайд зүлэг нөхөн тарихаар төлөвлөгдсөнөөс 2024 оны 06 дугаар сарын 04-ний байдлаар Төв цэнгэлдэх хүрээлэнд 596 м.кв зүлэг нөхөн тарьж, усалгааг тогтмол хийж байна.

Баяр наадмын бэлтгэл ажлын хүрээнд нийслэлийн төсвийн 489.0 сая төгрөгийн хөрөнгөөр Бат-Өндөр хайрхан ХХК Төв цэнгэлдэхийн гадна 6400 м.кв талбайг зүлэгжүүлж, усалгааны шланг суурилуулалтыг гүйцэтгэж байна.



Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр: Хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан ялгаж буй сууц өмчлөгчдийн холбоод, аж ахуйн нэгж байгууллагуудыг ангилсан хуванцраа тушаах, гэрээ байгуулах чиглэлээр “Ти Эм Эл” ХХК дахин боловсруулах үйлдвэртэй хамтарч ажиллаж дүүргийн хэмжээнд 234 байгууллага, СӨХ гэрээ байгуулж, хуванцар хаягдлаа нийлүүлж, дахин боловсруулж байна.

Эко хотын тээвэр ААТҮГ нь 7 хоног бүрийн Пүрэв гарагт тогтмол 1 удаа 1, 2, 20, 23 дугаар хороодын нийт 8 цэгээс 7 удаагийн рейсээр 18,8 тонн хуванцар, лааз, цаасан хайрцаг, гялгар уутыг тээвэрлэсэн.

Хот байгуулалт, хотын стандартын хяналтын газартай байгуулсан хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт сууц өмчлөгчдийн холбоодын удирдлага, ажилтнуудад хог хаягдлын ангилан ялгалтын чиглэлээр хотын стандартын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулж, 110 сууц өмчлөгчдийн холбоодын 160 хүн хамрагдсан.

Зураг . Сургалтын явц



Дүүргийн төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр он дамжин хэрэгжсэн XCMG маркийн задгай тэвштэй, 8 тн даацтай, цас хусагчтай 7 ширхэг хогны автомашиныг 2024 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хог тээврийн байгууллагуудад хүлээлгэж өгсөн.

Зураг. Хог тээврийн задгай тэвштэй, 8 тн даацтай, цас хусагчтай 7 ширхэг хогны автомашиныг хог тээврийн байгууллагуудад хүлээлгэн өгөх үйл ажиллагаа:



Дүүргийн төсвийн 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр хог шахах төхөөрөмж бүхий Хьюндай HD-78 маркийн 6 м.кубын 1, Хьюндай HD-170 маркийн 14.2 м.кубын 3 буюу нийт 4 ширхэг автомашиныг нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр “Хьюндаймоторс Монгол” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Хог шахах төхөөрөмж бүхий автомашин нийлүүлэгдэх шатанд хэрэгжиж байна.

Дүүргийн төсвийн 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр хог тээврийн задгай тэвштэй 9, зам цэвэрлэгээ усалгааны 12, хог болон цас ачих, хусах 13 механизм буюу нийт 34 автомашин механизм нийлүүлэгдэх шатанд хэрэгжиж байна.

Хог цуглуулалт, тээвэрлэлт:

Дүүргийн хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хог тээврийн 4 байгууллагын цуглуулж, тээвэрлэсэн хог хаягдлын тоон мэдээлэл:

Байгууллага	Рейс	Тээвэрлэсэн хог, тн	Хариуцсан хороо
“Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ	17,655	75,451	9, 10, 12, 13, 14, 16, 21, 25
“Хан-Уул Агро” ОНӨААТҮГ			11, 15, 17, 18, 22
“Хан-Эко тээвэр” ААТҮГ			4, 5, 6, 7, 8, 24
“Эко хотын тээвэр” ААТҮГ			1, 2, 3, 19, 20, 23
Нийт	17,655	75,451	25 хороо

Зураг . Хог хаягдлын өдөр, шөнийн тээвэрлэлт



Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хог тээвэрлэлт, зам цэвэрлэгээг сайжруулах, хяналт тавих ажлын хүрээнд “Шинэ 7 хоногийг хоггүй угтъя аян”-ыг зохион байгуулж 7 хоног бүрийн даваа гаригт Засаг даргын орлогч Б.Цэрэнгийн удирдлагаар нийт 19 удаагийн шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулан холбогдох мэдээ тайланг бэлтгэн танилцуулсан.

Зураг . Хот, нийтийн аж ахуйн шуурхай



Байгаль орчныг хамгаалах, хөрсний нөхөн сэргээлтийн чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 2023 оны А/151 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүрэгт түгээмэл тархалттай ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг 7 аж ахуйн нэгжийн 41, Төв аймгийн Алтанбулаг суманд үйл ажиллагаа эрхэлдэг 7 аж ахуйн нэгжийн 102, нийт 14 аж ахуйн нэгжийн 143 тээврийн хэрэгсэлтэй “Тээвэрлэлтийн хариуцлагын гэрээ”-г хийж, хяналт тавьж ажиллаж байна.

Дээрх байгууллагуудтай хамтарч 2024 онд уул уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн 13 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 6 га-д биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөн ажиллаж байна. Нөхөн сэргээлтийн ажил 2024 оны 10 дугаар сарын 01-нээс 11 дүгээр сарын 15-ны хооронд хэрэгжинэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ҮР ДҮН**2.1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн;**

❖ Төсвийн Шууд захирагчийн “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгах саналыг хэлтэс, тасгуудаас хүлээн авч нэгтгэн 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөг стратеги төлөвлөгөөний нийт 7 бүлгийн хүрээнд:

- Холбогдогч талуудын оролцоо, судалгаа, шинжилгээ, баримтад үндэслэсэн бодлого, шийдвэрийг боловсруулж, төлөвлөж хэвшүүлэх зорилгын хүрээнд 25 зорилт, 33 арга хэмжээ
- Хяналт-шинжилгээний үр дүнд тулгуурлан бодлого, шийдвэрийн төлөвлөлт, зохицуулалтыг хийж хэвшүүлэх хүрээнд 2 зорилт, 6 арга хэмжээ
- Бодлого, шийдвэрийн үнэлгээний бие даасан, найдвартай байдлыг хангаж, хэрэглээг нэмэгдүүлэх хүрээнд 1 зорилт, 2 арга хэмжээ;
- Мэдээллийн ил тод байдлыг хангаж, дэвшилтэт технологид суурилан түргэн шуурхай хүргэх хүрээнд 5 зорилт, 11 арга хэмжээ;
- Мэргэшсэн, туршлагатай, бүтээлч хандлагатай, хүний нөөцийг бүрдүүлэх хүрээнд 2 зорилт, 5 арга хэмжээ;
- Байгууллагын дотоод үйл ажиллагаа бүрэн уялдаатай болгох хүрээнд 3 зорилт, 41 арга хэмжээ;
- Төрийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх хүрээнд 8 зорилт, 11 арга хэмжээ
- Нэмэлт ажлын хүрээнд 7 зорилт, 12 арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 53 зорилт, 121 арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн, тайлагнаж, тайланг 2024 оны 12 дугаар 11-ний өдрийн 03/2587 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.


Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн тайлангийн 7 бүлэг, 53 зорилт, 121 арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс тус бүрээр нэгтгэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 55% эрчимжүүлэх шаардлагатай байсан. Үр дүнгүй 4 зорилтын 9 арга хэмжээг эрчимжүүлж, хэрэгжилтийг хангах тухай хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын 2024/02 дугаар зөвлөмжийг Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд хүргүүлсэн.

Жилийн эцсийн хэрэгжилтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс тус бүрээр нэгтгэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 97%, “Тодорхой үр дүнд хүрсэн”.

Стратегийн зорилгууд	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй (100)	Тодорхой үр дүнд хүрсэн (70-100)	Эрчимжүүлэх шаардлагатай (30-70)	Үр дүнгүй (0-30)	Үнэлэх боломжгүй	Үнэлгээ (хувь)
Холбогдогч талуудын оролцоо, судалгаа, шинжилгээ, баримтад үндэслэсэн бодлого, шийдвэрийг боловсруулж, төлөвлөж хэвшинэ.	25	33	29	3	1			98%
Хяналт-шинжилгээний үр дүнд тулгуурлан бодлого, шийдвэрийн төлөвлөлт, зохицуулалтыг хийж хэвшинэ.	2	6	5				1	100%
Бодлого, шийдвэрийн үнэлгээний бие даасан, найдвартай байдлыг хангаж, хэрэглээг нэмэгдүүлнэ.	1	2	2					100%

Стратегийн зорилгууд	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй (100)	Тодорхой үр дүнд хүрсэн (70-100)	Эрчимжүүлэх шаардлагатай (30-70)	Үр дүнгүй (0-30)	Үнэлэх боломжгүй	Үнэлгээ (хувь)
Мэдээллийн ил тод байдлыг хангаж, дэвшилтэт технологид суурилан түргэн шуурхай хүргэнэ.	5	11	11					100%
Мэргэшсэн, туршлагатай, бүтээлч хандлагатай, хүний нөөцийг бүрдүүлнэ.	2	5	5					100%
Байгууллагын дотоод үйл ажиллагаа бүрэн уялдаатай болсон байна.	3	41	38	2	1			98%
Төрийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлнэ.	8	11	9		1	1		87%
Нэмэлт ажил БОАЖЯ, БХБЯ-ны зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх хүрээнд	7	12	8	1			3	91%
НИЙТ ДҮН	53	121	107	6	3	1	4	97%

Засаг даргын Тамгын газрын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэл



Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайланг нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/1106 дугаар захирамжийн хавсралтаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 2 дугаар хавсралтад заасан бүтцийн дагуу хагас, бүтэн жилээр тус тус нэгтгэн тайлагнасан.

Хүний нөөцийн чиглэлээр:

Засаг даргын Тамгын газар, хороо болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албаны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын захиалгыг холбогдох газарт хүргүүлсэн.Үүнд;

1.Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 03/159 дугаартай албан бичгээр сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж, захиалгын дагуу нийт 22 албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулагдсан. Шалгалтад Засаг даргын Тамгын газрын удирдах 1, гүйцэтгэх 11, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн албан тушаалд 2, нийт 14 иргэн хамрагдаж тэнцсэн бөгөөд Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх Салбар зөвлөлийн “Нэр дэвшүүлж, санал болгох тухай” 2024 оны 48, 49, 50, 51, 52, 53, 54, 55, 56, 57, 58, 84, 87, 88 дугаар тогтоолыг үндэслэн иргэдийг албан тушаалд томилж, томилсон шийдвэрийг ЗДТГ-ын даргын 2024 оны 03/512, 03/736 дугаартай албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн.

2.Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 03/558 дугаартай албан бичгээр сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж, захиалгын дагуу нийт 9 албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулагдсан. Шалгалтад Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэх албан тушаалд 5 иргэн хамрагдаж тэнцсэн бөгөөд Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх Салбар зөвлөлийн “Нэр дэвшүүлж, санал болгох тухай” 2024 оны 156,157,158,159 дүгээр тогтоолыг үндэслэн иргэдийг албан тушаалд томилж, томилсон шийдвэрийг ЗДТГ-ын даргын 2024 оны 03/1113 дугаартай албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн.

3.Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 03/1086 дугаартай албан бичгээр нийт 5 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн бөгөөд захиалгын дагуу төрийн албаны тусгай шалгалт зарлагдаагүй байна.

Тайлант хугацаанд нийт 5 удаагийн захиалгаар 38 албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын тусгай шалгалтад тэнцсэн 25 иргэнийг Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид 100 хувь нийцүүлэн албан тушаалд томилох ажлыг зохион байгуулсан бөгөөд 13 албан тушаалд иргэн бүртгүүлээгүй болон бүртгэл цуцлагдсан тул нөхөгдөөгүй албан тушаалын сул орон тоог нөхөх захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд тухай бүр хүргүүлсэн. Монгол Улсын ерөнхийлөгчийн 2024 оны 84 дүгээр зарлигаар шинэчлэн батлагдсан журмын дагуу төрийн захиргааны албан тушаалд жинхлэн томилогдсон 19 албан хаагчийг 2024 оны 7 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлэх ёслолын арга хэмжээнд хамруулах ажлыг зохион байгуулсан.

Албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн чиглэлээр:

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэгт заасан Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хөтөлбөрийн хүрээнд "Засаг даргын Тамгын газар болон хороодын төрийн албан хаагчийн сургалт хөгжил, ёс зүй, сахилга хариуцлагын чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө"-г батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын 20 арга хэмжээ 95 хувь хэрэгжсэн.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/97 дугаар тушаалаар томилогдсон Ёс зүйн дэд хороо нь 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан 3 зорилтын хүрээнд 14 арга хэмжээ 96 хувь хэрэгжсэн.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дүгээр зүйл, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж, төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах,

хариуцлагатай төрийн албыг сахиулах, хяналт тавих зорилгоор Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврыг дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, хороо, цэцэрлэг, сургууль, орон нутгийн өмчит байгууллага, нийт 100 байгууллагын удирдлагуудад 2024 оны 03/614 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хорооны 3 удаагийн хурлаар 13 албан хаагчид холбогдох 17 өргөдөл гомдлыг хэлэлцэж, 3 албан хаагчид ёс зүйн зөрчил тогтоогдсон бөгөөд хурлын дүгнэлтийг тухай бүр шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан, гомдол гаргагч иргэнд хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Удирдлагын академиас 2024 оны 3 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулсан “Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах” сургалтад дэд хорооны гишүүд, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг таниулах, ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг танилцуулах” сургалтад ЗДТГ, хорооны 120 албан хаагч, авлига, ашиг сонирхол, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх видео шторк, нөлөөллийн арга хэмжээнд нийт 150 албан хаагч болон хороодын 230 хэсгийн ахлагчдыг тус тус хамруулсан.



Байгууллагын соёл, үйл ажиллагаанд илэрч буй ёс зүй, сахилга хариуцлагын зөрчлийг үнэлэх, шалтгаан нөхцлийг илрүүлэх цахим судалгаанд ЗДТГ-ын 68 албан хаагчдыг хамруулсан ба иргэдээс төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд үндэслэн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхээр ЗДТГ-ын 1 хэлтэс, 5 албан хаагчид Ёс зүйн дэд хорооны зөвлөмжийг хүргүүлсэн.

Хороодын албан хаагчдад хуваарийн дагуу 11 хороонд Засаг даргын захирамж, илтгэх хуудас, хурлын тэмдэглэл, хорооны үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах чиглэлээр 89 удаагийн арга хэмжээгээр мэргэжил арга зүйгээр хангасан. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, албан хаагчид, хорооны Зохин байгуулагч нарыг хамруулсан хэлтсийн хурлыг 4 удаа зохион байгуулж, хурлаас өгсөн 11 үүрэг даалгаврын хэрэгжилтийг 100% хангуулсан.



Хороодын албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр:

Монгол Улсын засаг захиргааны анхан шатны нэгж болох хорооны албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулах, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 21/03 дугаар тогтоолоор батлагдан хэрэгжиж байгаа “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан

хаагчдын чадавхи бэхжүүлэх” хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд харилцан суралцах ажлын байран дээрх сургалт, арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр 3 дугаар хорооны байранд зохион байгуулж, дүүргийн 25-н хорооны нийт 29 албан хаагчийг хамруулсан.

Хорооны Зохион байгуулагчдын дунд 2 удаагийн олон нийтийн арга хэмжээг зохион байгуулсан. Боулинг, дартсын тэмцээнийг 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр, Сэлэнгэ аймгийн Сайханы хөтөл, Тужын нарсаар аялах арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 25-27-ны өдрийн хооронд тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор 59-н Зохион байгуулагчийг хамруулсан.



Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:

Төрийн гадаад бодлого үйл ажиллагааны нэгдсэн байдлыг сайжруулах, байгууллага хоорондын гэрээ байгуулах чиглэлээр гарсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01/01, 2014 оны 46/26 дугаар зөвлөмж, Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”, Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ыг гадаад харилцаатай холбоотой үйл ажиллагаандаа мөрдөж, гэрээ, хэлэлцээр болон санамж бичигт тусгаж хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Шилийн гол аймгийн Эрээн хотын Улс төрийн зөвлөгөөний дарга Чао Ге тэргүүтэй 6 төлөөлөгчийг 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Засаг даргын орлогч Б.Цэрэн, Засаг даргын Тамгын газрын дарга С.Энхбаяр тэргүүтэй төлөөлөгчид хүлээн авч уулзсан. Тус уулзалтаар хоёр хотын төр хувийн хэвшлийн байгууллагуудын уялдаа холбоог хангаж байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй болон худалдаа үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр харилцан тохиролцсон.

Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Шилийн гол аймгийн Эрээн хотын дэд дарга Жан Инжие тэргүүтэй 4 төлөөлөгчийг Хан-Уул дүүргийн Засаг дарга Б.Цэрэн тэргүүтэй төлөөлөгчид 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хүлээн авч, айлчлалын хүрээнд хотуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, соёлын арга хэмжээ зохион

байгуулах, ерөнхий боловсролын сургуульд Хятад хэлний багш ажиллуулах зэрэг асуудлын талаар санал солилцсон.

Хан-Уул дүүргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд албан томилолтын шийдвэр, холбогдох баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд:

- Бүгд найрамдах Солонгос Улсын Улсан хотын Нам дүүрэгт 01 дүгээр сарын 25-28-ны өдрүүдэд 16 хорооны Засаг дарга нарыг,
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Манжуур, Хайлаарт 25 хорооны 226 хэсгийн ахлагчдыг 2024 оны 05 дугаар сарын 01-12-ны өдрүүдэд,
- Япон Улсын Осака хотод ЗДТГ-ын 10, хорооны 7 ажилтан, албан хаагчдыг 2024 оны 05 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд,
- Бүгд найрамдах Солонгос Улсын Жежү хотод Засаг даргын Тамгын газрын Засаг даргын шуурхай ажил хариуцсан ажилтан Ц.Дорждэрэмийг 2024 оны 05 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд,
- Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх Улсын бүртгэлийн хэлтсийн 11 албан хаагчид 2024 оны 09 дүгээр сарын 06-10-ны өдрүүдэд Япон улсын Токио хотод,
- Бүгд найрамдах Солонгос Улсын Улсан хотын Нам дүүргийн Засаг даргын урилгаар Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Мөнхгэрэл тэргүүтэй 6 хүний бүрэлдэхүүнтэй Засаг даргын Тамгын газрын албан хаагчид Бүгд Найрамдах Солонгос Улсын Улсан хотын Нам дүүрэгт 2024 оны 9 дүгээр сарын 26-ны өдрөөс 9 дүгээр сарын 29-ний өдрүүдэд,
- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/88 дугаар тушаалаар томилогдсон бүрэлдэхүүн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Г.Туяацэцэгээр ахлуулан Бүгд Найрамдах Солонгос Улсын Гёнсан аймгийн Хаман суманд 2024 оны 10 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд тус тус албан томилолтоор ажиллуулсан.



Засаг даргын зөвлөлийн хурал, шагнал:

Засаг даргын 2024 оны А/692 дугаар захирамжаар Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж нийт 9 гишүүнтэй болсон. Тус хурлаар хэлэлцүүлэх асуудлыг тухай бүр батлуулж, журмын дагуу 7 хоног бүр тогтмол зохион байгуулж ажилласан.

2024 оны жилийн эцсийн байдлаар 45 удаагийн зөвлөлийн хурлыг зохион байгуулж, нийт **206** асуудал хэлэлцэгдэж, 96 үүрэг даалгавар өгөгдсөн байна. Хэрэгжилтийн явц **90%**-тай байна. Зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэр хэрэгжилтийг тухай бүр холбогдох хэлтэс, нэгжүүдэд хүргүүлэн үүрэг даалгавар, биелэлтийг хугацаанд өгч ажилласан.

Төрийн болон төрийн бус байгууллага боловсрол, эрчим хүч, хөнгөн үйлдвэрийн салбарт үр бүтээлтэй олон жил ажилласан **809** иргэнийг төрийн дээд одон медалиар шагнуулахаар нэр дэвшүүлсэн материалыг хянан шалгаж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4, 8, 11, 23 дугаар тогтоолоор хэлэлцүүлэн батлуулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.



Боловсрол, эрчим хүч, хүнс хөдөө аж ахуй, эрүүл мэнд, спорт болон бусад салбарт үр бүтээлтэй олон жил ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын 302 ажилтан, албан хаагчдыг салбар яамны “Салбарын тэргүүний ажилтан”, “Жуух бичиг”-ээр шагнуулах Засаг даргын дэмжих бичгийг гарган яамдад хүргүүлсэнээс 90% шагнагдсан байна.

Алдарт эхийн I, II дугаар одонгоор шагнагдсан 805 эхчүүдийн холбогдох баримтыг НЗДТГ-т хүргүүлж, 2024 оны 05 дугаар сарын 20-ний өдөр одон гардуулах үйл ажиллагааны бэлтгэл ажил болон дүүргийн Засаг даргаас алдарт эхийн одонт эхчүүдэд мэндчилгээ хүргэх арга хэмжээг зохион байгуулсан.



Хан-Уул дүүргийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнагдах хүсэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллагын ажилтан албан хаагчдын шагналыг материалыг хүлээн авч **186** иргэнд тэмдэглэлт ойн өдрийг тохиолдуулан “Хүндэт тэмдэг”-ээр шагнаж урамшуулсан.

Санхүү, бүртгэлийн чиглэлээр:

Дүүргийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөг батлуулан, Засаг даргын Тамгын газар болон 25 хороодын албан хаагчидтай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг шинэчлэн байгуулсан. Дүүргийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг нийт 10 удаа зохион байгуулан, 18 ажлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/52 дугаар тушаалаар 25 хороод, албан хаагчдын өмчид байгаа эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн хагас жилийн тооллогыг зохион байгуулсан.

2024 оны хагас жилийн байдлаар дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 15 ажлыг техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авч дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3,217,459,027 төгрөгийн бараа материал, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 7,960,681,610 төгрөгийн эд хөрөнгийг холбогдох хэлтэс албадын данс бүртгэл болон Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлд бүртгэсэн. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/301 дүгээр захирамжаар дүүргийн төр захиргааны хуучин барилгыг буулгах шийдвэр гаргуулан Засаг даргын Тамгын газрын 2024 оны А/53 дугаар тушаалаар данс бүртгэлээс хассан.


Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангасан харилцахын гүйлгээнүүдийг хянаж баталгаажуулсан.

Засаг даргын Тамгын газрын үндсэн дансаар 1527 ширхэг баримтаар 8,084,952,123.09 төгрөг, дүүргийн хөрөнгө оруулалтын харилцахын дансаар 93 компанийн 12,120,503,138.9 төгрөгийн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулсан.

Дансны төрөл	I улирал, мян.төг	II улирал, мян.төг	2024 оны I хагас жил, мян.төг
Засаг даргын Тамгын газрын үндсэн дансаар	3,772,816	4,312,136	8,084,952
Дүүргийн хөрөнгө оруулалтын харилцахын дансаар	1,265,389	10,549,299	12,120,503

Мөн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн харилцахын дансны 7 удаагийн нийт 26,582,000 төгрөгийн гүйлгээг холбогдох баримтыг үндэслэн хянан баталсан.

Санхүүгийн анхан шатны баримтад тулгуурлан бараа материал, хангамжийн 925 ширхэг баримтаар 1,341,580,402 төгрөгийн орлогын гүйлгээ шивж, Засаг даргын Тамгын газар, хороодын албан хаагчдын ашиглаж буй 35,250,100 төгрөгийн хангамжийн материалыг хариуцсан албан хаагчдад шилжилт хөдөлгөөнөөр бүртгэсэн.



Бараа материалын нийт 996,869,065 төгрөгийн 875 зарлагын гүйлгээг баримтад үндэслэн зарлагадаж холбогдох тайлан, баримт бичгийн бүрдэлд хяналт тавьсан.

Зарлагын гүйлгээний зориулалт:

- Бичиг хэрэг 111,005,825₮
- Тээвэр, шатахуун 65,125,480₮
- Сэлбэг хэрэгсэл 9,862,100₮
- Хүнсний материал 85,752,080₮
- Бусад хангамжийн материал 752,123,580₮

2024 оны 1 дүгээр сард түрээсийн байртай 3, 15, 17, дүгээр хороодын түрээс, цахилгаан, дулаан, усны гэрээнүүдийг холбогдох байгууллагуудтай шинэчлэн байгуулсан. Мөн 4, 5, 6, 7, 8, 9, 16, 12, 14, хороодын бохирын гэрээ, 12, 23, 24, дүгээр хорооны иргэдэд үйлчлэх төв байрны дулаан, цахилгааны гэрээг шинэчлэн байгуулсан. Хороодын байрны түрээс, ашиглалтын зардалд төлбөр тооцоо хийж өр төлбөргүй ажилласан.

Мэдээлэл технологийн чиглэлээр:

Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны тоглоомын талбайд утасгүй интернэтийн төхөөрөмж суурилуулж, “Санке дабл ви” ХХК-тай хамтран 1 жилийн гэрээ байгуулж, шилэн кабелийн арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээг гүйцэтгүүлэхээр хамтран ажиллаж байна. Дүүргийн 4, 10, 12, 13, 14, 16, 21, 24 хороодод үүссэн шилэн кабелийн гэмтлийг тухай бүр засварлаж, иргэдэд үйлчлэх төв байрны 3, 5, 6, давхар болон 1, 2, 4, 8, 9, 10, 11, 23 дугаар хороодын дотоод сүлжээний холболтыг шинэчлэн байгууллагын сүлжээний хэвийн үйл ажиллагааг

Д/д	Үйлчилгээний төрөл	Жилийн эцэс (өссөн дүнгээр)
1	Эд хөрөнгийн эрхийн бүртгэл	25241
2	Хуулийн этгээдийн бүртгэл	14584
3	Иргэний бүртгэл	34760
4	Гадаад паспорт	8165
5	Нотариат	17688
	Нийт	100,438

хангасан.

Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны бичил цэцэрлэгт хүрээлэнд болон 120-н автобусны буудлын 2 талд байршсан дулаахан автобусны зогсоолд өндөр хурдны Wi-Fi интернэтийг байршуулах ажлыг зохион байгуулсан. Давхардсан тоогоор өдөрт 50-60 иргэд утасгүй интернэт ашиглаж байна.

Засаг даргын Тамгын газрын 10 албан хаагчдад иж бүрэн компьютер, 5 принтер, 25 хороодод тус бүр 1 иж бүрэн компьютер, 10 хороонд принтер, 6 хороонд ухаалаг дэлгэц, иргэдэд үйлчлэх төв байрны нэг цэгийн үйлчилгээний танхим болон хурлын Б танхимд тус бүр 75 инчийн дэлгэц, сургалтын танхимын LED дэлгэц, тоног төхөөрөмжийг тус тус шинээр суурилуулах, угсрах ажлыг зохион байгуулж, сервер болон компьютер техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах хяналт шалгалтын үр дүнд 50 компьютерийн засвар үйлчилгээ, 75 хэрэглээний программ хангамжийг шинэчилсэн.

Нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагааны талаар:

Дүүргийн нэг цэгийн үйлчилгээний 11 цонхоор 69 төрлийн үйлчилгээг 2024 оны жилийн эцсийн байдлаар 88040 иргэн авсан. Мөн иргэдэд зориулан ТҮЦ машин, улсын бүртгэлийн лавлагааны болон гадаад паспорт захиалах автомат машин, улсын бүртгэлийн хураамж, газар зохион байгуулалтын хураамж, татвар, торгууль, шүүхийн тэмдэгтийн хураамж гэх мэт үйлчилгээг хялбар, шуурхай шийдэх боломжтой Гэрэгэ киоск төхөөрөмжөөр 60690 иргэн үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн.


Иргэдэд үзүүлсэн буцалтгүй тусламж:

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан “Хан-Уул дүүргийн иргэдэд нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай журам”-ын хэрэгжилтийн хүрээнд мөнгөн тусламж хүсч, шаардлага хангасан нийт 219 иргэнд дүүргийн Засаг даргын 13 удаагийн захирамжаар 102,580,000 (нэг зуун хоёр сая таван зуун наян мянга) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгох ажлыг зохион байгуулсан.

Дүүргийн санхүү, төрийн сангийн чиглэлээр:

Нэгтгэлийн программд 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан өгвөл зохих нийт 19,651 аж ахуйн нэгж, байгууллагаас 14,667 тайлан буюу 74.6%-ийг цахим системээр ирүүлсэн байна. Үүнээс 14,411 байгууллага буюу 73.3%-ийг баталгаажуулж, 256 байгууллагын алдаатай болон аудитын байгууллагын нэрийн баталгаажуулалт хийгдээгүй тайланг буцаасан бөгөөд 4,900 гаруй аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд арга зүйн зөвлөгөө өгсөн. Мөн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу 6 аж ахуйн нэгж, байгууллага, 8 нягтлан бодогч нарт шийтгэл оногдуулж, нийт 27.2 сая төгрөгийг дүүргийн төсөвт төвлөрүүлэн, зөрчлийг арилгуулан ажилласан.

Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 7 зөрчлийн материалыг тухай бүрт нь дүүргийн Прокурорын газарт хянуулсан. 2024 оны 01 дугаар сарын 15-ны өдөр Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст шийтгэлийн хуудасны тооцоог хүргүүлсэн.



Орон нутгийн байгууллагуудад олгосон санхүүжилт:

2024 оны орон нутгийн байгууллагууд хөтөлбөр болон орлого, зардлын төсвийн сар, улирлын хуваарийг иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан төсвийн дагуу боловсруулж хэлтсийн даргаар хянуулан, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж тухайн байгууллагад хүргүүлж, хяналт тавьж ажиллаж байна. Төсвийн орлого, зарлагын жилийн болон сар, улирлын хуваарийг төсвийн төлөвлөлтийн Фискал програмд байгууллага бүрээр оруулан нэгтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст илгээн байгууллагуудын төсвийн зарцуулах эрхийг нээлгэж, зарлагын гүйлгээ хийх нөхцлийг ханган 01-12 дугаар саруудын санхүүжилтийг бүрэн хуваарилсан.

Улсын төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны орлого, даатгалын төлбөр, нэр данс зөрүүгийн болон бусад орлого, нэмэлт санхүүжилт, улсын төсвийн байгууллагуудын санхүүжилт, үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогыг эдийн засгийн ангилал, хөтөлбөр зориулалт тус бүрээр нийт 1,192 удаагийн бичилтээр задалж гүйцэтгэсэн.

Нийгмийн салбарын байгууллагуудад олгосон санхүүжилт: Нийгмийн салбарын байгууллагуудын байр ашиглалтын тогтмол зардлын 12,160.0 сая төгрөгийн батлагдсан төсвийг байгууллага тус бүрээр төсвийн сар, улирлын хуваарийг хийж батлуулан, зарцуулах эрхийг хуваарийн дагуу нээн, төсвийн гүйцэтгэлд сар бүр хяналт тавин ажилласан.

Дүүргийн эрүүл мэндийн төвүүдийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал орон нутгийн төсвөөс гарах болсонтой холбогдуулан тухайн байгууллагын 2023 оны төсвийн гүйцэтгэлд үндэслэн тус дүүргийн Эрүүл мэндийн төвд 180.0 сая төгрөг, Нэгдсэн эмнэлэгт 386.0 сая төгрөг, Туул тосгоны хүн эмнэлэгт 152.0 сая төгрөгийг тус тус төлөвлөн орон нутгийн төсвөөс санхүүжилт авах шинэ дансыг нээлгэн, 2024 оны 3 дугаар сараас 12 сар хүртэлх төсвийн хуваарийг хийн төлөвлөлтийн баазыг татуулж, санхүүжилтийг бүрэн олгох эрх нээгдэн, 12 сарын байдлаар 575.7 сая төгрөгийн санхүүжилт олгон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй хангах нөхцөл бүрдүүлэн ажиллаж байна.

Төрийн сангийн үйлчилгээний талаар: Төрийн сан банк нь харилцагч төсөвт байгууллагуудын дансны нэгдсэн жагсаалт гаргаж, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдэд хуваарилан, Засгийн газрын санхүү, удирдлагын мэдээллийн системээр 581 ширхэг 7,992.1 сая төгрөг, Төрийн сангийн удирдлагын цахим системээр 37,807 ширхэг 645,301.7 сая төгрөгийн гүйлгээг ажлын 3 хоногт багтаан алдаагүй хийж гүйцэтгэсэн байна. Төрийн сангийн удирдлагын цахим системд 1816 ширхэг 24,822.2 сая төгрөгийн гүйлгээг холбогдох журмын дагуу хянан буцаан санхүүгийн эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажилласан.

Дүүргийн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд орон нутгийн 21, орон нутгийн төсвийн цэцэрлэг 40, сургууль 24, нийт 85 байгууллагын мэдээ нэгтгэгдэн 01-11 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг Сангийн яамны програмтай тулган баталгаажуулсан. Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, дүүргийн Статистикийн хэлтэст дүүргийн орлого, төсвийн байгууллагуудын зарлагын мэдээ, бусад холбогдох мэдээллийг сар бүр нэгтгэн хүргүүлсэн.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Захиргааны актын эрх зүйн үндэслэлийг хянан, биелэлтийг тооцох чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 784 захирамж, ЗДТГ-ын даргын 321 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, 368 захирамжийн хэрэгжилтийг тооцсон бөгөөд, биелэлт 92.3% буюу хангалттай хэрэгжсэн.

Гэрээний эрх зүйн үндэслэлийг хянах, бүртгэлжүүлэх чиглэлээр:

Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан 749 гэрээний эрх зүйн үндэслэлийг хянан бүртгэлжүүлсэн.

Шүүхэд төлөөлөх, хууль хяналтын байгууллагатай харилцах чиглэлээр:

Иргэн, хуулийн этгээдээс гаргасан нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн шүүхэд 11, Иргэний хэргийн шүүхэд 7, нийт 18 хэрэгт итгэмжлэлийн үндсэн төлөөлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байна.

2024 онд анхан шатны шүүхийн хуралдаанд 37, давж заалдах шатны шүүхийн 9 нийт 46 хуралдаанд цахимаар болон танхимаар оролцсоноос:

- Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 2,
- Актын биелэлтийг түдгэлзүүлсэн 1 хэрэг маргаан
- Нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн 4 хэрэгт тус тус төлөөлөн оролцсон.

Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр:

“Хууль эрх, зүйн хэлтсээс зохион байгуулах сургалтын төлөвлөгөө”-г дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан Хууль зүй, дотоод хэргийн яам, Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар, Монгол Улсын сонгуулийн ерөнхий хороо, дүүргийн Прокурорын газар, Онцгой байдлын хэлтэс, Татварын хэлтэс, “Хууль зүйн туслалцааны төв”-ийн Хан-Уул дүүрэг дэх салбартай хамтран сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.

Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний дагуу эрх зүйн 10 сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 1850 иргэн, албан хаагчийг хамруулсан. Үүнд:

1. Татварын ерөнхий хууль, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль,
2. Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль,
3. “Хууль эрх зүйн мэдлэг олгох” гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт,
4. Монгол улсын Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Шүүхийн үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо сэдэвт сургалт,
5. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай хуулийн төслийг боловсруулан, олон нийтэд танилцуулах хэлэлцүүлэг,
6. Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх сургалт,
7. Зөрчлийн тухай хуулийн сургалт
8. Хувь хүний нууцын тухай хуулийн сургалт
9. Кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, цахим орчны зүй зохистой хэрэглээ, кибер аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, цахим ур чадварыг дээшлүүлэх “Цахимд зөв байя” сургалт,
10. Монгол Улсын анхдугаар Үндсэн хууль болон 1992 оны Үндсэн хуулийг тайлбарлан таниулах сургалтыг тус тус зохион байгуулсан.

2024 оны 03 дугаар сарын 28-ний өдөр Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газартай хамтран дүүргийн нэг цэгийн үйлчилгээний төвд шүүхийн “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгууллаа. Өдөрлөгийн арга хэмжээнд тус шүүхийн Тамгын газраас шүүхэд нэхэмжлэл гаргахад ямар баримт бүрдүүлэх, шүүхэд мэдүүлэх эрхийн тухай болон шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа, эвлэрүүлэн зуучлалаар хэрэг маргааны шийдвэрлүүлэхийн ач холбогдол, мөн шүүхийн журмаар гэрлэлт цуцлуулах, хүүхдийн асрамж, тэтгэмж, ажилласан жил тогтоолгох гэх мэт иргэдэд тулгамдсан асуудлаар зөвлөгөө мэдээллийг хүргэсэн.



• Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй сууц өмчлөгчдийн холбоодод 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын хэлтэс, Татварын хэлтэс, Прокурорын газартай хамтран “Иргэдийн эрүүл аюулгүй орчныг хангуулах, Хууль эрх зүйн мэдлэг олгох, Гамшиг осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, татварын тайлан тайлагнах мэдээлэл олгох” болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж 121 сууц өмчлөгчдийн холбоо хамрагдан мэдээ мэдээлэл хүргэн ажилласан.



Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны “Менежмент төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг талуудын оролцоотойгоор үнэлэх, шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд дүүргийн иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, судлаачдын төлөөллийг оролцуулсан хамтарсан сургалт, хэлэлцүүлгийг 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт 52 хүн оролцсон.



• Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт заасны дагуу сонгуулийн хэсгийн хорооны бүрэлдэхүүнд ажиллах төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад 2024 оны 02 дугаар сарын 26-ний өдөр цахимаар сургалт зохион байгуулсан. Тус сургалтад 110 хүн оролцсон.

• 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Хан-Уул дүүргээс сонгогдон шүүхэд иргэдийн төлөөлөгчөөр оролцох иргэд, хороодын хэсгийн ахлагч нарт дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газартай хамтран шүүхэд иргэдийн төлөөлөгчийн оролцоог нэмэгдүүлэх, шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцохын ач холбогдол, Эвлэрүүлэн зуучлалын талаар сургалт зохион байгууллаа. Тус сургалтад 95 иргэн оролцсон.

- 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай хуулийн төслийг боловсруулан, олон нийтэд танилцуулах хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Тус хэлэлцүүлэгт хороонд үйл ажиллагаа явуулдаг Сууц өмчлөгчдийн холбооны удирдлага болон иргэд оролцсон.



- Гэмт хэрэг гаргахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай" 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 20 дугаар мөрдөгчийн мэдэгдлийн дагуу хууль бусаар бэлтгэсэн ховор ургамал болох хуш модны үр идээ самрыг худалдан авахгүй байхаар сануулсан видео, шторк, Хан-Уул дүүргийн прокурортой хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх видео, шторк тус тус бэлтгэн фэйсбүүк группүүдээр байршуулан иргэд олон нийтэд таниулах, сурталчлан ажиллаж байна.



- Дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн шуурхай хурлын үүрэг даалгаврын дагуу 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр дүүргийн 1-25 хорооны Засаг дарга, зохион байгуулагч нарт "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн сургалт зохион байгуулсан.

- Онцгой байдлын байгууллагын хүсэлтээр албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор "Зөрчлийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийн сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 04-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад дүүргийн онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах, аврах 14, 30, 65 дугаар ангийн нийт 69 албан хаагч хамрагдсан.




- Кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, цахим орчны зүй зохистой хэрэглээ, кибер аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, цахим ур

чадварыг дээшлүүлэх “Цахимд зөв байя” сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад 55 албан хаагч хамрагдсан.

- Бүгд Найрамдах улсыг тунхаглаж, Анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан дүүргийн ЕБ-ын сургуулиудын ахлах ангийн сурагчдад Анхдугаар Үндсэн хуулийн түүхэн ач холбогдол, үзэл санааг таниулсан сургалт зохион байгуулсан. Сургалтад 72 сурагч хамрагдсан.

- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад үе тэнгийн дээрэлхэлт, цахим гэмт хэрэг, мөрийтэй тоглоом, утаат болон электрон тамхины хор нөлөө, хүний эрх, үүрэг, ёс суртахууны талаарх эрх зүй, ёс зүйн мэдлэг олгох болон гэмт хэрэг зөрчилд холбогдсон сурагчдад хууль, зүйн зөвлөгөө өгөх, дахин холбогдохоос урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ бүхий сургалтыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Прокурорын газар, дүүргийн Цагдаагийн газартай хамтран 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн ахлах ангийн 250 хүүхдэд сургалтыг зохион байгуулсан.



Нийгмийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, төрөөс баримталж буй бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, тайлагнах ажлын хүрээнд:

- “Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тулгамдсан асуудал” хэлэлцүүлгийг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран дүүргийн Соёлын ордонд зохион байгуулж, 8 эрүүл мэндийн байгууллага болох Нийслэлийн эрүүл мэндийн газар, Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв, Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв, Хүүхдийн сэргээн засах Хантуул төв, Нийслэлийн түргэн тусламжийн төвийн Хан-Уул салбар, Өрхийн эрүүл мэндийн төвүүд оролцож 60 гаруй мэргэжилтэн, албан хаагчдыг хамруулсан.



- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Хан Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Цахиур төмөр эмийн компанитай хамтран “Эрүүл хүүхэд-Эх орны ирээдүй” хөтөлбөрт өдөрлөгийг Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт

хэвтэн эмчлүүлж буй нийт 69 хүүхдүүдийг хамруулан 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан.

- “Дэлхийн дауны хам шинж өвчний эсрэг тэмцэх өдөр”-ийг дэлхийн улс орнууд 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдөр тэмдэглэдэг бөгөөд “Хэвшмэл ойлголтыг өөрчилъе” уриан дор тэмдэглэхийг НҮБ-аас уриалсан. “Шагри-Ла Улаанбаатар” зочид буудлын их танхимд Дэлхийн Дауны өдрийн баярыг Монголын Дауны холбоо, ХУД-ийн Засаг даргын Тамгын газар, Нэгдсэн эмнэлэг хамтран тэмдэглэх үйл ажиллагааг зохион байгуулсан. Эрүүл мэндийн боловсрол, мэдээллийг нийт 300 гаруй үйлчлүүлэгч нар түгээж ажилласан.



Жендэрийн үндэсний хорооноос МУ Ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр захирамжаар батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” танилцуулах 2024 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн сургалтад Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нийт 27 эмчийг хамруулсан.

Дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран “Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжье”, “Бага насны хүүхдийн эрүүл мэнд хөгжлийг хянах олон улсын чиг хандлага” 7 цагийн сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, 21 өрхийн эрүүл мэндийн төвийн 49 эмч нарыг оролцуулан зохион байгуулсан. Өрхийн эмч нарыг Нэгдсэн эмнэлгийн эрэгтэйчүүдийн кабинеттай очиж танилцуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн ба эрэгтэйчүүдийн кабинетын амбулаторийн үзлэгт Эрүүл мэндийн төв 287, Нэгдсэн эмнэлэг 1316, нийт 1603 иргэн хамрагдсан.

Азийн хөгжлийн сан, Эрүүл мэндийн төвтэй хамтран “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохицуулах зөвлөлийг чадавхжуулах сургалт”-ыг 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулж, ЭМТ, НЭ, ӨЭМТ-үүдийн 83 эмч оролцсон.

Монголын чанарын холбоотой хамтран “Чанар аюулгүй байдлыг хангах нь” сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулж өрхийн эрүүл мэндийн төвийн 34 эмчийг хамруулсан.



Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай судалгаа шинжилгээ хийж, хяналт тавих.

Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн гэрээг Дүүргийн засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нартай байгуулж баталгаажуулсан. Нийт 19 өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрээг баталсан. Мөн 2023 онд үйл ажиллагаагаа бүрэн хангалттай дүгнүүлж ажилласан өрхийн эрүүл мэндийн төвүүдэд талархал, өргөмжлөл гардуулсан.



Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан гэрээний хагас жилийн биелэлт дүгнэх ажлыг 2024 оны 06 дугаар сарын 5-10-ны хооронд, жилийн эцсийн гэрээний биелэлтийг дүгнэх ажлыг 12 дугаар сарын 5-10-ны хооронд зохион ажлын бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Тайлан мэдээг хагас жил, жилийн эцсээр Нийслэлийн Эрүүл Мэндийн газарт хүргүүлсэн.

Мэргэжлийн байгууллагуудтай хамтран хүний нөөцийг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулах ажлын хүрээнд: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Хан-Уул дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвийн холбооноос “Дуудлага” мэргэжлийн ур чадварын 1 дүгээр шатны уралдааныг 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр, 2 дугаар шатны уралдааныг 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдрүүдэд зохион байгуулж 300 хүн хармуулсан. Нийслэлийн аварга шалгаруулах III шатны уралдаан 2024 оны 05 дугаар сарын 18-д зохион байгуулагдсан бөгөөд дүүргээс шалгарсан 3 баг оролцсоноос 18 дугаар хорооны “Мэндсаруул өрх” өрхийн эрүүл мэндийн төв 3 дугаар байранд шалгарч амжилттай оролцсон.

Нэгдүгээр шатны уралдааны зураг

Хоёрдугаар шатны уралдааны зураг



Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээг сайжруулж, урьдчилан сэргийлэх үзлэгийн хувийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: Эрүүл Монгол өдөрлөгийг Ерөнхийлөгчийн Тамгын газар дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран төвийн бүсэд 2024 оны 05 дугаар сарын 29-нд, Яармагийн бүсэд 6 дугаар сарын 10-ны өдөр тус тус зохион байгуулж, Нийслэлийн эрүүл мэндийн үндэсний төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Dr.Chingun эмнэлэг, Alpha med эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвүүдээс оролцуулан үйлчилгээ үзүүлж нийт 5600 гаруй иргэдийн хамруулсан.

Хан-Уул дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Мэргэжил бүхэн сайхан” аянг 2024 оны 05 дугаар сарын 10-30-ны өдрүүдэд 12 удаа зохион байгуулах Дүүргийн Эрүүл мэндийн төвийн бүтэц, тасгуудын зохион байгуулалт, эмч мэргэжлийн онцлог, ажлын байрны үйл ажиллагаатай танилцуулах ажлыг өдөр бүр 5-6 сурагчдад танилцуулж, нийт 61 хүүхдийг хамруулсан байна.

Эрүүл мэндийн чиглэлээр энэ онд нийт 28 удаагын үйл ажиллагааг зохион байгуулж 7850 хүнийг хамруулсан байна.



Биеийн тамир, спортын чиглэлээр:

Нийтийн биеийн тамирын чиглэлээр 2024 онд 49 арга хэмжээнд 695 байгууллагын 36,870 иргэдийг хамруулсан.Үүнд:

1. "Хамтдаа хэвшүүлэе" 21 хоногийн аянд 21000 иргэн
2. Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хороо, Olympus gym хамтран зохион байгуулсан "Эко дүүргийн спортлог иргэн" өдөрлөгийн арга хэмжээнд 130 иргэн
3. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнд 18 цэцэрлэгийн 600 хүүхэд
4. Дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Cheerleading" хөгжөөн дэмжигчдийн аварга шалгаруулах тэмцээнд 9 сургуулийн 220 сурагч
5. "Улаанбаатар марафон-2024" олон улсын гүйлтийн арга хэмжээнд 126 байгууллагын 6100 иргэн
6. "Алхацгаая гүйцгээе" аяны хүрээнд явган алхалтад 35 байгууллагын 260 иргэн
7. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан өвлийн спортыг сурталчлах зорилгоор Хокейн тэмцээнд 25 байгууллагын 120 хүүхэд
8. Хан-Уул дүүргийн хүүхдийн баярын арга хэмжээг спортын 5 төрөлт тэмцээнд 25 байгууллагын 120 хүүхэд
9. "Авто машингүй өдөр 2024" 200 иргэн
10. Нийслэлийн Иргэдийн спортын XII наадамд 24 хорооны 6,558 иргэн
11. Соёлын бүтээлч сар 2024 явган аялалын тэмцээн боловсролын салбарын 80 байгууллагын 800 ажилтан
12. "Хамтдаа алхаад эрүүлжэе" явган алхалтын аянд 1400 иргэн
13. Биеийн тамир спортын хорооны 12 төрлийн сургалтад 128 байгууллагын 1143, Усан спорт сургалтын төвд 1,255 иргэнийг тус тус хамруулсан.



Дүүргийн Иргэдийн спортын XII их наадмыг 2024 оны 05 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд 3 үе шаттайгаар явган аялал, олс таталт, сагсан бөмбөг, волейбол, хийн дасгал, аэробик, софт волейбол, ширээний шагайн наадгай, дартс гэсэн спортын 9 төрлөөр байгуулж 24 хорооны нийт 6558 иргэнийг хамруулсан. Иргэдийн спортын XII их наадмын нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд 180 тамирчид оролцож, алтан медаль-3 сагсан бөмбөг (эр), волейбол (эр), дартс (эр), мөнгөн медаль-3 олс таталт (эр, эм), ширээний шагай (эм), хүрэл медаль-2 хийн дасгал, аэробик нийт 8 медалийн болзол хангаж багийн дүнгээр 1 дүгээр байр эзэлсэн.

Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг спортын 10 төрлөөр 10 дасгалжуулагч багштай, 641 тамирчин бэлтгэл сургуулилт хийж байна. Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагаанд 2024 оны орон нутгийн төсөвт 74.0 сая төгрөг тусгуулсан. Бочи спортын төрлөөр нийслэлийн 63 дугаар сургуультай хамтран хөгжлийн бэрхшээлтэй өсвөрийн тамирчдыг хичээллүүлэн шигшээ багийн тоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид: Улсын хэмжээнд спортын 16 төрлөөр 699 тамирчин оролцож алтан медаль 74, мөнгөн медаль 71, хүрэл медаль 91 нийт 236 багц медаль, Олон улсын 11 тэмцээнд 45 тамирчин оролцож алтан медаль 11, мөнгөн медаль 14, хүрэл медаль 11 хүртсэн. Улсын чанартай спортын уралдаан тэмцээнд спортын 8 төрлөөр 50 удаагийн тэмцээнд давхардсан тоогоор 2356 тамирчин оролцож, алт 76, мөнгө 78, хүрэл 108 нийт 262 медаль хүртсэн.



Соёлын чиглэлээр:

"Хотын соёлд-Бидний оролцоо" цахим контентын уралдааныг 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс 03 дугаар сарын 25-ны өдрүүдэд төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 10-12 дугаар ангийн сурагчид мөн төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын багш, ажилчид, эцэг эхчүүдийн дунд зохион байгуулж, 32 байгууллагын 1,500 гаруй иргэд, сурагчдыг хамруулан 42 бичлэг хүлээн авч, Насан туршийн суралцахуйн төвийн фэйсбүүк пэйж хуудсанд байршуулан 86,647 хүний хандалт, 10,566 лайк, 7,768 иргэн коммент, 13,052 иргэн шейр хийж олон нийтэд түгээсэн.



Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2017-2023 оны үйл ажиллагаа, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын талаарх тайланг танилцуулах, иргэдийн тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх ажлын талаарх санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор иргэдийн уулзалтыг зохион байгуулсан.

Үйл ажиллагааг дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байрны 9 давхрын хурлын танхимд 2024 оны 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулан дүүргийн 25 хороодын иргэдийн төлөөлөл 200 иргэн оролцсон.



Тулгар төрийн 2233 жил, Их Монгол Улсын 818 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113 жил, Ардын хувьсгалын 103 жилийн ой, Үндэсний их баяр наадам, Үндэсний хувцасны өдрийг тохиолдуулан Монголчуудын уламжлалт соёл, түүний дотор үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулагддаг “Дээлтэй Монгол наадам-2024” наадамд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, хороодын албан хаагчид, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, дүүргийн иргэд болон гадаадын иргэдийн төлөөлөл нийт 600 гаруй хүний бүрээлдэхүүнтэйгээр



оролцсон.

Монголын соёл, шашны зан үйлийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж, нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилготой “Даншиг наадам-Хүрээ цам” шашин, соёлын наадам 2024 оны 8 дугаар сарын 3,4-ний өдрүүдэд Хүй 7 худагт зохион байгуулагдсан. Ес дэх жилдээ зохиогдож байгаа тус наадамд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Соёлын ордон, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Хан Эко тээвэр ААТҮГ,



Соёлын ордны дэргэдэх “Уянга өөдөө” хамтлаг, дүүргийн соёлын биет бус өвийг өвлөн тээгч, авьяастнуудын хамт оролцож, наадмын соёлын талбай, Бөмбөгөр театрт 2 өдрийн турш хөтөлбөрийн дагуу тоглон, дүүргийн Соёлын өргөөндөө 1600 гаруй иргэд, жуулчдад өв соёлоо сурталчилсан.

Соёлын ордны авьяас хөгжүүлэх 6 төрлийн сургалтад нийт 218 хүүхэд хамрагдан хичээллэж байна. Өмнөх жилийнхээс 57 хувиар нэмэгдсэн. Үүнээс насны ангиллаар авч үзвэл: 7-18 насны 213, 18-35 насны 5 суралцагч байна. Эмэгтэй-123, Эрэгтэй-93. Хөгжлийн бэрхшээлтэй 3 хүүхдийг үнэ төлбөргүй хамруулж байна.





“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Соёлын өвийг дэлхий дахинд сурталчлах чиглэлээр олон улсын арга хэмжээг зохион байгуулна”, “Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, цар хүрээг өргөжүүлнэ” гэж тус тус заасан байдаг. Иймээс Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Фестиваль зохион байгуулах тухай” 41 дүгээр тогтоолоор “Нүүдэлчин” дэлхийн Соёлын фестивалийг жил бүр зохион байгуулж байхаар болсон.

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль 2024 оны 08 дугаар сарын 16-наас 18-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт орших “Тайж хайрхан”-ы бэлд зохион байгуулагдаж, Соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд Монгол Улсаас 880 өвлөн уламжлагч, 10 гаруй гадаадын улс орнуудын 150 гаруй төлөөлөл оролцсон. Тус фестивальд соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд Соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл, нийслэлийн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй Хан-Уул дүүргийн харьяат 3 өвлөн уламжлагчдыг оролцуулсан.

Зайсан толгой дахь “Зөвлөлтийн дайчдын дурсгалын цогцолбор”, “Хувьсгалт Монгол” танкны хөшөөний иж бүрэн тохижилт, засварын ажлыг 2024 оны 07-09 дүгээр сард ОХУ-ын Ленинград мужийн Засгийн газрын санхүүжилтээр “Шидэт Орос байшин” ХХК хийж гүйцэтгэсэн.

Засгийн газрын 2021 оны 179 дүгээр тогтоолоор Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад орсон Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байх “Туулын Хар түнийн ордны туурь”, 11 дүгээр хороонд байх “Богд хааны ногоон ордны цогцолбор”, “Богд хааны ногоон ордны өмнөх 2 ширхэг чулуун арслан”, Нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд байх “Богд хааны хүрэн ордны зарим байшин” зэрэг түүх, соёлын 4



дурсгалын хадгалалт, хамгаалалтыг гэрээгээр хариуцуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Богцон дахь соёлын өв, өвийн боловсролыг дэлгэрүүлэх, олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хүрээнд "Урлахуйг өвлөө" уулзалтыг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр дүүргийн Насан туршийн суралцахуйн төвд зохион байгуулж, гар урлал сонирхогч 84 иргэнийг хатгамалч, нэхмэлч, даалин урлаач, хайчилбар хийгч зэрэг соёл, уламжлалыг өвлөн уламжлагч харилцан туршлага солилцож, мэдлэг бүтээсэн, өв уламжлал, соёлын биет бус өвийг дээдлэн хүндэтгэх ёс заншлыг танилцуулсан.



Нийслэлийн Засаг даргын ивээл дор уламжлал болгон зохион байгуулагддаг Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншарвын нэрэмжит Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг шалгаруулах 30 дахь удаагийн уралдааныг 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 75 дугаар сургуульд зохион байгуулж, Хан-Уул дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн 19 сургуулийн 1,100 гаруй сурагч оролцсон. Тус наадмын 2 дугаар шатны шалгаруулалт 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Соёлын төв өргөөнд зохион байгуулагдаж, тусгай байранд Шинэ Монгол Харумафүжи сургуулийн "Шинэ зууны хүүхдүүд" хамтлаг, Д.Лувсаншаравын нэрэмжит шагналаар Хан-Уул дүүргийн 18 дугаар сургуулийн "Шуранхайн тэнгэр" хамтлаг, Монголын найрал дууны уран бүтээлчдийн холбооны нэрэмжит шагналаар Монгол дахь Канад сургуулийн "Нарны үрс" хамтлаг шалгарсан амжилтыг тус тус үзүүлсэн.



Дэлхийн 90 гаруй улс, 350 гаруй хотыг нэгтгэсэн Нэгдсэн Үндэстний байгууллагын Боловсрол шинжлэх ухаан, соёлын байгууллага ЮНЕСКО-гийн "Бүтээлч хотуудын сүлжээ" (UCCN)-нд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот 2023 онд ардын урлаг болон гар урлалын төрлөөр нэгдэн орсны дагуу "Бүтээлч салбарт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах, нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 385 жилийн ойн хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих зорилгоор нийслэлийн дүүрэг, хороо, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч аж ахуй нэгж, иргэдийн үйл ажиллагаа, амжилтыг олон нийтэд сурталчлан таниулж, урамшуулахад чиглэсэн "Бүтээлч хот" сэдэвт "Бүтээлч дүүрэг, Бүтээлч хороо, Бүтээлч байгууллага, Бүтээлч иргэн"-ийг шалгаруулах уралдаанд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороод, иргэд, аж ахуй нэгж байгууллагууд амжилттай оролцсон.

"Бүтээлч хот" сэдэвт уралдааны Бүтээлч дүүрэг, бүтээлч хороо номинацид Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Бүтээлч иргэн номинацид-3 иргэн, Бүтээлч аж ахуй нэгж номинацид-2 аж ахуй нэгжийн материалыг бүрдүүлэн Нийслэлийн Соёл, урлагийн газар хүргүүлснээс:

- “Бүтээлч хороо” төрөлд тэргүүн байр: Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо
- “Бүтээлч иргэн” төрөлд гуравдугаар байр: Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны иргэн, Монгол Улсын Гавьяат Багш Т.Дунжаа
- “Бүтээлч байгууллага” төрөлд гуравдугаар байр: “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв” УТҮГ
- “Бүтээлч дүүрэг” төрөлд гуравдугаар байр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар тус тус шалгарсан амжилтыг үзүүлсэн.



Боловсролын чиглэлээр:

Хан-Уул дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Мэргэжил бүхэн сайхан” аянг 2024 оны 05 дугаар сарын 10-31-ний өдрүүдэд зохион байгуулж байна. Аяны хүрээнд Төрийн албан хаагчдын ажлын нэг өдөр, мэргэжлээ сонгосон түүх, мэргэжлийн онцлогийг судалж танилцан мэргэжлийн талаар асуулт тавьж сонирхолтой яриа өрнүүлж 12 удаа зохион байгуулж нийт 600 гаруй хүүхэд хамрагдсан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг ерөнхий боловсролын 23 сургуулийн 1801, сургуулийн өмнөх боловсролын 37 байгууллагын 1399, нийт 3200 багш, ажилтнуудыг санал хүсэлтийг хүлээн авч холбогдох асуултад хариулан ажиллаж.



Дүүргийн Засаг дарга уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнд нийслэлийн тэргүүн байр эзэлсэн 250 дугаар цэцэрлэгийн тамирчин хүүхдүүдийг эцэг, эх, дасгалжуулагч багш, цэцэрлэгийн эрхлэгчдийн хамт хүлээн авч хүндэтгэл үзүүлэх, амжилтын баярыг хамт

хуваалцах арга хэжээг 2024 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулж 70 гаруй хүүхэд, эцэг эх оролцсон.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор, Монгол Улсын Засгийн Газрын дэмжлэгтэйгээр, Олон улсын гимнастикийн холбоо, Азийн гимнастикийн холбооноос “Жимнастрада-2024” соёл, спортын наадам 2024 оны 09 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд Буянт-Ухаа спорт цогцолборт Монгол улсаа төлөөлөн Э.Батнавч эрхлэгчтэй Хан-Уул дүүргийн 250 дугаар цэцэрлэгийн 30 бяцхан гимнастикчид, багш дасгалжуулагч нарын хамт амжилттай оролцож шилдэг үзүүлбэртэй баг хамт олон- Цом, цэцэрлэгийн насны ангилалд-Тэргүүн байр, алтан медалийн эзэд ажилтыг үзүүлсэн.



2024-2025 оны хичээлийн жилд тохиолдуулан Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Зөв хүүхэд-Зөв ирээдүй” дэд хөтөлбөрийн “Хүүхэд бүрийг сурч, хөгжих, төлөвших тэгш боломжоор хангах” хэмээн заасны дагуу 1 дүгээр ангид элсэн суралцах зорилтот бүлгийн хүүхдүүдэд хичээлийн хэрэгслийн иж бүрдэл олгох шийдвэрийг Засаг даргын зөвлөлийн 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 29 дугаар хурлаас гаргасны дагуу дүүргийн 19 хорооны 150 хүүхдэд хуваарийн дагуу гардуулах ажлыг зохион байгуулсан.



Хан-Уул дүүрэгт 2024 онд хэрэгжүүлж буй бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын онцлог ажлууд болон дүүргийн төсвийн хөрөнгөөр ерөнхий боловсролын 23 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 40 байгууллагуудад 2024 оны 09 дүгээр сарын



12-21-нд 841 ширхэг сүүлийн үеийн иж бүрэн зөөврийн компьютерийг багш нарт гардуулан өгсөн.

Хан-Уул дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад шатрын спортыг сурталчлах, шатрын спортоор хичээллэх сонирхлыг нэмэгдүүлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах “Их нүүдэл-2024” тэмцээнийг 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 75 дугаар сургуульд зохион байгуулсан.



Тус тэмцээнд төрийн болон төрийн бус өмчийн 27 сургуулийн 600 гаруй сурагч оролцож, оюун ухаанаа сорин өрсөлдсөнөөс 1-12 дугаар ангийн 72 сурагч шилдгээр шалгарч, батламж, алт, мөнгө, хүрэл медалийг гардуулах ажлыг зохион байгуулсан.

Нийслэлийн 385 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан Нийслэлийн Засаг даргын нэрэмжит өсвөрийн шатарчдын багийн аварга шалгаруулах “ИХ НҮҮДЭЛ” тэмцээнд дүүргээ төлөөлөн Нийслэлийн ерөнхий боловсролын 15 дугаар сургууль, “Орхон ХаСү” сургууль оролцсон.



Нийслэлийн ерөнхий боловсролын 15 дугаар сургууль 18 багын 432 тамирчнаас ТУСГАЙ байр эзэлж, “Орхон ХаСү” сургууль 7 дугаар байран эзэлсэн амжилтыг үзүүлсэн.

Нийгмийн хамгааллын чиглэлээр:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Хан-Уул дүүргийн орон тооны бус салбар зөвлөлийн хурлыг 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулан 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэж, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 бүлэг 20 үйл ажиллагаатайгаар баталж 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн.

Гэр бүлийн тухай болон Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу хүсэл гаргасан 14 иргэнд дүүргийн Засаг даргын захирамжаар харгалзан дэмжигч тогтоож, харгалзан дэмжих гэр бүлийн гишүүнгүй 2 иргэнийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулсан.

Хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөлийг дүүргийн Засаг даргын 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/228 дугаар захирамжаар байгуулав.

Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Хан-Уул дүүргийн иргэдэд нэг удаагийн буалтгүй тусламж олгох журам”-ын дагуу гэр хүссэн 2023-2024 онд гэр хүссэн өргөдөл өгсөн 135 өргөдлийг судлан

зайлшгүй шаардлагатай 58 өрхөд дүүргийн Засаг даргын 15 удаагийн захирамжаар 5 ханатай гэр олгосон.



Хараагүй иргэдийн эрхийг хамгаалах өдөр “Дэлхийн цагаан таягтны өдөр”-ийг тохиолдуулан 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр дүүргийн хараагүй 180 иргэнд хүнсний дэмжлэг олгосон.



“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс”-ын 24 удаагийн хурлаар 808 хүүхдийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд: 129 хүүхдэд шинээр байнгын асаргаа тогтоож, 18 хүүхдийн байнгын асаргааг цуцалсан. Өнөөдрийн байдлаар дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 1127, үүнээс байнгын асаргаанд 1034 хүүхэд байна. Комиссын үйл ажиллагаанд шаардлагатай бичиг хэрэг, цай, кофены зардалд 1.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 2024 оны байдлаар 1160 байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “18 ба түүнээс дээш насны хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг эрүүл мэндийн магадлалын зөвлөл дүгнэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэн үнэмлэх олгох үүргийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ.” хэмээн заасны дагуу 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хан-Уул дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй нийт 800 гаруй иргэдэд Хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэхийг олгосон. Дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөл 5000 гаруй иргэнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ тогтоосон байна.



Дүүргийн Улаан загалмайн хороо, Монгол дахь Солонгосын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгтэй хамтран 2024 оны 4 дүгээр сард дүүргийн нутаг дэвсгэрт амьдарч байгаа орон гэргүй иргэдийн дунд сүрьеэ, ХДХВ/БЗХӨ-ий эрт илрүүлэг, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг “Өлзийт асар” ТББ төвийн байранд зохион байгуулж, архины хамааралтай 72 иргэнийг хамруулсан.

Хан-Уул дүүргийн АА бүлэгтэй хамтран архинаас хор хөнөөл, архинд донтох эмгэгийн таниулах “Гашуунаар төгсөөгүй-Өнөөдрийн итгэл” өдөрлөгийг 2024 оны 3 дугаар сард зохион байгуулж, хорооны нийгмийн ажилтан болон архинаас татгалзах хүсэлтэй 50 иргэнийг оролцуулсан.



Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийн дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эхчүүдийн “Асуудал-Шийдэл” өдөрлөгийг 2024 оны 11 дүгээр сард зохион байгуулж, 125 эцэг эхчүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах арга зүй, тэдний онцлог хэрэгцээ, хооллолт, дүүргийн салбар комиссын үйл ажиллагааны мэдээлэл өгсөн.



Авлигатай тэмцэх газартай хамтран авлигыг үл тэвчих, нийгэмд учруулах хор уршгийг ойлгуулах сургалтыг 2024 оны 9 дүгээр сард зохион байгуулж 105 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулав.



"Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах Олон улсын өдөр"-ийг угтан Тусгай болон Пара Бочигийн дүүргийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сард зохион байгуулж 50 хүүхэд тус тус хамруулсан.

Австрали улсын Мельбурн хотноо зохион байгуулагдах Олон улсын сонсголын бэрхшээлтэй иргэдийн 3х3 сагсан бөмбөгийн холбооны Ази Номхон далайн бүсийн нээлттэй тэмцээнд оролцох баг тамирчдад 3.8 сая төгрөгийн дэмжлэг олгосон ба тус тэмцээнд 3х3 сагсан бөмбөгийн баг тамирчид мөнгөн медаль хүртсэнээр 2025 онд Японд зохион байгуулагдах 2028 оны паралимпийн олимпод оролцох эрхийн тоглолтод оролцох эрх авсан.



Хороодын байранд тэргэнцэртэй иргэнд зориулсан налуу зам хийх 250.0 сая төгрөгийн ХУДХААА0101009 дугаартай тэндерт "Нанобриллиант констракшн" ХХК шалгаран 9 хороо, 4 ӨЭМТ-ийн байранд налуу замын ажлыг хийж гүйцэтгэсэн.

2025 онд 1, 2, 13 дугаар хорооны налуу замыг стандартад нийцүүлснээр анхан шатны нэгжүүдийн барилга байгууламжийн тэргэнцэртэй иргэдэд хүртээмжтэй байдал 100 хувь хангагдана.



"Ахмадаа дээдэлье" дэд хөтөлбөрийн хүрээнд 5 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх саналыг боловсруулан дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөл, дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэд хөтөлбөрийн 366,427,700 төгрөгийн гүйлгээний баримтыг бүрдүүлэн, хөтөлбөрийн үр дүнд нийт 15,000 гаруй ахмад настанд хүрч ажилласан. Үүнд:

- "Цагаан сар" арга хэмжээнд 7200 гарын бэлгийг бэлтгэн хороодод хүргүүлсэн.
- 19 дүгээр хорооны Ахмадын хөгжлийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлсэн.
- 16-р хорооны ахмад настнуудын эрдсийн шинжилгээнд хамруулсан
- Хөдөлмөрийн баатруудын замнал
- "Ахмадын баяр" арга хэмжээг хороодод зохион байгуулахад шаардлагатай 126 сая төгрөгийн санхүүгийн баримтыг бүрдүүлэн санхүүд хүлээлгэн өгсөн.



Хөдөлмөр хамгааллын чиглэлээр:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран 2024 онд хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр зохион байгуулах 9 өдөрлөг арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 1 дүгээр сарын 24-ний дүүргийн Засаг даргын өдрийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд 2024 оны УИХ, орон нутгийн сонгуультай холбоотой цуцалсан.

Нийслэлийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газраас 2024 оны 5 дугаар сард зохион байгуулсан “Хөдөлмөр эрхлэлт 2024” арга хэмжээнд 280 иргэнийг хамруулан, 8 аж ахуйн нэгжийн сул ажлын байрыг иргэдэд танилцуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг авсан иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг танилцуулах, зөвлөгөө мэдээллээр хангах уулзалт зөвлөгөөнийг 2024 оны 9 дүгээр сард зохион байгуулж, 250 иргэнийг хамруулсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдын баталсан “Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе” уриатай улсын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян зохион байгуулах удирдамжийн дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг 2024 оны 4 дүгээр сард зохион байгуулж, 200 байгууллагын 215 хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнуудыг хамруулсан.



Барилгын салбар дахь үйлдвэрлэлийн ослыг бууруулах зорилгоор “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дарцаг аялах” аяныг дүүргийн Засаг даргын орлогч Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу зохион байгуулж, 2024 оны 4-9 дүгээр саруудад барилгын салбарын 14 аж ахуйн нэгжээр аялуулав.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 01/841 дугаар удирдамжийн дагуу дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 57 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн улсын үзлэг зохион байгуулсан.

Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 92 аж ахуйн нэгж байгууллагын 121 иргэний гомдлыг хүлээн авч, 26 гомдлыг хялбаршуулсан журмаар, 103 иргэний гомдлыг гурван талт хорооны 21 удаагийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн.

Дүүргийн Засаг даргын орлогч бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн даргын баталсан “Хөдөлмөрийн маргаанаас урьдчилан сэргийлэх тухай” удирдамжийн дагуу ахуйн үйлчилгээний ажилтнуудын “Чандмань” ТББ-тай хамтран 17 байгууллагын 177 хүнд хөдөлмөрийн маргаанаас урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулсан.

Засаг даргын Тамгын газар, хороодын албан хаагчдад өвөл, зуны улиралд шаардлагатай 6 нэр төрлийн хамгаалах хэрэгслийн судалгаа гаргаж, “Ажлын тусгай хувцас,

хамгаалах хэрэгсэл олгох, ашиглах журам"-ын төсөл боловсруулж, хэдий ч заавал жагсаалтаар батлах нь зүйтэй хэмээн шийдвэрлэсний дагуу "Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн жагсаалт"-ыг 12 дугаар сарын 15-нд жагсаалтыг батлуулав.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг 2 удаа зохион байгуулж, 163 ажилтныг хамруулсан. Үүнд:

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтнуудын "Алтан дуулга" холбоотой хамтран хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг 2024 оны 4, 11 дүгээр сард зохион байгуулж 21 нийгмийн ажилтан, 142 хэсгийн ахлагчдыг хамруулсан.



Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:

Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан тус дүүрэгт оршин суугаа эмэгтэйчүүд, одонтой ээжүүдэд хүндэтгэл үзүүлэх "Ээж бол ертөнц" арга хэмжээг хороодоор дамжуулан 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдрөөс 2024 оны 3 дугаар сарын 07-ны өдрийг хүртэлх хугацаанд батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулан 25 хорооны 7500 эмэгтэйчүүдийг хамруулсан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийн 5.2.6 дахь "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, шинэ жилийн баяр болон бусад нийтийн хэмжээнд зохион байгуулагддаг баяр ёслолын арга хэмжээнд хагас, бүтэн өнчин болон зорилтот бүлгийн хүүхдийн оролцоог тэгш хангаж ажиллана." гэсэн зорилтын хүрээнд нэгдсэн арга хэмжээг 2024 оны 6 дугаар сарын 01-ний өдөр Степ Арена төвийн гадна талбайд зохион байгуулан 5000 гаруй хүүхэд, багачуудыг хамруулан ажилласан.



"Тусч найзууд" бүлгэмийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, арга хэмжээнд оролцох эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжих зорилгоор энэ оны эхний хагас жилийн байдлаар явган алхалт, танилцах болон удирдлагын зөвлөлийн уулзалт, анхдугаар зөвлөгөөн зэрэг 4 удаагийн арга хэмжээ зохион байгуулж 93 эмэгтэйг хамруулсан.

Мөн тус бүлгэмийн гишүүдэд "Хувь хүний хөгжил"-ийн сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулан 25 хорооны нийт 50 эмэгтэйчүүд оролцож өөрийгөө таних чадвар, харилцааны чадвар, багийн ажиллагаа, шийдвэр гаргах чадвар, өөрчлөлтөд нээлттэй байдал, сэтгэл ханамжийн нэмэгдэл мэт олон зүйлсийг ойлгож, үүний дагуу өөрийгөө хөгжүүлэх замаа тодорхойлж сурцгаасан. Мөн тус бүлгэмийн эмэгтэйчүүдэд Хан-Уул дүүргийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын танилцуулгыг хийсэн.



Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1467 дугаар захирамжийн дагуу Электрон тамхины хор хөнөөлийн талаар 2 төрлийн постер, мэдээлэл бэлтгэн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс болон Цагдаагийн газар, 25 хороодын цахим хаягт байршуулж, нийтдээ 13,000 иргэд олон нийтэд хүрч ажилласан.

"Татагдаж болохгүй" уриан дор электорон тамхины хор нөлөөллийн таниулах, электорон тамхи худалдан авагчдад насны хязгаар тогтоох тухай захирамжийг сурталчлах, электрон тамхийг хэрэглэхгүй байх зөв үлгэр дуурайллыг үзүүлэхийг дэмжсэн богино хэмжээний бичлэг (рийл) -ийн уралдааныг дүүргийн ЕБС-ийн 10-12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулж, 28 сургуулийн 350 сурагч хамруулж, уралдаанд ирүүлсэн 14 бичлэгийг шалгаруулсан.



Хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр:

Түргэн үйлчилгээний цэг, ил задгай худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 2024 оны “Газрын зөрчил арилгаж, албадан чөлөөлөх арга хэмжээ авах тухай” А/27 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй байршуулсан, зорчих хэсгийг хаасан, эрүүл ахуйн шаардлага хангахгүй, орчны бохирдол ихээр үүсгэж буй 49 түргэн үйлчилгээний цэг, 30 тээврийн хэрэгслийг ачуулж, нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлөх ажлыг хороо болон дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран зохион байгуулсан. Үүнд

- 10, 12, 16, 25 дугаар хорооны иргэний 4 ТҮЦ
- 11-р хороо Туул голын зам дагуу 3 ТҮЦ,
- Наадамчдын зам, Нисэхийн зам дагуу 26 ТҮЦ;
- 15-р хороо Хурд хороолол доторх 1 ТҮЦ
- 11 дүгээр хороо, Туул гол дагуу явуулын үйлчилгээтэй түргэн хоолны үйлчилгээ эрхэлж буй 30 иргэн,
- Зайсан толгойн Дайчдын хөшөөнд байршуулсан 7 түргэн үйлчилгээний цэг.
- Наадамчдын зам, Нисэхийн зам дагуу 8 ТҮЦ;



Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны “Ил задгай, гар дээрх худалдаа үйлчилгээнд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” удирдамжаар Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэс, дүүргийн Мал эмнэлгийн тасаг, хороодтой хамтарсан ажлын хэсэг 14 удаагийн хяналт шалгалт хийж, зөрчлийг тухай бүр арилган, 10 иргэнд тус бүр 20 нэгжийн торгуулийн арга хэмжээ авч, хүнсний аюулгүй байдлыг хангуулан, зөвлөн тусалж ажилласан.



Явуулын үйлчилгээтэй хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд стандарт шаардлагыг мөрдүүлэх, дэмжин ажиллах чиглэлээр:

- Дүүргийн нутаг дэвсгэрт Зайсан туул гол дагуу явуулын үйлчилгээтэй түргэн хоолны үйлчилгээ эрхлэгчдэд эрүүл ахуйн стандартын дагуу хяналт шалгалт хийж, Богдхан уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран газар чөлөөлөх албан мэдэгдэл хүргүүлсэн.

- Дүүргийн Засаг даргын 2024 оны “Газрын зөрчил арилгаж, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах тухай” А/202 дугаар захирамжаар эрүүл ахуйн стандарт шаардлага хангахгүй, зориулалтын бус зөөврийн байгууламжид түргэн хоолны үйлчилгээ явуулж буй нийт 15 түргэн хоолны цэгийг нүүлгэн шилжүүлсэн.



Аялал жуулчлалын чиглэлээр: Нийслэлийн аялал жуулчлалын газраас аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад, дотоодын жуулчдад таниулах зорилгоор зохион байгуулсан 4 удаагийн олон нийтийн арга хэмжээнд дүүргийн нутаг дэвсгэрт зочлох үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагыг хамруулж бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан, хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан. Үүнд:

- “Бүргэдийн баяр” арга хэмжээ
- “Тэнгэр” олон улсын бөө мөргөлийн фестиваль
- “Улаанбаатар марафон” арга хэмжээ
- “Улаанбаатар Травэл Экспо- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн.



Дотоод, гадаадын жуулчдад салбарын мэдээллийг онлайнаар хүргэх зорилгоор Нийслэлийн Аялал жуулчлалын газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа зочид буудал, дэн буудлын цахим мэдээллийн санг үүсгэж зорилгоор судалгаа мэдээллийг шинэчилсэн боловсруулсан.

Мөн худалдаа үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системд 2024 оны эхний хагас жилийн байдлаар зочлох үйлчилгээний салбарын 12 хүсэлт бүртгэгдсэн.

Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх зорилгоор 2 байршилд гэрлэн чимэглэл бүхий талбай тохижуулж, Богд хааны ордон музейн цэцэрлэгт хүрээлэнд “Christmas market” худалдаа үйлчилгээг зохион байгуулж худалдаа, хоол үйлдвэрлэл, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 20 иргэн, аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан, борлуулалтыг дэмжин ажилласан.

Мөн “Улаанбаатар винтер” фестивальд зочлох үйлчилгээний салбарын 5 аж ахуйн нэгжийг хамруулсан.

Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр:

Дүүргийн газар тариалангийн салбарт кластерын жишиг загварыг бий болгон, хүлэмжийн ногоо тариалах, боловсруулах технологи, стандартыг нэвтрүүлж, “Хан-Уулд тариалав” брэнд бий болгох зорилтын хүрээнд дүүргийн Засаг даргын 2024 оны “Баялаг бүтээгч өрхийг дэмжих тухай” А/233 дугаар захирамжийг баталж, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, баялаг бүтээгч өрхийг дэмжих ажлыг 2 үе шаттай зохион байгуулсан.

Баялаг бүтээгч өрхийг дэмжих ажлын хүрээнд Япон улсын хөдөө аж ахуйн зөвлөх Ёкозүми Ёшиюкитэй хамтран дүүргийн 8, 9, 12, 14-р хорооны 150 гаруй өрхийн тариалан эрхлэгч нарт Япон улсын өндөр сортын 7 төрлийн хүнсний ногооны үр үрсэлгээ, хөрс сайжруулагч бордоо, гарын авлагаар ханган сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Намрын ургац хураалтаар 150 орчим тонн хүнсний ногоо хураан авч өрхийн хэрэгцээгээ хангасан. Хаврын тариалалтад зориулж хөнгөлөлттэй үнээр дүүрэгт хуваарилагдсан 10 нэр төрлийн 142 уут, 825.5 кг хүнсний ногооны үрийг 13, 14 дүгээр хорооны 366 өрхөд үнэ төлбөргүй олгож, тариалалтыг дэмжин ажилласан.



Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам”-ын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр:



“Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүртгэл мэдээллийн plant.mofa.gov.mn цахим систем”-д 344.5га тариалангийн талбай бүхий 215 тариаланчийг тулган баталгаажуулсан.

Гарал үүслийн гэрчилгээ олгох шаардлагатай 24 газар тариалан эрхлэгчийн 25 нэр төрлийн төмс, хүнсний ногооноос дээж авч, ургамлын өвчин хортон, хог ургамал, пестицид, нитратын үлдэгдэл тодорхойлуулахаар итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн 111.8тн хүнсний ногоонд цахим гарал үүслийн гэрчилгээ олгосон.

Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих чиглэлээр:

Улсын аварга фермер”-ийн болзлыг хангасан 12 дугаар хорооны иргэн Н.Баттөмөр, “Нийслэлийн аварга фермер”-ийн болзлыг хангасан С.Эрхэмжаргал, 14 дүгээр хорооны иргэн З.Зоригт нарыг ХХААХҮЯ, НХХААГ дэмжин тодорхойлж, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, ажлын дадлага туршлага, шинэ санаачилга, бүтээлч ажлын үр дүнгээрээ улс, нийслэлд тус



тус шалгарсан.

“Глобал Сивик Шэйринг” ТББ-тай хамтран эрчимжсэн мал аж ахуй, эрхлэгчдийг дэмжиж малын үүлдвэрлэг байдал, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх “Хүртээмжтэй мал аж ахуй” төслийн хүрээнд “Мал аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулах” 5 өдрийн вакуумжуулсан сургалтыг зохион байгуулж, 15 фермер эрхлэгчийг хамруулсан.

Хан-Уул дүүрэгт мал аж ахуй, газар тариалан эрхэлж буй буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа бодлого шийдвэр, зээл, төсөл хөтөлбөрийг танилцуулах, малчин тариаланчдыг дэмжих, хамтын ажиллагааг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг сонсох, санал солилцох уулзалтыг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулж, 12,13,14 дүгээр хорооны 91 малчин мал бүхий иргэд, төмс, хүнсний ногоо болон хүлэмжийн аж ахуй эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүд оролцсон.





Сүүний үхрийн үүлдэрлэг байдлыг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, үржлийн бух, гойд ашиг шимт үнээнд үзлэг, ангилалт, баталгаажуулалт, ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийн ажлын хүрээнд үржлийн бух, саалийн үнээтэй айл өрхийн судалгааг нарийвчлан гарган мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна.

Дархан-Уул аймагт зохион байгуулсан "Шилмэл мал-2024" үзэсгэлэн худалдаанд 12 дугаар хорооны Улсын тэргүүний фермер Н.Баттөмөр мах, сүүний чиглэлээр Шведийн бор бух, сүүний чиглэлээр Симменталь үнээ төрлөөр оролцож, “Мах сүүний чиглэлийн бух дэд байр”, “Сүүний үнээний үүлдэрлэг байдал дэд байр”-аар тус тус шалгарч, ажилттай оролцсон.



“Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох тухай” Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор батлагдсан журмыг танилцуулах сургалтыг мал бүхий 12,13,14 дүгээр хороо болон мал эмнэлэг үйлчилгээний 23 нэгжийн хамт зохион байгуулж 50 сүү бэлтгэн нийлүүлэгч иргэд, фермер эрхлэгч оролцсон.



Ахуйн үйлчилгээний цэг салбарын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, ажилтан албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр:

“Олон улсын мэргэжлийн гоо сайхны ур чадварын аварга шалгаруулах” тэмцээнийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Монголын үсчин гоо, засалчдын холбоотой хамтран зохион байгуулж, дүүргийн 26 үсчин, гоо засалчдыг хамруулж, туршлага судлуулсан.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны А/180 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт хими цэвэрлэгээ, угаалга, нийтийн халуун усны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 31 газарт Нийслэлийн Байгаль орчны газар, дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран хяналт шалгалт зохион байгуулж, 27 зөрчил илрүүлж, гадна орчны тохижилт сайжруулах чиглэлээр дүүргийн Менежерийн 02/2002 дугаартай зөвлөмжийг 31, мэдэгдэл 7 иргэн, аж ахуйн нэгжид тус тус хүргэж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.



Авто үйлчилгээний чиглэлээр:

Авто үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг сурталчлах, мэдээллээр хангах зорилгоор 38 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, гарын авлага боловсруулан, 182 иргэн, аж ахуйн нэгжид тарааж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан.


- Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газраас зохион байгуулсан “Авто үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага MNS5025:2020 стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага”-ын талаарх хэлэлцүүлэгт 4 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулж, санал хүргүүлсэн.

Дүүргийн Засаг даргын 2024 оны “Авто үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд хамтарсан хяналт, шалгалт зохион байгуулах тухай” А/671 дүгээр захирамжийн хүрээнд 144 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгуулж ажилласан. Үүнд:

- 7 иргэн, аж ахуйн нэгжид 4.9 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ;
- 33 иргэн, аж ахуйн нэгжид улсын байцаагчийн албан шаардлага;
- 78 иргэн, аж ахуйн нэгжид зөвлөмж;

32 иргэн, аж ахуйн нэгжид хугацаатай албан мэдэгдэл хүргүүлж, газар дээр нь 8 зөрчлийг арилгуулж, хяналт тавьж ажилласан.

Дүүргийн хэмжээнд нийт 42 авто угаалга үйл ажиллагаа явуулж байгаагаас 12 иргэн, аж ахуйн нэгж саарал усны тоног төхөөрөмжийг суурилуулж үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд өмнөх оны тоотой харьцуулахад 21.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Батлах хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд:

Оюутан-цэрэг сургалт

Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/376 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2024 оны А/126 дугаар захирамжийн дагуу “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутны бүртгэлийг 2024 оны 03 дугаар сарын 01-14-ний өдрүүдэд үндэсний портал сайт “E-Mongolia”-аар бүртгэлийг хүлээн авч, дүүргийн хэмжээнд 5 их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн шаардлага хангасан 108 оюутан, суралцагчид бүртгэж, эрүүл мэндийн үзлэг болон бие бялдрын шалгалтад тэнцсэн 74 оюутныг Үндэсний батлан хамгаалах их сургуульд хүлээлгэн өгсөн.

Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаагаа явуулдаг 5 их, дээд сургууль, 2 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 108 оюутан, суралцагчид “Оюутан-цэрэг” цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан нь 2023 онтой харьцуулахад 34 оюутнаар багассан үзүүлэлттэй байна.



Дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтыг зохион байгуулсан талаар:

ЗХЖШ-ын даргын 2024 оны н/25 дугаар тушаал, нийслэлийн Засаг даргын 2024 оны н/01 дүгээр захирамж, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчийн 2024 оны мн/23 дугаар тушаалыг тус тус үндэслэн цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг Зэвсэгт хүчний 303 дугаар ангид 04 дүгээр сарын 08-12-ны өдрүүдэд, Зэвсэгт хүчний 065 дугаар анги дээр 05 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд, Зэвсэгт хүчний 310, 314 дүгээр анги дээр 05 дугаар сарын 13-17-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан.

Зэвсэгт хүчний 303 дугаар ангид 10, Зэвсэгт хүчний 065 дугаар ангид 7, Зэвсэгт хүчний 310 дугаар ангид 8, Зэвсэгт хүчний 314 дүгээр ангид 10 бэлтгэл үүрэгтний судалгааг тус тус гаргаж, сургалтын гэрээ байгуулан тухайн ангид нарядын дагуу бүрэн хүлээлгэн өгсөн.

Сургалтын төгсгөлд сургалтын дүн гаргаж, цэргийн бэлтгэл үүрэгтний давтан сургалтад амжилттай суралцсан бүрэлдэхүүнд мэргэжил олгох сургалтад суралцсан тухай батламж, дүүргийн Засаг даргын талархал гардуулсан.

*Хүүхэд залуучуудад эх оронч үзэл санааг төлөвшүүлж, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх:*

Дүүргийн Засаг даргын 2024 оны А/95 дугаар захирамжаар “Иргэн-цэргийн харилцааны өдөрлөг зохион байгуулах тухай” захирамжийг батлуулж, төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:

- Хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгын хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн үйл ажиллагаатай танилцуулах арга хэмжээг Цэргийн штаб, Боловсролын хэлтэстэй хамтран 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн байрлалд зохион байгуулсан.

Тус арга хэмжээнд дүүргийн Ерөнхий боловсролын 60 дугаар сургуулийн ахлах 12 дугаар ангийн 3 бүлгийн 60 гаруй сурагч, 2 багш оролцож, хөтөлбөрийн дагуу ангийн байрлалтай танилцуулж, зэвсэглэл, техник, гардан тулааны үзүүлэх тоглолтыг үзүүлж, сонирхуулсан.



“Бид эх орны ирээдүй” хөтөлбөрийг хэрэгжүүлж дүүргийн Ерөнхий боловсролын 7, 52 дугаар сургуулиудад “Цэрэг, эх орны булан”, 41 дүгээр сургуульд “Иргэн цэргийн харилцааны танхим”-ыг тус тус байгуулсан.



- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын ахлах болон дунд ангийн сурагчдын дунд “Монгол цэрэг” сэдэвт зохион бичлэг, гар зургийн уралдааныг 03 дугаар сарын 01-12-ны өдрүүдэд зохион байгуулж, төрийн өмчит болон хувийн хэвшлийн 14 сургуулиас нийт 70 гаруй бүтээлийг ирүүлсэн. Зохион бичлэг, гар зургийн уралдаанд сурагчдын ирүүлсэн бүтээлүүдийг шалгаруулж, шилдгээр шалгарсан сурагчдад шагнал гардуулсан.



Гар зургийн уралдааны тэргүүн байрт 15 дугаар сургуулийн 8ё ангийн сурагч Ц.Саранзул, дэд байрт 15 дугаар сургуулийн 8б ангийн сурагч Б.Чандмань-Эрдэнэ, гутгаар байрт 7 дугаар сургуулийн 9ё ангийн сурагч Б.Анунгоо нар тус тус шалгарсан.

“Монгол цэрэг” сэдэвт зохион бичлэгийн уралдааны тэргүүн байрт 15 дугаар сургуулийн 10а ангийн сурагч О.Содтөгөлдөр, дэд байрт “Аварга” сургуулийн 11а ангийн сурагч Г.Ананд, гутгаар байрт 26 дугаар сургуулийн 11а ангийн сурагч О.Мягмарсүрэн нар тус тус шалгарсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын баталсан “Нийслэлийн Ерөнхий боловсролын 12 дугаар ангийн сурагчидтай явуулах хичээлийн агуулга, дараалал”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар “Бид эх орны ирээдүй” хөтөлбөрийн хүрээнд хичээл заах багш, офицер, ахлагч нарын хуваарийг батлуулж, дүүргийн хэмжээнд нийт 22 сургуулийн 58 бүлгийн 1830 сурагчдад “Эх оронч төлөвшил ба үндэсний бахархал” сургалтыг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс 03 дугаар сарын 19-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Ерөнхий боловсролын сургуулиуд, сурагчдын төлөөлөлд “Цэргийн цолны дараалал” бүхий самбарыг дурсгал болгож гардуулсан.



Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103 жилийн ойн төлөвлөгөөт ажлын хүрээнд 03 дугаар сарын 16-ны өдөр “Хүннү Молл” их дэлгүүрийн В1 давхарт “Иргэн-цэргийн харилцааны өдөрлөг” зохион байгуулсан. Өдөрлөгийн үйл ажиллагаанд Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Хүндэт харуулын салааны үзүүлэх тоглолт, Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын уран бүтээлчид, Үлгэр жишээ, үлээвэр найрал хөгжмийн тоглолт, Монгол цэргийн музейн явуулын үзэсгэлэн дэлгэгдэж, “Монгол цэрэг” сэдэвт гар зураг, зохион бичлэгийн уралдаанд тэргүүлсэн сурагчдад шагнал, 18 нас хүрсэн цэргийн 10 үүрэгтэд цэргийн үнэмлэх, 03 дугаар сарын 18-ны өдөр төрсөн өдөр нь тохиож буй дүүргийн 8 дугаар хорооны иргэн М.Мөнх-Оргилд дурсгалын зүйл гардуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан.

Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчин, Цэргийн штабын үйл ажиллагааг сурталчлах өдөрлөгт 500 гаруй иргэд, хүүхэд залуучууд оролцсон.



Дүүргийн Засаг даргын 2024 оны А/111 дүгээр захирамжийн хэрэгжилтийг ханган дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын цогцолбор “Дөл” тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Зэвсэгт хүчний 326 дугаар материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан.

Тэмцээнд дүүргийн 7 дугаар сургуулийн “Хурд”, 10 дугаар сургуулийн “Аравт”, 15 дугаар сургуулийн “Зэв”, 18 дугаар сургуулийн “Соёмбо”, 26 дугаар сургуулийн “Соёмбо”, 32 дугаар сургуулийн “Офицерууд”, 34 дүгээр сургуулийн “Хан Гарьд”, 52 дугаар сургуулийн “Хар ирвэс”, 59 дүгээр сургуулийн “Хангарьд”, 60 дугаар сургуулийн “Цэгц”, 75 дугаар сургуулийн “Шонхорууд”, 114 дүгээр сургуулийн “Шонхор”, 115 сургуулийн “Сонор”, 118 дугаар сургуулийн “Сүлд”, 163 дугаар сургуулийн “Шонхор” зэрэг багууд, нийт 15 сургуулийн 201 сурагчид тэмцээнд оролцсон.

Дөл тэмцээнийг 9 үзүүлэлтээр зохион байгуулж, их онооны системээр дүгнэн Ерөнхий боловсролын 118 дугаар сургуулийн “Сүлд” баг “Тэргүүн байр, 114 дүгээр сургуулийн “Шонхор” баг “Дэд байр”, 7 дугаар сургуулийн “Хурд” баг “Гутгаар байр”, 26 дугаар сургуулийн “Соёмбо” баг “Тусгай байр” тус тус эзэлсэн.

Цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээний шилдгээр шалгарсан тасгуудад шагналыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга С.Энхбаяр, Цэргийн штабын дарга, дэд хурандаа Д.Баасанхүү, Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн захирагч, дэд хурандаа Ү.Уянгасайхан нар гардуулсан.



Нийслэлийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/168 дугаар захирамжийн дагуу нийслэлийн Засаг даргын нэрэмжит цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээнд дүүргийн аваргаар шалгарсан Ерөнхий боловсролын 118 дугаар сургуулийн “Сүлд” тасаг, тасгийн бүрэлдэхүүнийг хүчжүүлж Ерөнхий боловсролын 7, 60 дугаар сургуулиудын ахлах ангийн 3 сурагчдыг оролцуулж, нийт 15 сурагчдыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын төлөвлөлт, сургалтын офицер, хошууч М.Хишгээ хариуцан 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 18-ны өдрийг дуустал Зэвсэгт хүчний 326 дугаар ангид байрлуулан бэлтгэл сургуулилтыг хангуулан 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний Батлан хамгаалахын их сургууль дээр зохион байгуулагдсан тэмцээнд оролцуулсан.

Нийслэлийн аварга шалгаруулах “Дөл” тэмцээнд Хан-Уул дүүргийн “Сүлд” тасаг “Тэргүүн байр” эзэлсэн.

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103 жилийн ойг тохиолдуулан 16 ажил төлөвлөснөөс 15 ажил биелэгдэж, төлөвлөгөө 94 хувьтай хэрэгжсэн.

Үр дүн: Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103 жилийн ойн үйл ажиллагаанд Зэвсэгт хүчний анги, төрийн цэргийн байгууллага-7, ерөнхий боловсролын сургууль-24, хувийн хэвшлийн-1 нийт 32 байгууллагатай хамтран ажиллаж, ерөнхий боловсролын сургуулийн багш-26, 2000 гаруй сурагч, 500 гаруй иргэн, нийт 2500 гаруй иргэдийг оролцуулж үйл ажиллагааг зохион



байгуулсан.



2.2 Төсвийн орлогын төлөвлөгөө болон нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, нийслэлийн төсвөөс дүүргийн төсөвт олгож буй санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт;

“Улс, нийслэл, орон нутгийн 2024 оны төсвийн орлогын бүрдүүлэлтийг хангах зарим арга хэмжээний тухай” дүүргийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/29 дүгээр захирамжийг боловсруулан батлуулж, орлого бүрдүүлэгч, хэлтэс албадтай хамтран, орон нутгийн төсвийн орлогын биелэлтийг Татварын хэлтэстэй сар бүр тулган баталгаажуулсан.

Орон нутгийн төсөвт 2024 оны 5 дугаар сарын байдлаар орлого 207,633.5 сая төгрөг орох төлөвлөгөөтэйгөөс 172,107.1 сая төгрөг бүрдэж, өссөн дүнгээр 82.9 хувийн биелэлттэй байна.



Дүүргийн 2024 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг нийт 13-н дансны 1-05 дугаар сарын орлого болон зарлагын гүйлгээгээр тулган хянаж, Татварын хэлтсийн орлогын эдийн засагчтай тооцоо нийлэн дүүргийн Нэгдсэн Санхүүгийн тайланд амжилттай нэгтгэгдлээ.

Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавин, “Улс, нийслэл, орон нутгийн 2024 оны төсвийн орлогын бүрдүүлэлтийг хангах зарим арга хэмжээний тухай” дүүргийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/29 дүгээр захирамжийн төслийг боловсруулан батлуулж, холбогдох хэлтсүүдэд хүргүүлэн хамтран ажилласан.

Нийслэлд төвлөрүүлэх орлогын талаар:

Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хянаж холбогдох залруулах бичилтийг хийн баталгаажуулсан. Дүүргийн ерөнхий орлогын дансанд татварын нэр төрлөөр 172,770.7 сая төгрөгийг, нийслэлд 134,311.3 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлэв.

Улсын Тэмдэгтийн хураамж буцаан олгох талаар:

Орон нутгийн төсвийн орлогын биелэлтийг сар бүр Татварын хэлтсийн орлогын эдийн засагчтай замд яваа татварын орлого болон татварын нэр төрлийн буцаасан гүйлгээг тулган баталгаажуулж, тооцоо нийлэн сарын биелэлтийг дүгнэн ажилласан.

Төсвийн “тэг” үлдэгдэлтэй данснаас 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 544 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын татварын нэр төрлийн орлогын буцаах болон залруулах гүйлгээнд 994.8 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.

Татварын хэлтсээс ирүүлсэн албан бичиг, жагсаалтыг улсын тэмдэгтийн хураамжийн 100200100941 тоот дансны хуулга, шүүхийн захирамж, иргэн, аж ахуйн нэгжийн өргөдөл, иргэний үнэмлэх, гэрчилгээний хуулбар, мөнгө тушаасан баримт, татварын тодорхойлолт

зэргийг нарийвчлан тулгаж, төлбөрийн хүсэлт бичиж ерөнхий нягтлан бодогч, хэлтсийн даргаар батлуулан орлого бууруулах гүйлгээ хийв.

2.3 Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн санал, зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал;

Төсвийн тухай хуулийн 54.2-т “ТЭЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, төсөл, сан, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн тайланд хамруулна” гэж заасны дагуу Засгийн Газрын санхүүгийн нэгтгэлийн Э-ТАЙЛАН системд дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамрагддаг төсөвт 87 байгууллагын 2023 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилт, касс харилцахын нэгтгэл, нэмэлт санхүүжилтийн тооцоог тулган Сангийн Яамны нэгтгэлийн Э-тайланд байгууллага бүрээр тулган шалгаж хүлээн авч дүүргийн нэгдсэн тайланг Нийслэл дэх төрийн Аудитын газраар шалгуулж стандарт дүгнэгдэв.

2023 оны жилийн эцсийн аудитын дүгнэлтээр Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар стандарт үнэлгээ авч аудитын дүгнэлтээр нийт 8 зөвлөмжийн алдааг залруулан хэрэгжилтийн тайланг Нийслэл дэх төрийн аудитын газар хүргүүлсэн.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд хяналт тавих ажлын хүрээнд:

Дүүргийн Засаг даргын 2023 оны А/151 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүрэгт түгээмэл тархалттай ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг 7 аж ахуйн нэгжийн 41, Төв аймгийн Алтанбулаг суманд үйл ажиллагаа эрхэлдэг 7 аж ахуйн нэгжийн 102, нийт 14 аж ахуйн нэгжийн 143 тээврийн хэрэгсэлтэй “Тээвэрлэлтийн хариуцлагын гэрээ”-г хийж, хяналт тавин ажиллаж байна.

Зураг. Тээвэрлэлтийн хяналт шалгалтын ажлын явц



Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлогч аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтарч 2024 онд уул уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн

13 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 6 га-д биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Нөхөн сэргээлтийн ажил 2024 оны 10 дугаар сарын 01-нээс 11 дүгээр сарын 15-ны хооронд хэрэгжинэ.

2.4 Төрийн захиргааны албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн байдал;

Засаг даргын Тамгын газрын даргын “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг байгуулах тухай” 2024 оны А/118 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний баг Засгийн газрын 2023 оны 301, 442 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулан албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, урамшуулал олгох ажлыг зохион байгуулсан.

Үнэлгээнд Засаг даргын Тамгын газрын удирдах 9, гүйцэтгэх төрийн захиргааны 40, төрийн тусгай 6, төрийн үйлчилгээний 27, хорооны 59, нийт 141 албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг 2024 оны жилийн эцсийн байдлаар үнэлж, үнэлгээгээр “Маш сайн” үнэлэгдсэн 133, “хэвийн” үнэлэгдсэн 8 албан хаагчид тус тус журмын дагуу Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны Б/218 дугаартай тушаалаар урамшуулал олгосон.

2.5 Үндсэн чиг үүргийн биелэлт, үрд дүнд дотоод аудит, хяналт эсвэл шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх, уг ажлын дүгнэлтийг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлсэн байдал;

Дүүргийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, хэрэгжиж буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэл, дүүрэгт 2024 оны эхний улиралд бүртгэгдсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж 2 зөвлөмж гарган Засаг даргын Тамгын газрын 2024 оны 03/214 тоот албан бичгээр 28 байгууллагад хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллаж байна.


Дүүргийн Засаг даргын хариуцлагын гэрээний 2 бүлэг 10 зорилт, 92 арга хэмжээ эхний хагас жилийн байдлаар 58%, эрчимжүүлэх шаардлагатай байсан. Тайланг 2024 оны 06 дугаар сарын 18-ны 03/1265 тоот албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, тайлагнасан. Хэрэгжилт хангалтгүй 20 арга хэмжээг эрчимжүүлэх тухай хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмжийг Засаг даргын Тамгын газрын болон харьяа хэлтсүүдэд 03/1661 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Жилийн эцсийн биелэлтийг нэгтгэхэд 92%-тай хэрэгжиж тодорхой үр дүнд хүрсэн байна.

№	Зорилт, арга хэмжээ	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй 100	Тодорхой үр дүнд хүрсэн хүрсэн 70-100	Эрчимжүүлэх шаардлагатай 30-70	Үр дүнгүй 0-30	Үнэлэх боломжгүй	Үнэлгээ /хувь/
	Бүлэг								
1	Дүүргийн Засаг даргын эрх, үүрэг	9	87	41	36	6	2	2	88%
2	Нийслэлийн Засаг даргын дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт	1	5	3	2				96%
НИЙТ ДҮН		10	92	44	38	6	2	2	92%

Төрийн өмчит 37 цэцэрлэг, 24 сургуулиудын тогтмол зардал, урсгал засварын зардал, 17 орон нутгийн байгууллагуудад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд сар бүр хяналт тавин, шинэчлэгдэн гарч буй Засгийн газрын тогтоол, шийдвэрүүдийг тухай бүр танилцуулан, холбогдох заавар зөвлөгөөг өгч 3 удаагийн сургалтыг зохион байгуулан ажилласан.

2.6 Архив, албан хэрэг хөтлөлт, шийдвэрлэлтийн байдал


Хан-Уул дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудад 2023 онд 41360 албан бичиг ирж шийдвэрлэлтийн хувь 95.1%, шийдвэрлэлтийн дундаж хоног 6.3 байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 43826 албан бичиг цаасан болон цахим суурьтай ирж шийдвэрлэлтийн хувь 98.26%, шийдвэрлэлтийн дундаж хоног 4.26 байна. Энэ нь ирсэн албан



бичиг 2466 буюу 5.9%, шийдвэрлэлтийн хувь 3.6%-иар тус тус өссөн, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2.7 хоногоор багассан үр дүн гарсан.

Албан бичиг шийдвэрлэлтийн явцад гарсан зөрчлийн тоо 2023 онд 1009 байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 966 буюу 10%-иар буурсан байна.

Дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2023 онд 6197 албан бичиг ирж, шийдвэрлэлтийн хувь 95.56%, шийдвэрлэлтийн дундаж хоног 6.3 байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 7442 албан бичиг цахим болон цаасан хэлбэрээр ирж шийдвэрлэлтийн хувь 99.05%, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4.26 хоногийн үзүүлэлттэй байна. Энэ нь ирсэн албан бичиг 1285 буюу 20%, шийдвэрлэлтийн хувь 3.49%-иар өссөн, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2.04 хоногоор багассан үр дүн гарсан.



Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс алба, төрийн өмчийн сургууль, цэрцэрлэгээс боловсруулан явуулсан бичгийн мэдээ:

Хан-Уул дүүргийн төрийн байгууллагуудаас 2023 онд 22789 албан бичиг явуулж байсан бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар 23761 албан бичгийг боловсруулан явуулсан нь 972 буюу 30%-иар өссөн байна. Засаг даргын Тамгын газраас төлөвлөн явуулсан

албан бичиг 2023 онд 2230 байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 2374 буюу 21%-иар өссөн.

Архивын чиглэлээр:

Засаг даргын Тамгын газрын албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулах, зохион байгуулалтын нэгж, нөхөн бүрдүүлэлтийн бусад эх үүсвэрээс баримтыг хүлээн авах, хадгалах, ашиглуулах мөн Нийслэлийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/915 дугаар “Дүрэм батлах тухай” захирамжаар төрөөс архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр гаргасан хууль тогтоомж, шийдвэрийг Дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, төрийн өмчийн болон өмчит байгууллагуудын архивын баримтаар сан хөмрөгөө нөхөн баяжуулж, тэдгээрийг найдвартай хадгалж хамгаалах, байгууллага, иргэдэд үйлчлэх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Хөмрөг үүсгэгч байгууллагын захирамжлалын баримт бичгийн цахим нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах ажлын хүрээнд дүүргийн харьяа байгууллагуудын цахим нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Хууль эрх зүй, Архивын хэлтсийн даргаар батлуулсан.

Төлөвлөгөөний дагуу харьяа **105** байгууллагын 2023 онд үүссэн захирамжлалын баримтыг төрийн архивын нэгдсэн системд **204** хадгаламжийн нэгжийн **12806** баримтын **19936** хуудсыг цахимжуулсаныг батлан шалгасан. Захирамжлалын баримтын цахим нөхөн бүрдүүлэлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж Нийслэлийн Архивын газарт тайлагнаж ажилласан. Үүнд:

- Дүүргийн Засаг даргын дэргэдэх алба хэлтэс -25
- Хороо -25
- Сургууль -23
- Цэцэрлэг -37

Төрийн архивт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус нөхөн бүрдүүлэлт хийх хөмрөг үүсгэгч байгууллагын нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны хүрээнд дүүргийн архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын **5** удаагийн хурал хуралдаж 2024 оны нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөт **32** байгууллагын байнга хадгалах данс бүртгэлийг баталж, батлагдсан данс бүртгэлийн дагуу байнга хадгалах **2499** баримтыг төрийн архивт хүлээн авч бүртгэлжүүлсэн.



“Архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журам”-ын дагуу дүүргийн архивт хөмрөг үүсгэгч 114 байгууллагын 2024 оны архивын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалт, хамгаалалтын мэдээллээр /burtgel.archives.gov.mn/ улсын нэгдсэн санг баяжуулж Нийслэлийн Архивын газарт нэгдсэн тайлан мэдээг хүргүүлсэн.

Нийслэлийн Архивын газрын Мэргэжил арга зүйн зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 03 дугаар хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын байнга хадгалах 2009-2020 оны 648 хадгаламжийн нэгж, 2013-2020 оны 70 жил хадгалах 94 хадгаламжийн нэгж, 2008-2020 оны түр хадгалах 3028 хадгаламжийн нэгж, 1999-

2021 оны устгах баримтын 38 хэргийн 1806 хадгаламжийн нэгжийн данс бүртгэлийг нягтлан шалгаж үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

- Тендерийн худалдан авах ажиллагааны 2003-2020 он хүртэлх хугацааны гэрээний дугаарыг нөхөж, бүртгэлийг засварласан.
- Байгууллагын архивт хадгалагдаж буй 2009-2020 оны баримтад иж бүрэн нягтлан шалгалт, техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.



Улсын Их хурлын ээлжит сонгуулийн 74 хэсгийн хорооны үйл ажиллагааны явцад үүссэн цаасан суурьт байнга хадгалах 202, түр хадгалах 192, нийт 394 хадгаламжийн нэгж, Хан-Уул дүүргийн орон нутгийн сонгуулийн 74 хэсгийн хорооны үйл ажиллагааны явцад үүссэн цаасан суурьт байнга хадгалах 154, түр хадгалах 252, нийт 406 хадгаламжийн нэгжийг хүлээн авч бүртгэлжүүлэн Нийслэлийн архивын газарт заавар журмын дагуу хүлээлгэн өгсөн.

Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын үйл ажиллагаа:

Дүүргийн архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд тусгасны дагуу 32 байгууллагын нөхөн баяжилт хийхээс жилийн эцсийн байдлаар **32** байгууллагын данс бүртгэлийг Дүүргийн архивын дэргэдэх БНШАЗК-ын 5 удаагийн хурлаар хэлэлцүүлэн баталж, байнга хадгалах баримтыг төрийн архивт хүлээн авахаар шийдвэрлэсэн.



Мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө, сургалтын чиглэлээр:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар түүний эрхлэх асуудлын хүрээний албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн “EDOC” систем ашиглагч 127 байгууллагад хяналт тавьж, зөвлөгөө өгч ажилласан.

Төрийн архивт хөмрөг үүсгэгч байгууллагууд болон Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах ажлын хүрээнд архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр сургалтын төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Архивын хэлтсийн даргаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу:

- Төрийн архивт хөмрөг үүсгэгч байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангах ажлын хүрээнд “Архивын баримт бүрдүүлэх, данс бүртгэл үйлдэх” сэдэвт сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Хан-Уул дүүргийн Соёлын ордонд,

- “Архивын нөхөн баяжилт” сэдэвт сургалтыг 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр дүүргийн иргэдэд үйлчлэх төв байрны 7 давхрын Б зааланд,
- Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт батлуулах тухай сургалтыг дүүргийн сургууль, цэцэрлэгүүдийн архивын ажилтнуудад 2024 оны 05 дугаар сарын 6-ны өдөр дүүргийн иргэдэд үйлчлэх төв байрны 7 давхрын Б зааланд,
- “Архивын нөхөн баяжилтын арга зүй” сэдэвт сургалтын 2024 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр дүүргийн иргэдэд үйлчлэх төв байрны 7 давхрын хурлын Б зааланд,
- “Архивын нөхөн баяжилтын арга зүй” сэдэвт сургалтын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр дүүргийн иргэдэд үйлчлэх төв байрны 7 давхрын хурлын Б зааланд тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор **153** албан хаагч хамрагдсан.



Дүүргийн архивын хадгаламжийн сангуудад шаардлагатай 16,020,000 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг 2024 оны эхний хагас жилд худалдан авч баримтын хадгалах нөхцөлийг сайжруулсан.


Архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилтын хүрээнд байгууллагын архив болон төрийн архивын хадгаламжийн сангуудад ариутгал халдваргүйтгэлийн ажлыг жилд 3-4 удаагийн давтамжтай хийж баримтын хадгалах горимыг сайжруулсан.

Архивын Ерөнхий газрын даргын 2021 оны А/25 дугаар тушаалаар батлагдсан “Архивын баримтыг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах нийтлэг журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж, цаасан болон цахимаар ашиглуулсан баримтын нэр төрөл, нэгдсэн тоог бүртгэлжүүлж ажилласан. Төрийн архивын **25** хөмрөгийн баримтаас **35** иргэнд 1964-2018 оны **33** хадгаламжийн нэгжийн **113** хуудас лавлагаа хуулбарыг олгосон.

Малын “А” дансны **5** хөмрөгийн баримтаас **15** иргэнд 2008-2018 оны **136** хадгаламжийн нэгжийн **872** хуудас лавлагаа, хуулбарыг олгож байгууллага иргэдэд шаардлагатай үйлчилгээг үзүүлсэн.

Засаг даргын Тамгын газрын архивын үйл ажиллагаа:

Байгууллагын архивын сан хөмрөг үүсгэх, хадгалах хамгаалах чиг үүргийн хүрээнд “Захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх тухай” Нийслэлийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн А/452 дугаар захирамж, “Байгууллагын архивын үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага, хадгалалтын горимыг тогтоож мөрдүүлэх журам” батлах тухай Нийслэлийн Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/172 дугаар захирамж,



Нийслэлийн Засаг даргын А/177 дугаар захирамжаар батлагдсан “Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх журам”-ыг мөрдлөг болгон Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны явцад үүссэн 2023 оны 14 хадгаламжийн нэгжийн 1278 баримт бүхий 2718 хуудастай захирамжлалын баримтыг цахимжуулж, www.arch.ulaanbaatar.mn системд байршуулсан.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадад 2023 оны үйл ажиллагааны явцад үүссэн цаасан суурьт баримтаар байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийг 2024 оны 01 дүгээр сарын 02-ний өдөр Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан, хуваарийн дагуу хэлтэс, албадаас баримтыг архивт хүлээн авч баяжилт хийсэн. Үүнд:

- Байнга хадгалах 204 хадгаламжийн нэгж
- 70 жил хадгалах 6 хадгаламжийн нэгж
- Түр хадгалах 540 хадгаламжийн нэгж
- Байгууллага дээр байнга хадгалах 14 хадгаламжийн нэгж

нийт 764 хадгаламжийн нэгжийг архивт хүлээн авч, төрөлжүүлэн цэгцэлж, дугаарлалт хийн бүртгэл үүсгэсэн.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9 дэх заалтын дагуу “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 13.9.5-д “Төрийн Архивт баримт шилжүүлэхэд байнга, 70 жил, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, устгах баримтын жагсаалтыг Төрийн архивын дэргэдэх баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар хянуулж батлуулсан байна” гэж заасны дагуу Нийслэлийн архивын газрын дэргэдэх баримт нягтлан шалгах арга зүйн комиссын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр 02 дугаар хурлаар:

- Байнга хадгалах 2009-2020 оны 688 хадгаламжийн нэгж
- Захирамжлалын цахим 2013-2020 оны 8 DVD хадгаламжийн нэгж
- Түр хадгалах 2013-2020 оны 2985 хадгаламжийн нэгж
- Байгууллага дээр байнга 2012-2020 оны 114 хадгаламжийн нэгж
- 70 жил хадгалах 2013-2020 оны 94 хадгаламжийн нэгж
- Зураг төслийн 2014-2020 оны 79 хадгаламжийн нэгж
- Устгах хэргийн жагсаалт 1999-2021 оны 1806 хадгаламжийн нэгжийг тус тус хянуулан батлуулсан.

Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам” 2020 оны 246 дугаар тогтоолоор өөрчилсөн “Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн програм хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, Засаг даргын Тамгын газрын албан бичиг боловсруулалтын үйл ажиллагаанд Стандартчилал Хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн С/30 дугаар тушаалаар батлагдсан MNS 5140-2021 стандартыг мөрдөн ажилласан.

Байгууллагын албан бичигт стандарт хангуулах чиглэлээр:

Хан-Уул дүүргийн Засаг даргын А захирамжийн 2019, ЗДТГ-ын даргын тушаалын 1022, нийт 3041 захирамжлалын баримт бичгийг хэвлэмэл хуудаст буулгаж, захирамжлалын болон зохион байгуулалт, мэдээлэл, лавлагааны 3290 албан бичгийн боловсруулалтад Монгол Улсын MNS 5140:2021 стандартыг мөрдлөг болгон хяналт тавьсан.

2.7 Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал;

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэх зорилтын хүрээнд:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, албадад 2024 оны жилийн эцсийн байдлаар 6390 өргөдөл, гомдол ирснээс хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 6275, хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 22, судлагдаж байгаа 93 өргөдөл, гомдол байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 12 цаг 38 минут.


- Бичгээр – 2477

- 1800-1200 – 759
- 11-11 – 2900
- Хороо бүртгэсэн – 151
- Цахимаар – 36
- Дижитал сити – 67

Засаг даргын Тамгын газарт 1057 өргөдөл, гомдол ирснээс 1043 хугацаандаа шийдвэрлэгдэж, судлагдаж байгаа 14 өргөдөл, гомдол байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа: 8 хоног 9 цаг 36 минут.

- Цаасаар - 235
- 1800-1200 - 322
- 11-11- 451
- Дижитал сити - 35
- Цахимаар – 14


Иргэдийн гаргасан өргөдөл, гомдлыг төрлөөр ангилж үзвэл:



Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Хан-Уул дүүрэг	Нийт өргөдөл		Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Шийдвэрлэлтийн дундаж хоног		Зөрчлийн тоон үзүүлэлт	
	2023 XII	2024 XII	2023 XII	2024 XII	2023 XII	2024 XII	2023 XII	2024 XII	2023 XII	2024 XII
ИТХ	3	5	1	4	2	1	32х 23ц 16м	18х 03ц 29м	68	37
ЗДТГ	950	1057	940	1043	2		08х 05ц 23м	08х 09ц 36м	67	33
Харьяа хэлтэс, алба, тасаг	3521	3941	3461	3855	23	19	08х 08ц 07м	06х 18ц 43м	575	357
Дүүргийн өмчит үйлдвэрийн газрууд	72	121	69	119	1	1	08х 17ц 12м	09х 19ц 23м	50	54
Хороод	529	484	515	478	11	1	06х 15ц 41м	04х 05ц 39м	654	116
Эмнэлэг	670	780	662	774			02х 11ц 14м	03х 13ц 29м	125	52
Сургууль, цэцэрлэг	31	2	31	2			02х 05ц 57м	02х 00ц 21м	15	
Дүүргийн хэмжээнд /нийт/	5776	6390	5679	6275	39	22	07х 11ц 19м	06х 12ц 38м	1554	649

Хугацаа хэтэрсэн шийдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:



Шийдвэрлэх явцад гаргасан зөрчлийн төрөл, байгууллагаар:

Зөрчлийн төрөл	Зөрчлийн тоо	Байгууллагаар	Зөрчлийн тоо
Бусад зөрчил	0	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	37
Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил	147	Засаг даргын Тамгын газар	33
Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	137	Харьяа хэлтэс, алба, тасаг	357
Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил	341	Дүүргийн өмчит үйлдвэрийн газрууд	54
Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй зөрчил	18	Хороод	116
Хангалтгүй шийдвэрлэсэн	6	Эмнэлэг	52
НИЙТ	649	Сургууль, цэцэрлэг	0
		Дүүргийн хэмжээнд/нийт/	1649

Зөрчлийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал:



ХАМГИЙН ИХ ГОМДОЛ ИРСЭН ХЭЛТЭС

1. Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс - 130 буюу 51,5 %
2. Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс – 89 буюу 35,3%
3. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс – 18 буюу 7,4 %
4. Хууль, эрх зүйн хэлтэс-6 буюу 2,3 %

ГОМДЛЫН ТЭРГҮҮЛЭХ АГУУЛГА


1. Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааны тухай – 27 буюу 10,71%
2. Орон сууцны 1-р давхарт байрлах үйлчилгээний газруудын тухай – 24 буюу 9,52 %
3. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн болон ТҮЦ, павильон, ил задгай

худалдаа, үйлчилгээний тухай – 21 буюу
8,33 %

Хан-Уул дүүргийн 7777-1965 дугаарын утсанд 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 7749 дуудлага ирснээс:

- ✓ Засаг даргын Тамгын газарт-5385
- ✓ Татварын хэлтэс-711
- ✓ Улсын бүртгэлийн хэлтэс-731
- ✓ Газар зохион байгуулалтын алба-352
- ✓ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс-325
- ✓ Нийгмийн даатгалын хэлтэс-113
- ✓ Онцгой байдлын хэлтэс-54
- ✓ Бусад хэлтэс албад-78 удаа хандсан.

Иргэдээс ирсэн дуудлага:



Засаг даргын Тамгын газарт ирсэн дуудлагын хэлтэс, албадад хандсан байдал:

- ✓ Засаг даргын Тамгын газарт-9895
- ✓ Татварын хэлтэс-1510
- ✓ Улсын бүртгэлийн хэлтэс-1263
- ✓ Газар зохион байгуулалтын алба-1152
- ✓ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс-925
- ✓ Нийгмийн даатгалын хэлтэс-813
- ✓ Боловсролын хэлтэс-289
- ✓ Онцгой байдлын хэлтэс-154
- ✓ Бусад хэлтэс албад-509
- ✓ Хороодод-264 удаа хандсан.

Ирсэн дуудлагыг агуулгаар авч үзвэл:

Санхүүгийн тайлантай холбоотой асуудлаар-4365

Татварын тайлантай холбоотой асуудлаар- 1510

Улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой асуудлаар-1263

Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар-2068

Засаг даргатай уулзалт хийх тухай-402

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр:

Иргэдээс дүүргийн Засаг даргын харъяа, дэргэдэх хэлтэс, албан хаагчдад гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн Засаг даргын нэгдсэн шуурхай зөвлөгөөнд 3 удаа, Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнд 7 удаа, хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөнд 2 удаа танилцуулсан.

Өргөдөл, гомдлын шат дамжлагыг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хэрэгжүүлснээр байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдлын тоо өмнөх оны мөн үеээс 28 хувиар өссөн ч шийдвэрлэлтийн зөрчил 5 (70%)-аар, шийдвэрлэлтийн хугацаа 1 хоног 3 минутаар багассан.

Мөн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан "Ажиллангаа шагнуулъя" уралдааныг Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчдын дунд эхний хагас жилийн хугацаанд зохион байгуулж, өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн болон шийдвэрлэх явцад зөрчил давтан гаргасан Засаг даргын харъяа 9 байгууллага, 1 хороонд мэдэгдэл хүргүүлэх, журмын дагуу хариуцлага тооцох арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд 7 хоног бүр дэргэдэх хэлтсүүдийн үйлчилгээний тоон мэдээг, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтсүүдийн иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн сар бүрийн мэдээг нэгтгэн дүүргийн Статистикийн хэлтсээс эрхлэн гаргадаг "Нийгэм эдийн засгийн танилцуулга" гарын авлагад 5 удаа тус тус нийтлүүлж, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд өргөдөл, гомдлын тайлан мэдээг 7 хоног тутам тогтмол хүргүүлсэн.

Иргэдэд үзүүлсэн буцалтгүй тусламж:

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан "Хан-Уул дүүргийн иргэдэд нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай журам"-ын хүрээнд мөнгөн тусламж хүссэн иргэдийн нөхцөл байдлын үнэлгээ, шаардлагатай баримт бичгийн бүрдэлтийг хянан, хүлээн авч нийт 115 иргэнд 49,100,000 (дөчин есөн сая нэг зуун мянга) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардлагатай арга хэмжээг зохион байгуулсан.


2.8 Байгууллагын үйл ажиллагааны зардал хямдруулах, төсөв хэмнэх чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажил;

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд төсвийн хэмнэлтийн горимд ажиллаж, төлөвлөсөн арга хэмжээг зайлшгүй хэрэгцээ шаардлага үр дүн, ач холбогдлоор нь эрэмбэлэх замаар орон нутгийн төсөвт 7,908,354,200 төгрөг батлагдсанаас 5,476,280,259 төгрөгийн зарцуулалт буюу батлагдсан төсвийн зарцуулалт 69 хувийн гүйцэтгэлтэй, цалин хөлс, байр ашиглалт, хангамжийн материал, томилолт, бараа үйлчилгээний бусад зардлуудаас 31 хувийн хэмнэлт үүсгэсэн.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”

1.1 Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;

Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах чиглэлээр: “Хан-Уул дүүрэг цахим дүүрэг” болох зорилтын хүрээнд дүүргийн албан ёсны www.khanuul.mn/ цахим вэб сайтыг шинэчлэн, иргэд төрийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй шуурхай авах нөхцөлийг бүрдүүллээ. Тухайлбал дүүргийн khanuul.mn цахим вэб сайтад E-Mongolia, Ulaanbaatar.mn, Авилгатай тэмцэх газар зэрэг дээд байгууллагуудын нийт 10 гаруй төрлийн албан ёсны цахим вэб сайтыг холбож, иргэд шууд холбогдон төрийн үйлчилгээг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлсэн.



Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/376 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2024 оны А/126 дугаар захирамжийн дагуу “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутны бүртгэлийг 2024 оны 03 дугаар сарын 01-14-ний өдрүүдэд үндэсний портал сайт “E-Mongolia”-аар бүртгэлийг хүлээн авч, дүүргийн хэмжээнд 5 их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн шаардлага хангасан 108 оюутан, суралцагчид бүртгэж, эрүүл мэндийн үзлэг болон бие бялдрын шалгалтад тэнцсэн 74 оюутныг Үндэсний батлан хамгаалах их сургуульд хүлээлгэн өгсөн.

Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны “Цэргийн бүртгэл явуулах тухай” А/331 дүгээр журмыг удирдлага болгон Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/687 дугаар захирамжаар нийслэлийн хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 01 дүгээр сарын 19-ний өдрүүдэд цэргийн бүртгэлийн ажлыг цахим болон цаасан суурьтай зохион байгуулж, 2023 оны жилийн эцсийн статистик суурин хүн амын тоотой харьцуулахад 93,9 хувь хамруулсан.

Цэргийн бүртгэлийг дүүргийн хүн амын тоо бүртгэлтэй уялдуулан зохион байгуулж, байнгын оршин суугч, оюутнуудыг оршин суугаа хаягаар нь дүүргийн цэргийн бүртгэлийн дүнг 2023 оны жилийн эцсийн хүн амын статистик суурин мэдээтэй харьцуулсан судалгаагаар гаргаж, E-Монголиа портал веб сайттай хамтран зохион байгуулж, 7705 иргэний хүсэлтийг баталгаажуулан ажилласан.

3.2 Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангасан буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн;

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт болон бусад зэрэг <https://shilendans.gov.mn/> цахим хуудсанд 01-11 дугаар сарын байдлаар 145 мэдээллийг байршуулсан.

Мөн <https://khanuul.mn/> сайтын мэдээллийн ил тод байдлын хэсэгт дүүргийн төсөв, санхүүтэй холбоотой бүх мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулсан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ “Бусад мэдээлэл”


4.1 Холбогдох чиг үүргийн хүрээнд шинээр санаачлан хэрэгжүүлсэн болон онцлог ажил, арга хэмжээ;

Иргэд, албан хаагчдын уулзалт, арга хэмжээ

“Улаанбаатар–Бүсчилсэн хөгжил” үзэл баримтлалын хүрээнд МУ-ын Ерөнхий сайд Л.Оюун-эрдэнийн уулзалтыг 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтад Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх болон хороодын нийт 50 албан хаагч оролцсон.



Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчидтай 2024 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр уулзалт зохион байгуулж, уулзалтад тус дүүргийн ЗДТГ-ын 28, дэргэдэх хэлтэс албадын 64, хороодын 120, нийт 212 албан хаагчдыг хамруулсан.



Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1212 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулах журам”-ын хүрээнд дүүргийн Засаг даргын иргэдтэй хийх уулзалтыг 15 удаа зохион байгуулж, нийт 157 иргэнийг хүлээн авч, санал хүсэлтийг шийдвэрлэсэн.




Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд, засаг захиргааны нэгжийн шинэчлэлтийн талаарх бодлогыг төрийн албан хаагчдад танилцуулах 7 удаагийн уулзалтын удирдамж, хөтөлбөрийг боловсруулж зохион байгуулалтыг ханган ажилласан. Дээрх уулзалтуудад нийт 22 байгууллагын 1258 ажилтан, албан хаагч хамрагдсан.



Хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах талаар:


Дэлхийн томоохон хотуудын хэрэгжүүлж буй “20 минутын хотын концепц” болон Монгол Улсын урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Улаанбаатар хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хүн амын төвлөрөл, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, газар зүйн байршлыг үндэслэн Улаанбаатар хотын Засаг захиргааг 14 дүүрэг 42 нэгжид хуваарилан зохион байгуулахаар санал боловсруулсан. Засаг захиргааны шинэчлэлтийг хийснээр нийслэлийн одоогийн чиг үүрэг 58 хувиар буурах бол дүүргийн чиг үүрэг 15 хувь, хорооны чиг үүрэг 95 хувиар тус тус нэмэгдэж чиг үүргийн төвлөрөл буурч, төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх нөхцөл бүрдэнэ.



Тус шинэчлэлтийн хүрээнд Монгол Улсын Их Хуралд “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийг өргөн барьж, 2024 оны 06 дугаар сарын 05-нд батлуулсан.



20 минутын хот үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 06 дугаар тогтоолоор "Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн бэлтгэлийг хангуулах санал, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн төлөвлөгөө шийдвэрийн төсөл, цагалбар боловсруулан ажлын хэсгийн хуралд танилцуулсан.



Эрүүл мэндийн салбарын хүрээнд:

Дүүргийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, үр дүнг сайжруулахын тулд нийгмийн эрүүл мэндийн санаачилгыг хэлэлцэх, нөөц бололцоогоо зохицуулах, төрийн болон эрүүл мэндийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулан дэмжин ажиллах, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын талаарх үр дүнг дүгнэн танилцуулах уулзалтыг 2024 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 286 эмч, эмнэлгийн ажилчдад, 2024 оны 04 дугаар сарын 26-ны өдөр дүүргийн Нэгдсэн эмнэлгийн 160 эмч, эмнэлгийн ажилчдад, 2024 оны 05 дугаар сарын 02, 09, 27-ны өдрүүдэд 3 удаагын уулзалтаар дүүргийн Эрүүл мэндийн төдийн 185 эмч, эмнэлгийн ажилчид, 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Оргил рашаан сувилалын 59 эмч, эмнэлгийн ажилчид, 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Сэргээн засах клиникийн 60 эмч, эмнэлгийн

ажилчдыг оролцуулан зохион байгуулсан. Нийт эрүүл мэндийн байгууллагуудад 8 удаагийн уулзалтыг зохион байгуулж 750 ажилчдыг хамруулсан байна.

2024 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 286 эмч, эмнэлгийн ажилчдын уулзалт.





Хүнсний аюулгүй байдлыг хангуулах ажлын хүрээнд:

Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг чадваржуулах, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх, электрон тамхины хор хөнөөлийн талаар дараах онцлог ажил, арга хэмжээг зохион байгуулж 600 гаруй өсвөр насны сурагчдад хүрч ажилласан. Үүнд:

- 3 удаагийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан
- 324 дэлгүүр, сүлжээ дэлгүүр, худалдааны төвүүдэд зөвлөмж хүргүүлсэн
- 1 удаагийн уралдааныг зохион байгуулсан.




Электрон тамхины хор хөнөөлийн талаар 2 төрлийн постер, мэдээлэл бэлтгэн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүл ийн хөгжил, хамгааллын хэлтэс, Албан бус-Насан туршийн боловсролын төв, Эрүүл мэндийн төвийн цахим хаяг болон Хан-Уул дүүргийн Цагдаагийн газрын цахим хаяг, 25 хороодын цахим хаягт байршуулж, нийтдээ 13000 иргэд олон нийтэд хүрч ажилласан.



Дүүргийн менежерийн 2024 оны 11-р сарын 20-ны өдрийн “Шинэ оныг угтан гэр бүл, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дүүргийнхээ өнгө үзэмжийг нэмэгдүүлэх гэрлэн чимэглэл бүхий орчин бүрдүүлж хамтран ажиллах тухай” 02/2389 дугаар албан бичгийг худалдаа, үйлчилгээний 722 гаруй иргэн, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн.

Ibis style, Мишээл, Carrefour, Зайсан хилл стар, Хаан тауэр, Токио тауэр, Морьтон цогцолбор, Академи гудамж, Маршал таунд үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлчилгээний 52 аж ахуйн нэгж дотоод нөөц бололцоондоо тулгуурлан гэрлэн чимэглэл хийсэн.



--- oOo ---